

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
04 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 127
1. <i>Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.03.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	7 – 95
2. <i>Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	96 – 119
3. <i>Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/</i>	119 – 127

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 17-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 77 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Батбаатар, Ж.Баясгалан, Б.Бейсен, Б.Заяабал, С.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Ч.Анар, Х.Баттулга, Б.Бат-Эрдэнэ, З.Мэндсайхан, П.Наранбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтаншагай, С.Амарсайхан, Л.Энхнасан, Д.Энхтүвшин;

Тасалсан: Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: Т.Аубакир – 47 минут, Ж.Батсуурь – 01 минут, Б.Батцэцэг – 02 минут, Э.Болормаа – 01 минут, Х.Булгантуяа – 02 минут, Г.Ганбаатар – 01 минут, С.Ганбаатар – 09 минут, Д.Ганбат – 04 минут, Ц.Даваасүрэн – 13 минут, Т.Доржханд – 3 цаг 35 минут, Б.Жавхлан – 1 цаг 59 минут, Б.Жаргалан – 05 минут, Ж.Золжаргал – 06 минут, Ц.Мөнхтуяа – 02 минут, М.Нарантуяа-Нара – 12 минут, Н.Номтойбаяр – 08 минут, С.Одонтуяа – 21 минут, Р.Сэддорж – 1 цаг 33 минут, А.Ундраа – 09 минут, Н.Учрал – 04 минут, Г.Уянгахишиг – 1 цаг 54 минут, Б.Хэрлэн – 01 минут, Ж.Чинбүрэн – 17 минут, Б.Чойжилсүрэн – 08 минут.

Нэг.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2025.03.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн, Санхүүгийн зохицуулах хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Мөнх-Оргил, Цөмийн энергийн комиссын Тамгын газрын дарга Б.Баатарцогт, Цөмийн энергийн комиссын Цөмийн технологийн бодлогын

газрын дарга М.Чадраабал, Цөмийн энергийн комиссын Цөмийн аюулгүй байдлын бодлогын газрын дарга Э.Нямдаваа, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Геологи, үйлдвэрлэлийн бодлогын газрын дарга Ц.Төгсбуян, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Нэгдлийн хяналтын асуудал хариуцсан менежер Н.Жавзанпагма, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-ийн Санхүү, удирдлагын газрын дарга Г.Бадрах, “Эрдэнэс критикал минералс” ТӨҮГ-ын Санхүү, эдийн засгийн бодлогын газрын дарга Н.Тэгшжаргал, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, бүртгэлийн газрын захирал С.Ариунсанаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Дэд дарга Ү.Амарбат, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, мөн албаны ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, хуулийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, М.Ганхүлэг, Г.Дамдинням, Ж.Ганбаатар, П.Сайнзориг, Н.Наранбаатар, О.Батнайрамдал, Д.Ганмаа, Л.Мөнхбаясгалан, Х.Баасанжаргал, Д.Батбаяр, Б.Уянга, О.Цогтгэрэл, Ц.Мөнхбат, Д.Батлут, Ш.Бямбасүрэн, Б.Жаргалан, Х.Ганхуяг, Р.Сэддорж, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Л.Мөнхбаясгалан нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаарх санал хураалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Пүрэв гарагт явуулахаар тогтов.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 35 минут үргэлжилж, 13 цаг 35 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 15 цаг 02 минутад эхлэв.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Баярсайхан, мөн албаны ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ж.Алдаржавхлан, Ж.Баярмаа, С.Зулпхар, Ц.Мөнхбат, А.Ганбаатар, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Д.Жаргалсайхан, Ө.Шижир нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн санал хураалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Пүрэв гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 58 минутад хэлэлцэв.

Гурав.Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын референт Г.Нямсүрэн, Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх П.Хулан, Байнгын хороодын ажлын албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ш.Бямбасүрэн нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Л.Соронзонболд нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн санал хураалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Пүрэв гарагт явуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 51 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 109 гишүүн ирж, 86.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 18 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 00 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

77 гишүүн бүртгэгдэж, ирц 61.1 хувьтай байгаа учраас өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

5 асуудал хэлэлцэнэ.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Ж.Алдаржавхлан гишүүн, Ж.Ганбаатар гишүүн сууя. Чуулган эхэлчхээд байна. Улаанбаатар хотод 10 цаг 00 минут өнгөрсөн байна.

Үдээс хойших нэгдсэн хуралдаан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Гуравдугаарт, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Дөрөвдүгээрт, Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцэнэ.

Тавдугаарт, Баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан байна.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нэг.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд хуваарилсан.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд
/Засгийн газар 2025.03.28-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Туваан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээх талаар тусгагдсан.

Үүний хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Их Хурал 2022 онд Уул уурхайн биржийн тухай хуулийг 2024 онд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тус тус баталсан.

Уул уурхайн салбар нь 2024 оны жилийн эцсийн байдлаар

- дотоодын нийт бүтээгдэхүүний 26 хувь,
 - аж үйлдвэрийн салбарын 72 хувь,
 - гадаадын шууд хөрөнгө оруулалтын 81 хувь,
 - экспортын орлогын 94 хувь,
 - төсвийн орлогын 34 хувийг тус тус бүрдүүлсэн.
-

Гадаад худалдааны нийт эргэлт 2025 оны эхний 02 сарын гүйцэтгэлээр 3.7 тэрбум ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 120.4 сая ам.доллараар буурсан байна.

Экспорт импортоос давамгайлж 294.0 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй гарсан боловч экспортын орлого өмнөх оны мөн үеэс 235.4 сая ам.доллараар буурч, 2 тэрбум 4.9 сая долларын гүйцэтгэлтэй байна.

Одоогийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүнийг SPOT FORWARD гэрээний дагуу биржээр дамжуулан арилжиж байгаа бөгөөд 2023 оны 01 сарын 12-ны өдрөөс 2025 оны 03 сарын 14-ний өдрийг хүртэл 43 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг нийт 17.07 их наяд төгрөгөөр арилжаалаад байна.

“Монголын Хөрөнгийн Бирж” хувьцаат компанид бүртгэлтэй уул уурхайн бүтээгдэхүүний худалдагч 21 компани, 471 гэрээ байгуулсан худалдан авагчид бүртгэгдсэн байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаагаар хамгийн их бүтээгдэхүүн арилжаалсан сар нь 2024 оны 04 дүгээр сар бөгөөд нийт 55 удаагийн арилжаагаар 4.2 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 951.5 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Гэсэн хэдий ч дээрх эрх зүйн зохицуулалтуудын хийдэл болон хоорондын уялдаагүй байдлаас үүдэн уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан арилжаалах үйл ажиллагаа зогсонги байдалд орох, биржийн арилжаанд оролцогч аж ахуйн нэгжүүдийн орлогыг хязгаарлах зэрэг сөрөг үр дагаврууд байсаар байгаа нь цаашлаад үндэсний баялгийн санг арвижуулахад бэрхшээл үүсэх эрсдэлтэй байна.

Тухайлбал, уул уурхайн биржийн арилжааны дүнгээс үзэхэд тухайн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж, үнэ өсөх үед арилжаа өссөн бөгөөд 2023 оны 12 дугаар сард нүүрсний үнэ 816 мянган төгрөг хүрэх үед биржийн арилжаагаар 1.9 их наяд төгрөгийн нүүрс арилжсан байна.

2025 оны 2 дугаар сарын байдлаар нүүрсний үнэ 30 хувиар буурч, 568 мянга 800 төгрөг болоход биржийн арилжааны тоо өмнөх оны мөн үеэс 9 дахин буурсан байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны 1 болон 2 дугаар сард нийт 3.9 сая тонн нүүрсийг 1.8 их наяд төгрөгөөр арилжаалж байсан ба тухайн хугацаанд нэг арилжаанд дунджаар 6 худалдан авагчид оролцдог байсан бол 2025 оны 1, 2 дугаар саруудад нийт 428.6 мянган тонн нүүрсийг 122.9 тэрбум төгрөгөөр арилжаалаад байгаа ба нэг арилжаанд дунджаар 1-ээс 2 худалдан авагчид оролцож байгаа нь эрэлт огцом буурсан байгааг илэрхийлж байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн борлуулах энэ хуулийн 10.1-д заасан уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр заавал арилжаална гэж заасан бөгөөд үүнтэй холбоотойгоор төрийн болон орон нутгийн оролцоотой аж ахуйн нэгжүүд нь дотоодын баяжуулах үйлдвэрүүдэд бүтээгдэхүүнээ борлуулах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

Тухайлбал, “Эрдэнэс критикал минералс” төрийн өмчит үйлдвэрийн газар “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХХК-д дараах хүндрэлүүд үүсээд байгаа юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд нь дотоодын аж ахуйн нэгжүүдэд уул уурхайн бүтээгдэхүүнийг арилжаалах эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотойгоор 15-аас 40 хувийн агуулгатай төмрийн 2.5 сая тонн хэмжээтэй, ойролцоогоор 42 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий төмрийн хүдэр, завсрын бүтээгдэхүүний овоолго үүсээд байна.

Өнөөгийн байдлаар төмрийн хүдэр завсрын бүтээгдэхүүн хадгалах, агуулах талбайн дүүргэлт 87 хувьтай байгаа ба цаашид тасралтгүй нэмэгдэж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Эдгээр үйлдвэрүүдэд 2024 онд дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдээс 1.5 сая тонн бүтээгдэхүүнийг худалдан авах захиалга ирсэн байгааг борлуулах эрх зүйн орчин бүрдүүлснээр 33 тэрбум төгрөгийн орлого олж, улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар хураамж нэмэгдэхээр байна.

Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгэгдсэнээр 2025 оны 03 дугаар сарын байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй 49 баяжуулах үйлдвэр бүртгэлтэй байгаагаас нүүрсний 11, төмрийн 19, хайлуур жоншны 19 үйлдвэр байна.

Мөн 2024 онд 27 баяжуулах үйлдвэр, 2025 онд 18 баяжуулах үйлдвэр үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулахаар ирүүлсэн бөгөөд эдгээр үйлдвэрүүд улс, орон нутгийн төсөвт

- ▶ 2022 онд 12.2 тэрбум,
- ▶ 2023 онд 11.7 тэрбум,
- ▶ 2024 онд 2.8 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн нь буурсан үзүүлэлт юм.

Түүнчлэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд биржийн арилжааны үнийг хил залгаа улсын боомтын үнээр зарлана. Мөн биржийн арилжааны явцад талууд биржээс зарласан үнийг зөвшөөрснөөр гэрээний үнэ

тогтоно гэж хатуугаар зохицуулсан нь тус хуулийн 14.2 дахь заалтын үзэл санаатай зөрчилдөж байна.

Тухайлбал, нүүрсний үнэ 2023 оны 07 сарын 01-нээс 2024 оны 01 сарын 01 хүртэл 47 хувь өссөн бол 2024 оны 01 сарын 01-нээс 2025 оны 01 сарын 01 хүртэл 44 хувиар буураад байна.

Энэхүү үнийн уналтаас шалтгаалж биржээр арилжаалагдсан 727.5 сая ам.долларын үнийн дүн бүхий 31 гэрээний 6.83 сая тонн нүүрсний татан авалт хийгдээгүй. Ганцмод боомтын агуулахад 4.3 сая тонн нүүрс хуримтлагдсан байна.

Биржийн FORWARD гэрээний хэрэгжилт нэг хүртэл жил үргэлжилдэг бөгөөд тус хугацаанд үүсэх үнийн хэлбэлзэл нь худалдагч, худалдан авагч аль аль талд эрсдэл үүсгэж байгаа. Үнийг индексжүүлснээр зах зээлийн тусгал илүү бодитой болж талуудад үүсэх эрсдэл буурах боломж бүрдэнэ.

Мөн уул уурхайн биржийн арилжааны худалдааны хөргөлтийн нөхцөлийг зөвхөн хил нөхцөлөөр борлуулахаар хуулиар зохицуулсан нь бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна.

Биржийн арилжааг олон улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршилтай уялдуулж тогтоосноор Тавантолгойн экспортын хэмжээ нэмэгдэж, нүүрсийг дундын зуучлагчдаар дамжихгүй эцсийн хэрэглэгчдэд шууд борлуулах, мөн нүүрсний үнийг Хятадын биржийн тухайн өдрийн үнээр тогтоож, төрөл бүрийн OPTION тохирч борлуулах боломж бүрдэх юм.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төсөл, бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд бүтээгдэхүүн солилцох гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурал шийдвэрлэж болох зохицуулалтыг тусгана.

Ингэснээр агаарын бохирдол, орон сууцжуулалт, түгжрэлийг бууруулах мега төслүүд болон бусад нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой томоохон төслүүдийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Мөн цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх баталгааны хэлэлцээрийн дагуу Монгол Улс цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын мэдээ тайланг олон улсын атомын энергийн агентлагт хүргүүлэх үүрэг хүлээсэн тул уг харилцааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Иймд Уул уурхайн биржийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-нд энэ хуулийн 14.8-д заасан мэдээллийг цөмийн энергийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нэгтгэж хяналт тавина гэж, 14 дүгээр зүйлийн 14.8-д цацраг идэвхт ашигт малтмалын борлуулалтын талаарх мэдээллийг Цөмийн энергийн тухай хуулийн 47.1.1-д заасны дагуу олон улсын атомын энергийн агентлагт хүргүүлнэ гэж тус тус нэмж тусгасан бөгөөд үүнтэй холбогдуулан Цөмийн энергийн газар байгуулах зорилгоор Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Мөн цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Засгийн газрын зөвшөөрлөөр олгохоор тусгахаар тусгасан.

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах, эрдэс баялгийг олон улсын стандартын дагуу ашиглаж борлуулах, түүнээс олох орлогыг үндэсний эдийн засгийн бие даасан байдлыг хангах, олон тулгуурт эдийн засгийг дэмжих хүрээнд Уул уурхайн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцэхээр бэлтгэн танилцуулж байна.

Энэ хуулийн төсөл нь 3 зүйлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай тус тус нийцсэн болно.

Хуулийн төсөлтэй уялдуулан Цөмийн энергийн тухай, Зөвшөөрлийн тухай, Улсын Их Хурлын 2024 оны 13 дугаар тогтоолд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулахаар заагдсан байгаа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн танилцуулна.

Индэрт урьж байна.

Өнөөдөр үдээс өмнөх чуулганы хуралдаан 12 цаг 30 минут хүртэл үргэлжлэхээр байгаа. 150 минутаар хэлэлцэхээр энэ асуудлыг шийдвэрлэсэн байгаа.

Л.Соронзонболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний олборлолт, борлуулалтын бодит нөхцөл байдал болон дэлхий нийтийн чиг хандлага бусад улсын сайн туршлагыг харгалзан Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн чадавхыг сайжруулж, арилжааг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагыг үндэслэн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн үйлчлэх хүрээнд өөрчлөлт оруулж, уул уурхайн бүтээгдэхүүнийг гадаад болон дотоодын зах зээлд биржээр дамжуулан арилжих зохицуулалтыг тусгах, биржээр арилжаалах бүтээгдэхүүний үнийг зах зээлийн үнийн индексийн хөдөлгөөнд тулгуурлан өөрчлөлт оруулах боломжийг бүрдүүлэх, биржийн арилжааны үнийг Олон улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны журамд заасны дагуу зарлах, цацрах идэвхт ашигт малтмалыг биржээр арилжаалсан тохиолдолд борлуулалтын мэдээллийг олон улсын атомын энергийн агентлагт хүргүүлж байх зэрэг зохицуулалтыг тусган хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед

-Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа солилцох гэрээтэй холбоотой зохицуулалтын талаар, мөн цөмийн энергийн агентлаг байгуулах хэрэгцээ шаардлагын талаар,

-Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал нүүрсний чанар болон зах зээлийн үнийн индексийн хөдөлгөөнд тулгуурлан биржээр харилцан гэрээний үнэд өөрчлөлт оруулах зохицуулалтын талаар, мөн нүүрсний борлуулалт, хүргэлтийн нөхцөлийн талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд биржийн арилжааг зохих зохицуулалтын талаар, мөн нүүрсний агуулах болон татан авалтын нөхцөл байдлын талаар,

-Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хуулийн төсөлд туссан бараа солилцох зохицуулалт болон гарч болзошгүй эрсдэлийн талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл биржээ идэвхжүүлэх, олон тоглогчдыг татан оролцуулах өөр боломж байгаа эсэх, мөн нүүрсний борлуулалтын төлөвлөгөөний талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан биржээр нүүрс худалдаж авсан аж ахуйн нэгжүүдийн тээвэрлэлт хийх хугацааны талаар болон 2025 оны нөхцөл байдлыг хэрхэн харж байгаа талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж хөрөнгийн биржээр төрийн өмчийн болон хувийн өмчийн хэдэн компанийн ямар төрлийн бүтээгдэхүүн арилжаалагдаж байгаа талаар, мөн нүүрс тээвэрлэлт, тээвэрчдэд үүсээд байгаа нөхцөл байдлын талаар,

-Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль нь бодлогын түвшинд экспортыг дэмжиж чадаж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

-Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд зах зээлийн нөхцөл байдалд уялдуулан зохицуулалт хийх нь зүйтэй бөгөөд худалдааны нөхцөлүүдээ анхаарах талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд хэлэлцүүлгийн явцад төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг засаж сайжруулах талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан уул уурхайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвараа сайжруулж, бараа солилцооны нөхцөлөөс татгалзах талаар,

-Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал хуулийн өөрчлөлтөөр бүх асуудлаа шийдэх биш биржийн арилжаанд менежментийн шинэчлэл хийх шаардлагатай талаар,

-Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулах, бараа солилцооны зохицуулалтыг анхаарах, мөн биржийн менежментээ сайжруулах, тээвэр, логистикийн эрсдэлийг худалдан авагч, тээвэрлэгч компаниуд хариуцах чиглэлээр бодлогоо барьж нүүрсний үнэ өндөр байгаа мөчийг үр бүтээлтэй ашиглах талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан бараа солилцооны зохицуулалтыг тусгах нь зүйтэй талаар,

-Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж арилжааны багц томдож байгаа асуудалд анхаарах, мөн тээврийг сонголттой болгох нь зүйтэй бөгөөд хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаа талаар тус тус санал хэлсэн болно.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх

дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчид нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асуухаар байгаа.

Тэгээд өнөөдөр энэ хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэсний дараа Эдийн засгийн байнгын хорооноос ажлын хэсэг гаргаж ажиллах ийм чигтэй явж байгаа.

Ер нь биржийн тухай хуулийг батлаад удаагүй байгаа. Хэрэгжилт нь мэдээж эхэлж байгаа зүйл учраас доголдол байхыг үгүйсгэхгүй. Засаж сайжруулах зүйл олон байхыг үгүйсгэхгүй.

Гэхдээ Улсын Их Хурал дээр энэ асуудлыг маш олон талаас нь ярилцаж байж батлах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа. Улсын Их Хурлын гишүүд тийм байр суурьтай байгаа гэж ойлгосон.

Ингээд дарааллын дагуу Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Уул уурхайн бирж зөв явах ёстой.

Ер нь боломж нь байгаа. Энэ биржээр борлуулах нь маш зөв юм. Гэвч энэ биржээр худалдаж авч байгаа нөхдүүд нь ямарваа нэгэн танил талгүй тийм нөхдүүд биржийн худалдаанд оролцоод нүүрсээ авдаг.

Гэвч яагаад юм нь явахгүй байна вэ гэхээр “Эрдэнэс Тавантолгой” дээр очоод биржээр нүүрсээ авсан нөхдүүд очоод гэрээ хийхээр нэг сар, хоёр сар болдог байхгүй юу даа.

Тэгээд энэ хугацаанд өөрөөр хэлбэл нүүрс өсөж байгаа үед нөгөө хүмүүс хүлээж болно.

Гэтэл нүүрс үнэ нь унаж байгаа үед хоёр сар хүлээнэ гэдэг чинь нөгөө биржээр үнээ төлөөд худалдаад авчихсан тэр компаниудын хувьд маш том асуудал болж байгаа байхгүй юу даа.

Тэгээд энэ нь санаатай хийгддэг. Яагаад гэвэл дарга нар, Улсын Их Хурлын гишүүд, сайд нар яадаг вэ гэхээр “Эрдэнэс Тавантолгой” дээр очоод 500 мянган тонн, сая тонны гэрээг 3 доллар, 2 долларын зөрүү авч байгаад хийдэг. Тэр нүүрс нь бүгдээрээ түрүүлж гардаг.

Тийм учраас энэ нөгөө биржээр нүүрс авч байгаа тэр хүмүүсийн асуудал нь явахгүй, ачилт нь хийгдэхгүй ийм л юм болоод байгаа юм.

Тэгээд ер нь одоо ингээд харж байхад яавал нүүрсийг алт шиг үнэтэй болгох вэ гэдэг ийм л луйвар тэр “Эрдэнэс Тавантолгой” дээр бүрэн явж байгаа. Яагаад тэр биржээр нүүрс худалдаж авсан хүмүүсийн урдуур нүүрс гараад байна гэхээр 4500 калоритой нүүрсний гэрээ хийчхээд, үнийг нь төлчхөөд буцаагаад 6 мянган калоритой нүүрс ачдаг тэр нөхдүүдийн авлигад төлөгдсөн тэр нүүрс нь л түрүүлж гардаг байхгүй юу даа.

Тийм учраас энэ дээр асуудал үүсээд байгаа. Тэгээд яавал нүүрсийг алт шиг үнэтэй болгох вэ гэдэг ийм л, ерөөсөө өнөөдөр тэр “Эрдэнэс Тавантолгой” дээр явж байгаа. Жишээ нь, уурхайгаас төмөр замын ам хүртэл 14-хөн километр газарт 1 сая 78 мянган төгрөгөөр тээвэр хийж байна. 14-хөн километр газарт.

Дээрээс нь төмөр замаар хил дээр аваачиж буулгаад төмөр замаасаа хил хүргэхэд 4-хөн километр газарт 1 сая 800 мянган төгрөгөөр тээвэр хийж байна.

Тэгээд үүнийг хоёр, гуравхан компани хийдэг. Дандаа дарга нарын компани. Ингэж явах юм бол, замд нь нүүрсийг бүгдийг нь, Монголын ард түмэнд ирэх ёстой тэр бүх ашгийг бүгдийг нь тэнд хулгайлдаг байх юм бол яаж “Эрдэнэс Тавантолгой”-гоос бид ашиг олж чадах юм бэ.

Дөнгөж 93-хан мянган төгрөгийн дивиденд ашиг өгч байгаа. Тэр хамгийн багадаа 1 сая төгрөг болох. Тэнд ямарваа нэгэн асуудалгүй биржээрээ худалдаа хийгээд асуудалгүй тээвэр нь гардаг байх юм бол хамгийн багадаа сая төгрөг өгөх боломж байж байгаа шүү дээ.

Энэ болгоныг замд нь иддэг ийм тогтолцоог бүрдүүлчихсэн учраас өнөөдөр биржийн юм чинь явахгүй байгаа юм. Тэгээд энэ биржийн асуудлаа зохицуулахаас өмнө тэр “Эрдэнэс Тавантолгой” дахь авлига, хулгай тэр бүх зүйлээ зохицуул. Түүний дараа үүнийгээ ярьцгаа.

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд тээвэртэй холбоотой асуудлаар нэг хариулт тайлбар, нэгдсэн ойлголт өгөх нь зүйтэй байна.

Хоёрдугаарт, энэ дээр “Эрдэнэс Тавантолгой”-н захирлын үүрэг гүйцэтгэгч ирсэн байж байна. Бас нэг асуулт асууя.

Тэр Бортээгийн орд гэдэг ордын лиценз хэний эзэмшилд байдаг юм бэ? Хэвлэлээр намайг эзэмшдэг гэж яваад байх юм. Тэр талаар “Эрдэнэс Тавантолгой” компани нэг тайлбар өгөөч. Би тийм орд эзэмшдэгээ мэдэхгүй юм.

Б.Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Ер нь 13 километр газар ийм үнээр зөөж байна, дарга нарын компани зөөж байна гэдэг юм байхгүй.

Тэр дарга нарын компани гэдэг юм чинь чухам цаанаа хэн байдаг гэдгийг нь хууль хяналтын байгууллага тогтоох байх. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ чинь Тавантолгой компани өөрөө сонгон шалгаруулалт хийгээд л шалгарсан компани зөөж байгаа. Үнийн хувьд эргэж харах юм бий.

Гэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 сарын 19-ний 103 дугаар Засгийн газрын тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам ашиглахтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол гарсан.

Энд төрийн өмчийн аж ахуйн нэгжийн зардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, төмөр замын тээврийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар авч ажиллуулах арга хэмжээний тогтоол гарсан учраас үүнтэй холбогдуулаад зардлыг бууруулах дээр онцгой анхаарч байгаа.

Тэгээд энэ дээр Тавантолгой компанитайгаа хамтран ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Зарим нэг буруу зөрүү ойлголт байгаа юм байна шүү гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон өгье.

Х.Мөнхжаргал: Эрхэм гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе.

“Эрдэнэс Тавантолгой” компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал.

Улсын Их Хурлын даргын асуусан асуултад хариулья.

“Эрдэнэс Тавантолгой”-н ордын нэг болох Бортээгийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь одоо “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн өөрийн эзэмшлийн тийм хувьцаа байгаа.

Тус талбайд ерөнхийдөө ТЭЗҮ хийгдсэн. Ашиглалтын үйл ажиллагаа одоогоор эхлээгүй байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуулт асууя.

М.Ганхүлэг: Уул уурхайн биржийн тухай хуультай холбогдолтой асуудал дээр нэлээн нухацтай хандах нь зөв өө.

Яг асуулт асууж эхлээгүй байхад ах нар маань жоохон сандраад шууд мэдэгдлүүд хийгээд эхэлж байх шиг байна.

2022 оны 12 сард батлагдсан энэхүү хуулийн тодорхой үр дүнгээр нүүрсний хулгайн асуудал, нүүрсний экспортын асуудлуудыг нэлээн ил тод болгохтой холбогдолтой.

Үүний үр дүнд биржээр арилжаасны зөрүү гэж 1.3 их наяд төгрөгийн орлогыг Монгол Улс олсон. Энэ нь бүтэн жилийн хугацаанд сар бүр 100 мянган төгрөгийг бид хүүхдүүддээ өгөх ийм хэмжээний мөнгө.

Энэ хуулийн ажлын хэсгийг ахалж ажилласан одоогийн Их Хурлын гишүүн байгаа манай Ж.Ганбаатар сайд, О.Батнайрамдал гишүүдэд би талархал илэрхийлье гэж бодож байгаа.

Олон мянган залуучууд нүүрсний хулгайн эсрэг жагсаал хийж, бодитоор гарсан үр дүнгүүдийн нэг нь яах вэ энэ. Үүний цаана маш олон асуудлууд өнөөдрийг хүртэл асуултын тэмдэгтэй байгаа.

Хуулийн үндсэн нэмэлт, өөрчлөлттэй холбогдолтой хэд хэдэн асуудлуудыг тодруулах зайлшгүй шаардлагууд байна.

Биржийн хуультай болсноос хойш ер нь аль болох л биржээр худалдаалахгүй байх гэдэг сонирхол маш ихээр цухалздаг болсон. Энэ үнэн. Өнөөдөр орж ирж байгаа биржээр заавал арилжаалах нөхцөлөөс ухарсан бас нэг заалтыг би илүү тодруулж асуумаар байна. Энэ 10.3 дээр бүтээгдэхүүн солилцох буюу нүүрсээрээ бартердах эрхийг хуучин зөвхөн хил дамнасан төмөр замтай холбогдолтой төсөл дээр хийнэ гэдэг ийм агуулга байсан. Өнөөдрийн

орж ирж байгаа төслөөр үндсэндээ томоохон төслүүд энэ агуулгаар, биржийн бус байдлаар, бартераар хэлцэл хийгдэх ийм байдал орж ирж байна.

Тэгэхээр бид бүхэн ил тод байх тухай яриад байгаа. Хэний ямар төслүүд ямар байдлаар орж болох вэ гэдэг ийм нээлттэй байдлаар хуульчилж өгөх нь зөв юм уу гэсэн байна. Түүний цаана ямар нэгэн томоохон төслийн явуулж байгаа хүмүүсийн лобби, ашиг сонирхол бас агуулагдах вий дээ гэдэг ийм хардлага байна.

Үүнийг бид маш нухацтай ярих ёстой.

Хоёр дахь нь ам үнэтэй холбогдолтой, хил үнэтэй холбогдолтой асуудлыг бид бүхэн байнга ярьдаг. Яг үнэндээ нүүрсний хулгайн асуудал бол нүүрс экспорт гэхээсээ илүүтэй тээврийн асуудал тэр чигтээ байсныг нь бид бүхэн харсан.

Тийм учраас дахиад энэ тээврийн асуудлыг хоёр үнийн зөрүүнөөс гаргаж ирдэг энэ байдлыг бий болгох оролдлого үүний цаана байгаад байгаа юм биш үү. Үүнтэй холбогдолтой тодорхой агуулгууд орж ирж байна.

Дээрээс нь тээврийн компаниудын тодорхой сонирхол үүний цаана байх вий дээ гэдэг ийм хардлага байна.

Тэгэхээр үүнийг Их Хурлын гишүүд, Байнгын хороо, цаашдын асуудлууд дээр хэлэлцэх дээрээ нэлээн нягтлах ёстой.

Аль болох нэг үнээр хил дээрээсээ бид бүхэн худалдаалах гэсэн энэ зорилгоо үндсэндээ хангасан энэ байдлаасаа бид ухарч болохгүй гэж хэлэх гээд байна.

Хоёр дахь нь энэхүү нэмэлт, өөрчлөлтийн гол агуулгын хүрээнд биржийн үнэд бүтээгдэхүүний чанар болон зах зээлийн үнийн индексийн хөдөлгөөнд тулгуурлан өөрчлөлт оруулах тухай асуудал яригдаж байна.

Нэгэнт хэлцэл хийгдсэн үнэд өөрчлөлт оруулахдаа чанарыг үндэслэнэ гэсэн агуулгын цаана хэн чанарыг тогтоох вэ? Тодорхой хэлцэл хийгдсэн үнийг буулгах оролдлого бас үүний цаана явах вий гэдэг ийм хардлагууд байна.

Тэгэхээр нэлээн олон энэ асуудлуудыг тал талаас нь хэдүүлээ ярилцаж байж, өмнөх хуулиасаа ухралгүйгээр илүү ил тод байх энэ хувилбаруудыг сонгоод явах нь зөв байна гэдгийг асууж тодруулмаар байна.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан сайд энэ дээр одоо ер нь Засгийн газар нэг зүйл дээр анхаарахгүй бол яаралтай горим гэдэг нэрийн доор олон хуулийн төсөл өргөн бариад байна.

Тэгээд өргөн баригдсан хуулийн төслүүд нь дандаа хэл ам дагуулж байна. Одоо энэ Байнгын хороод дээр жишээ нь өчигдөр өнгөрсөн хоёр өдрийн тухайд хэлэлцэгдээд, хуулийн төсөл дээр шүүмжлэлтэй хандаж байгаа байдал энд асуудал дагуулж байгаа нь тодорхой, илэрхий байна шүү дээ.

Жишээлбэл, Зөвшөөрлийн тухай хуулийг дагалдуулаад Эрүүгийн хуульд оруулах өөрчлөлтийн төсөл өргөн барьсан байна гэдэг шүүмжлэлийг өчигдөр хуульч гишүүдийн зүгээс гаргасан. Над дээр бас орж ирж тэдгээр гишүүд асуудал тавьсан. Өргөн барьж байгаа хуулийн төслийн бүрдэл хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар дээр нягталдаг.

Тэгээд нягталсан асуудлаараа жишээлбэл Зөвшөөрлийн тухай хуулийг хэлэлцэх үүрэг нь, чиг үүрэг нь Эдийн засгийн байнгын хороонд хуваарилаад явуулдаг.

Гэтэл хамт өргөн мэдүүлсэн хууль нь Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал орж ирээд, Мэргэжлийн байнгын хороо буюу Хууль зүйн байнгын хороогоор энэ хуулийн төслийг хэлэлцүүлэхгүйгээр шийдвэрлэх асуудал яригдаж байгаа нь өөрөө учир дутагдалтай байна гэж асуудал яригдаад эхэлж байгаа юм.

Тэгэхээр Их Хурлын зүгээс энэ яаралтай горимоор өргөн барьж байгаа хуулийн төслүүдийг авахгүй байх зарчим барья гэхээр цаг үеийн шинжтэй байна гэдэг асуудлыг Засгийн газраас дандаа учир шалтгаан тоочдог.

Тэгээд нөгөө хуулийн төслийг нь авчхаад хэлэлцүүлье гэхээр асуудлууд үүсээд. Ингээд цаг хугацааны хувьд удаашрах нөхцөл үүсээд байгаа юм.

Тэгээд үүнийг л Та бүхэн маань нягтлахгүй болохоор Улсын Их Хурлын гишүүд хуулийн төсөл болгон дээр ийм асуудлыг ярина. Тэгээд ийм хуулиудыг чинь оруулж ирж хэлэлцүүлье гэхээр асуудал үүсээд байгаа учраас удаах шалтгаан гараад байгаа гэдгийг бас ойлгох хэрэгтэй.

Одоо энэ хууль жишээ нь өргөн баригдсанаас хойш бараг гурван долоо хоногийн дараа хэлэлцүүлэг рүү орж ирж байгаа биз. Тэгээд өөрөө энэ чинь нягтлах, судлах, хэлэлцүүлэг явуулах зайлшгүй шаардлагууд үүсчхээд байгаа байхгүй юу. Ядаж л энэ оролцогч талуудын санал, онолыг ерөөсөө аваагүйгээр орж ирж байгаа шүү дээ. Олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийхгүйгээр ороод ирж байгаа. Хариулт өгье.

Ц.Туваан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Х.Ганхуяг гишүүний асуултад хариулъя.

Тийм. Биржийн зарагдсан үнээс 1.3 их наяд төгрөгийн зөрүү буюу Монголын талдаа нэмэх орлого олсон. Энэ бол бас биржийн хуулийн давуу тал.

Бид бүхэн Биржийн тухай хуулиа цаашдаа мөрдөөд хэрэгжүүлээд явна, сайжруулаад явна гэдгийг хэлье.

Өмнө нь ажлын хэсгийн ахлагчаар ажилласан О.Батнайрамдал болон салбарыг тэргүүлж ажиллаж байсан Ж.Ганбаатар сайд нартаа бас талархаж байгаагаа энэ ташрамд хэлье. Энэ хууль цаашдаа хэрэгжээд явна.

10.3 дээр нэг заалт хийсэн байгаа. Энэ төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төсөл, бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал зөвшөөрвөл энэ асуудлыг шийдэж болохоор оруулж ирж байгаа.

Бид үүнийг бодож хийсэн юм. Юу гэхээр орон нутгуудад уулзалт, бүсийн чуулган, Их Хурлын гишүүд дээр ирж байгаа ч гэсэн асуудал. Энэ нийгмийн буюу сургууль, цэцэрлэг, эмнэлэгтэй холбоотой асуудал. Дэд бүтцийн буюу 14 мега төсөл, зам барилгатай холбоотой маш их зүйлийг хийгээч ээ гэдэг ийм саналууд ирж байгаа юм.

Тэгэхээр үүнийг бид хийх санхүүгийн боломж өнөөдөр алга байна. Төсвөөрөө шийдэх боломжгүй. Дээрээс нь гадаад орчин нөхцөл байдал ямар байгаа билээ. Гаднын хөрөнгө оруулалт энэ тэр ч гэсэн бас оруулж ирэх ийм боломжгүй байгаа.

Тэгэхээр энэ дээр ерөнхийдөө бүтээгдэхүүнээ солилцох буюу тэнд шууд бэлэн валютыг төлж гаднаас бүтээгдэхүүн оруулж ирж бүтээн байгуулалт хийх биш, бидэнд өөрсдөдөө байгаа боломжоо Их Хурал нь шийдэж өгөх юм бол хийж болно гэсэн ийм зүйл, заалт орж байгаа.

Тэгэхээр өнөөдрийн Монгол Улсын валютын нөөц 5.2 тэрбум доллартой байгаа.

Тэгэхээр одоо бүтээн байгуулалтын сар эхлэхээр энэ импорт их явах, барилгын салбарын импорт явах дээр валютын нөөц багасах ийм эрсдэл байгаа.

Тэгэхээр бид боломжоороо солилцох ийм заалтыг оруулж ирсэн гэдгийг хэлье.

Яг таны хэлж байгаагаар бид жоохон муухайгаар “ам” гээд яриад сурсан.

Ер нь олон улсын биржийн хууль, зохицуулалтад ч байдаг. Тээвэртэй, тээвэргүй үнэ. Энэ сонголттой л болгож өгч байгаа юм. Одоо бол бид биржээрээ бараа, бүтээгдэхүүнээ заавал арилжиж байгаа. Дээрээс нь хил нөхцөлөөр, ганцхан нөхцөл тулгасан байгаа. Тэгээд энэ нөхцөл нь өөрөө дотоодын баяжуулах үйлдвэрүүдийг авах боломжийг нэгдүгээрт хаагаад байна.

Хоёрдугаарт, хүмүүс биржээр зарагдсан бүтээгдэхүүн маш удаан хугацаанд эзэндээ очоод байна гэж ярьж байгаа.

Тэгэхээр тухайн худалдаж авсан хүн өөрөө тээврээ сонгоод, хэдий хугацаанд авах нь тухайн худалдан авагчдад боломжийг нээж өгөх гэдэг энэ агуулгаар бас энэ заалт, сонголтыг оруулж өгсөн гэдгийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: М.Ганхүлэг гишүүний асуултад ажлын хэсгээс нэмж хариулт өгье. Хэн хариулт өгөх билээ? Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Г.Намчинсүрэн. Гишүүний асуултад нэмж тайлбар өгье.

Тээврийн асуудал дээр нүүрсний тээврийг олон улсын худалдааны танхимаас зарласан буюу нөхцөл зарлахаар сонголттой байдлаар шийдвэрлэхээр хуулийн төсөлд тусгасан.

Энэ маань нэгдүгээрт тээвэргүй нөхцөл. Мөн цаашлаад “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрсийг бүр Хятадын гүн рүү оруулж борлуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор энэ асуудлыг тусгасан байгаа.

Сонголт нь ямар байх вэ гэдгийг Засгийн газар тухай бүрд нь шийдвэрлээд явахаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулж асууя.

М.Ганхүлэг: Чанарын асуудлыг хэн тогтоох вэ гэдгийг нэмж хариулья.

Ц.Туваан сайд аа, 10.3 дээр чинь ингэсэн байхгүй юу даа. “Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Их Хурал шийдвэрлэж болно” гээд оруулсан байгаа. “Шийдвэрлэхгүй ч байж болно” гэдэг ийм хоёрдмол утга энэ дээр чинь яваад байна.

Таны хэлж байгаа нийгмийн төслүүдийг дэмжиж байгаа. Тэгэхдээ нийгмийн бус, бас одоо ингээд үндсэндээ нэлээн ашиг сонирхол бүхий төслүүдийг ч дэмжиж болох ийм агуулга яваад байна л даа.

Тэгэхээр нөгөө ил тод байя, илүү тодорхой байя. Өмнө нь зөвхөн төмөр замын бүтээн байгуулалтыг л бид бүхэн зөвшөөрсөн байсан бол одоо ингээд бүгдийг нь оруулж ирэх чинь цаашдаа олон асуудлыг дагуулах гээд байна гэдэг ийм санааг хэлээд байна.

Одоо тодорхой тэр тээврийн үнэтэй холбогдолтой асуудал дээр энэ чинь ухарсан алхам мөн шүү дээ. Бид хил дээрээ үнээ тогтоодог байсан энэ асуудлаа бариад менежментийн хувьд тэр хугацаа алдаад байгаа асуудал дээрээ зохион байгуулалт хийгээд явах л ёстой ийм л агуулга байхад юун цаашаа орох. Энэ наашлуулах ийм шийдвэрийг бид бүхэн яриад байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуудал энэ том бүтээн байгуулалтын асуудлыг Монгол Улс шийдье. Энэ дэд бүтцээ бид шийдэхгүй, төсвийн мөнгө хүрэлцэхгүйгээс болоод өнөөдрийг болтол энэ бүх л аймгуудад зам барих, энэ олон том төслүүд, Улаанбаатар хотын түгжрэл гээд асуудлуудтай холбоотой энэ заалт орж ирж байгаа гэдгийг би зориуд хэлье гэж бодож байгаа юм. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энд ямар нэгэн нуугдмал зүйл байхгүй. Ийм төсөлд нүүрсээр солилцоо хийнэ гэдэг юмыг Засгийн газар дангаараа шийдэхгүй. Үүнийг Засгийн газар Улсын Их Хуралдаа оруулж ирж өргөн бариад шийдвэрлүүлнэ гэж байгаа байхгүй юу.

Түүнээс биш Засгийн газар бие даагаад шийднэ гэдэг юм байхгүй гэдгийг Та үүнийг зөв ойлгоорой гэж хэлье.

Хоёрдугаарт, тээврийн асуудал дээр “ам нөхцөл” гэдгийг яагаад оруулж байгаа юм гэхээр бид маш олон худалдан авагч нарт зарж байгаа болохоор.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Энэ олон худалдан авагч нарт зэрэг зарж байгаагаас болж нэгдүгээрт зарим нь аман дээрээсээ авъя. Бид өөрсдөө хурдан түргэн нүүрсээ авч борлуулмаар байна. Цаг хугацааны хувьд мөнгөө урьдчилаад 100 хувь төлсөн байдаг. Тэгээд нүүрсээ цагтаа авч чадахгүйдээ бухимдаад. Үүнээс болоод дараагийн худалдан авагч нар орж ирэхгүй байгаа учраас.

Ер нь Тавантолгойн үүрэг юу гэхээр мөнгөө авсан л бол нүүрсийг нь амнаасаа авна уу, хил дээрээ авна уу. Энэ бол өөрийнх нь асуудал гэж орхихгүй бол эргээд бид худалдан авагч нараа алдаад байгаа юм. Хугацаанд нь өгч чадахгүйгээсээ болоод.

Тийм учраас энэ дээр Зам тээврийн яам онцгой анхаараад бүх төрлийн тээврээр зэрэг ачих дээр Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу ажиллаж байгаа гэдгийг М.Ганхүлэг гишүүнд зориуд хэлье.

Түүнээс биш энэ бол бид ямар нэгэн байдлаар үнэ бууруулах гэсэндээ энэ “ам нөхцөл”-өөр гэж оруулаад байгаа юм биш шүү. Олон худалдан авагчид аль болох л.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болсон уу? М.Ганхүлэг гишүүн. Чанарын асуудал дээр ажлын хэсгийн 11 дүгээр микрофон. Хөрөнгийн биржийн захирал Б.Дөлгөөн хариулт өгье.

Б.Дөлгөөн: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хөрөнгийн биржийн захирал Б.Дөлгөөн байна. М.Ганхүлэг гишүүний асуултад хариулъя.

Чанартай холбоотой асуудал яах аргагүй олон улсад бид ямар байдгийг судалж үзсэн. Тэгээд олон улсын биржүүд дээр гэрээг тодорхой интервал дотор жишээлбэл хүхрийн тэдээс тэдийн хооронд байх ёстой гээд стандарт заагаад өгсөн ийм гэрээнүүдийг арилждаг.

Тэгээд олон улсад ямар туршлага байна вэ гэхээр хэмжээнээсээ хэтэрсэн, нэмэгдсэн, эсвэл буурсан нөхцөлд үнэ тэдээр өснө, үнэ тэдээр буурна гэдэг нарийн зохицуулалтуудыг оруулж өгсөн байдаг.

Тийм учраас энэ утгаараа чанарын асуудлыг оруулж өгч байгаа.

Тэгээд мэдээж үүнийг гуравдагч этгээд буюу олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн лабораториор бид хийлгэхээр энэ тал дээр ажлын хэсэг ажиллаад бирж дээр явж байгаа гэдгийг дуулгахад таатай байна.

Д.Амарбаясгалан: Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууя.

Г.Дамдинням: Одоо тэгээд хашир хүн гэж хаширсан хүнийг хэлдэг юм даа л гэж нэг үг санаанд ороод байх юм даа.

Нүүрсний хулгайгаа ярьж ярьж өнгөрсөн парламент арай гэж нэг юм дууссан. Гол асуудал OFFTAKE дээр л байсан шүү дээ.

Тэгээд одоо энэ биржийн хуулийн өөрчлөлт зүгээр муу нуухаар сайн илчил. Анэ дахиад нэг OFFTAKE л байхгүй юу. Нэрийг нь хэлэх хэрэгтэй.

Бид алдагдалгүй төсөв Засгийн газарт батлаад өгсөн учраас энэ хүмүүс чинь бас нэг ажил хийх гээд аргаа бараад явж байгаа нь бас нэг гарц хайгаад байх шиг байгаа юм. Тухайн үед ярьж л байсан.

Гэхдээ хэдэн асуулт байгаа юм. Өмнө нь бид зөвхөн нүүрс дээр OFFTAKE хийхийг зөвшөөрөөд, тэгээд зөвхөн төмөр замд зарцуулахыг нь зөвшөөрсний дараа ямар ямар сул талууд гарч ирсэн бэ гэхээр нэгдүгээрт хувийн хэвшил хийдэг үнээс гурав, дөрөв дахин үнэтэй хийдэг төмөр замтай болсон. 1 километрийнх нь үнэ. Энэ бол хулгай. Хамгийн том хулгай. Хийсэн хүмүүс нь ч мэдэж байгаа. Яригдана. Нэг л өдөр.

Хоёрдугаар асуудал OFFTAKE хийсэн компанийн нүүрс л хилээр гараад, шинээр мөнгө оруулж ирдэг, эдийн засаг руу нийлүүлдэг борлуулалт нь бас байхгүй болсон. Тэгээд долларын нөөц буураад, валютын нөөц, буураад ханш өсөөд, ханшаа алдангаа алдаад нэг баларсан шүү дээ.

Тийм учраас биржийн хууль гарсан байхгүй юу. Нүүрсний өндөр байгаа үе дээр. OFFTAKE-ийн нүүрс л хилээр гардаг. Бусад нь гардаггүй ийм л нөхцөл рүү орсон байсан юм шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ яаж хамгаалах юм бэ? Одоо ингээд бид энэ хуулийг батлаад өгөх юм бол өмнө нь хэлж байна шүү дээ. Зөвхөн нүүрс дээр байсан бүх бүтээгдэхүүн дээр. Төмөр дээр, зэс дээр. Одоо манайхаас гардаг бүх бүтээгдэхүүн дээр OFFTAKE хийхийг зөвшөөрч байна л гэсэн үг.

Тэр өмнөх алдаанаасаа бид ер нь юу сурсан юм, яаж сэргийлж болж байгаа юм.

Тэгээд одоо ямар аргачлалаар үнэлэх юм, хэн хийх юм. Тэгээд салбарын яам нь санал болгоод Засгийн газраар оруулаад гэрээндээ тусгаад тэгээд Их Хурлаар оруулна гэсэн ийм л хууль байгаа байхгүй юу.

Тэгээд би түрүүн хэлж байна шүү дээ. Хаширчхаад байна. Хаширчхаад байна. Ний нуугүй л хэл. Засгийн газрууд, энэ ажлын хэсэг.

Ц.Туваан сайд энэ чинь OFFTAKE шүү дээ. Бодитой байхгүй юу. Өмнөх алдаанаасаа бид юу сурсан юм. Би түрүүн хэллээ шүү дээ. Зүгээр захаас аваад хэлэхэд үнэ нь өөр. Хувийн хэвшил хийж байгаагаас хэд дахин өөр үнэтэй. Тэр нь дандаа дээшээ. Нэг ширхэг талх “Атар өргөө”-гийн талх билүү, юу билээ. 25 мянган төгрөгөөр өгч байсан гээд манай зарим Их Хурлын гишүүд энэ чуулганы танхимд ярьж байсан шүү дээ. Ийм шахааны юм руу л явах вий дээ л гэж айж байгаа байхгүй юу.

Түүнээс биш Засгийн газар ажил хийх гээд байгаа юмыг ойлгоод байна. Тэгэхээр өмнө нь гарч байсан энэ алдаа дутагдлуудаа энэ хуулиараа та нар яаж

засаж байгаа юм? Том хэмжээний OFFTAKE гэрээ компаниудтай хийх гэж байгаа юм байна. Яаж шалгаруулах юм? Бас нэг шалгаруулалт байх ёстой байлгүй дээ. Дэлхий дээр ганцхан компани хийнэ гэж байхгүй шүү дээ.

Тэгэхээр үүнийгээ яаж тусгаж байгаа юм. Хаширсан учраас л асуугаад байна. Та нарын ажилд саад болох гээд байгаа юм алга. Тэгээд тодруулна.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Г.Дамдинням гишүүн маш чухал асуудал ярьж байгаа.

Ер нь концепцын хувьд дэмжиж байгаад нь баярлалаа. Бид бас аргагүйдээд байгаа. Яг үнэндээ хэлэхэд.

Ард иргэдийн зүгээс чуулганд, Их Хурлын гишүүд та бүхэнд ч гэсэн бүсүүдээс ирж байгаа саналууд дээр бүтээн байгуулалт л яриад байгаа.

Замтай больё. Говийн бүсийнхэн устай больё. Тэгээд л төмөр зам тавья. Нийгмийн шинжтэй хот байгуулъя, цэцэрлэг, сургуулиудыг иж бүрнээр нь олноор нь шийдье гээд.

Тэгэхээр энэ дээр Засгийн газарт яг ний нуугүй хэлэхэд өөр гаргалгаа байхгүй. Төсвөөр шийддэг арга байхгүй. Төсөв алдагдалгүй болсон. Тэгээд батлагдсан.

Дээрээс нь **“Трамп тариф”**-аас болоод гадаад орчинд хөрөнгө оруулалт хийх явдал хумигдсан, мөнгө үнэтэй болсон яг энэ цаг үед бид валютаараа худалдаж авч гадагшаа валютаа гаргаад тэндээс бэлэн бүтээгдэхүүн худалдаж авч ирж бүтээн байгуулалт хийх биш өөрсдөдөө байгаа юмаараа л солилцъё гэдэг ийм логик явж байгаа.

Яг зүйтэй. Таны хэлж байгаа. Энэ дээр мэдээж бүтээн байгуулалтыг Засгийн газар дээрээ Их Хурлын гишүүд ч гэсэн саналаа өгнө. Эндээ ямар хэмжээний бүтээн байгуулалтыг эрэмбээр нь дараалуулж байгаад хамгийн нэг номерын эрэмбэтэй асуудлуудыг. Жишээлбэл, бүсүүд дээр ч юм уу энэ асуудлыг нь гаргаж ирээд, тэгээд түүнийхээ мэдээж хийх объёмоо тохирно, мөнгөн дүнгээ тохирно.

Түүндээ өгөх бүтээгдэхүүнээ. Одоо энэ чинь ганцхан нүүрс ч биш. Төрийн өмчийн оролцоотой компаниудын эзэмшиж байгаа бүтээгдэхүүнүүд. Нэмж ч гэсэн бид бас бүтээгдэхүүн олборлох, хайгуулаар олох гэсэн энэ зүйлүүд утга дотор явж байгаа.

Тэндээс гарч байгаа бүтээгдэхүүнээ дахиад л хил гааль дээрээ үнэлнэ. Одоо жишээлбэл, өнөөдөр манай дээр 4 том гэрээ “Эрдэнэс Тавантолгой”-гоос

гараад явж байгаа шиг эд нар бүгдээрээ үнэтэй, мэдээлэлтэй. Тэгээд л тэр бүтээн байгуулалтын үнээсээ хасагдах журмаар явна.

Яаж шалгаруулах дээрээ бид одоо энэ хууль батлагдвал дараагаар нь энэ асуудлаа нээлттэй журмын хүрээнд ярьж шийдвэрлэх юм гэдгийг хэлье.

Төмөр зам дээр манай Б.Дэлгэрсайхан сайд нэмээд хариулъя.

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Баярлалаа. Г.Дамдинням гишүүний асуултад хариулъя.

Ер нь таны ярьж байгаатай санал нэг байгаа. Ер нь төмөр замын бүтээн байгуулалтууд яах вэ, өмнө нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар шийдээд явдаг байсныг харин ч бид Улсын Их Хурал руу оруулж ирж шийдүүлж байгаа нь олны анхааралд авч ирж байгаа. Бүх гишүүдийн санал бодлыг оруулж, тэгээд Их Хурлын анхааралд оруулж ирж байгаагаараа бас давуу талтай гэдгийг та зөв ойлгоорой.

Түүнээс биш өмнө нь хэн нь юу ууж идсэн, тэр нь ямар үнэтэй уусан гэдэг талаар би аудит биш болохоор мэдэхгүй байна.

Гэхдээ сая Ц.Туваан сайдын хэлдгээр бид үнэхээр том бүтээн байгуулалтыг хийе гэж байгаа л бол ингэж хийхээс өөр арга байхгүй. Цаашдаа бид дэлхий нийтийн геополитикийн асуудал ямар болохыг өнөөдөр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Бид байтугай бусад улс орнууд ч тааж мэдэхгүй байна.

Тийм учраас тодорхойгүй нөхцөлд хэдүүлээ маш тодорхой шийдвэр гаргаад, тэгээд цаашаа яваад, энэ бүтээн байгуулалт энэ тэрээ хийхгүй бол улс орон маань нүүрс зарахыг хүлээгээд, нүүрсээр хэдэн төгрөг төсөвт ороод, тэр төсвөө хэдүүлээ сургууль, цэцэрлэг, зам гэж хуваарилсаар байтал цаг хугацаа байхгүй болж байгаа юм.

Цаг хугацааг хэмнэж байгаа л нэг арга юм. Гэхдээ Улсын Их Хурлын анхааралд оруулж ирээд Улсын Их Хурлаараа бид ийм зам тавих юм, үүнийгээ ийм өртгөөр тавих гэж байгаа юм, ингэж шийднэ гэдэг ийм шийдвэр авч байж энэ төсөл, хөтөлбөр цаашаа явах юм.

Түүнээс биш дур зоргоороо Засгийн газар ганц нэг сайд гарын үсэг зураад үүнийг шийдээд явах зүйл биш шүү. Өөрчлөлт орж байгаа, шинэчлэл орж байгаа гэдгийг зөв талаас нь олж хараарай гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гонгорын Дамдинням гишүүн тодруулж асууя.

Г.Дамдинням: Сайд нараас би түрүүн асуугаад байна шүү дээ.

Нүүрсний хулгайгаас авсан сургамжаа яаж засаж орж ирж байгаа юм бэ л гээд байгаа байхгүй юу. Би түрүүн бүр тодорхой хэллээ шүү дээ. OFFTAKE гэрээгээр хийсэн бараанууд л хилээр битүү гардаг. Улсын сан руу орж ирдэг борлуулалт нь орж ирэхгүй байснаас болоод бид ханшаа алдаж баларч байсан тохиолдол байсан учраас бид энэ хуулийг гаргасан.

Үүнийгээ яаж сэргийлж байгаа юм? Та нар. Дагасан хуулиуд чинь байгаа юу? Нэг.

Хоёрдугаарт, бүх бүтээгдэхүүнүүд дээрээ нээгээд хаялаа. Өмнө нь нүүрсний хулгай гэж улс даяараа ер нь нурчингаа алдаж байж одоо нэг юм дуусаж байгаа юман дээрээ сургамжууд ер нь юу авсан юм бэ? Түүн дээрээ хэлээд өгөөч ээ гэхээр Та нар өөрсдийнхөө таатай асуултад л хариулаад яваад байна л даа. Яах вэ та нарын ажлыг дэмжих гээд байгаа санаа нь.

Тэгээд хулгайд дахиад өртөөд битгий өлгөгдөөд явчхаасай л гэж хэлээд байгаа юм та нарт.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Тэр OFFTAKE-ээр гэрээ хийгдсэн нүүрс түрүүлж гарч байгаа гэдэг юм бол таны хэлж байгаатай санал нэг байгаа. Өмнө нь ийм байсан.

Тийм учраас үүнийг Засгийн газар олж хараад тэгээд ганц Тавантолгой үүнийг шийдэж болохгүй юм байна. Тавантолгой ерөөсөө тээвэрлэлттэйгээ, борлуулалттайгаа, олборлолттойгоо бүх юмаараа нэг юман дээр аваачаад зангидаад байхаар хулгай зэлгий нь ганц давуу эрхээр OFFTAKE-ийн нүүрс гараад байна гэдэгтэй би санал нэг байна.

Тийм учраас Засгийн газар энэ дээр ямар арга хэмжээ авч байгаа вэ гэхээр нүүрс олборлодог, ачдаг нь Тавантолгой үүнийгээ хий. Тээвэрлэдэг ажлыг нь Зам, тээврийн яам хий. Салгаад аль аль нь хяналттай болгох үүднээс үүнийг ингэж шийдэж өгч байгаа юм шүү.

Цаашдаа OFFTAKE-ийн нүүрс түрүүлж гарна гэсэн ойлголт байхгүй. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газраас барьж байгаа бодлого юуны өмнө.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн асуулт асууя.

Ж.Ганбаатар: Биржийн тухай хуулийн гол амин сүнс нь Ц.Туваан сайд аа, Б.Дэлгэрсайхан сайд аа.

Биржийн тухай хуулийн чинь гол амин сүнс нь энэ төрийн өмчит компаниуд нийтийн баялгийг олборлоод гадагшаа гаргаж байгаа бол заавал биржээр ил тод, шударга өрсөлдөөний дүнд зах зээлийн үнэд хүргэж борлуулна л гэсэн ийм зарчимтай шүү дээ.

Зарчим чинь ерөөсөө хуулийн өөрчлөлтөд огт байхгүй. Тийм болохоор хуулийг дэмжих ямар ч боломжгүй байна л даа. Энэ бүх зарчмаасаа хууль чинь буцаж байна. Энэ хуулийн өөрчлөлт чинь.

Тэгээд Ц.Туваан сайдын хариултыг сонсохоор Ц.Туваан сайд салбарын сайдын байр сууриас салбараа бас нэг жоохон бодож хариулахгүй бол зүгээр нэг яах вэ Эдийн засгийн сайдын хэмжээнд ч юм уу хариулах гээд байна л даа.

Тэгэхээр энэ салбар чинь өөрөө цаашаа хөгжих ёстой.

Тэгээд би тэр 10.3, одоо тэр М.Ганхүлэг гишүүний ярьж байгаа тэр 10.3, мөн тэр биржийн дундаж үнэ, бусад бүх заалтууд дээр эсрэг байр суурьтай байна.

Өнөөдөр бид нүүрсээ биржээр үнэтэй зарсан мөнгөөр л амьдарч байгаа шүү дээ. Өнөөдөр. Тэр Монголбанканд байгаа тэр 4 тэрбум доллар, 5 тэрбум доллар гээд байгаа чинь бид биржээр үнэтэй нүүрсээ зарсны хүчинд л олсон мөнгө. Тэр хувь, хувьсгал компаниудын мөнгө нийлээд л дээ. Яг бодитоороо тэнд хэдэн доллар байгаа юм. Мэдэхгүй.

Тэгэхээр би энэ биржийн тухай хуулийн өөрчлөлтийг огт дэмжихгүй байна.

Ажлын хэсэг байгуулаад ч гэсэн нэг их сайжрахгүй гэж би бодож байна. Сая зарим гишүүдийн хэлж байгаа тэр ухралт болно. OFFTAKE гэрээ. Үнэн үнэн. Сайхан юм бодоод хийдэг. Ер нь хүмүүс нэг сайхан юм бодоод хийдэг. Амьдрал өөрөө тэрийг хөгжүүлдэг шүү дээ. Сайхан юмны чинь цаана авлига л хөгжүүлдэг байхгүй юу. Сайхан бодоод юм хийдэг. Тэр чинь тэгээд хүний тэр зан чанартай нийцэхгүй. Уг чанартай нийцэхгүй наадах чинь тэгээд л хүнд суртал, авлига болоод л хувирдаг. Үүнээс л холдуулж энэ хуулийг баталсан.

Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлт ерөөсөө энэ. Ингэж сэглэж байсны оронд энэ хууль. Би бол хэрэггүй дээ. Биржийн тухай хуульгүй явсан нь дээр юм байна гэж бодож байна.

Эсвэл хуулиа хэвээр нь үлдээх хэрэгтэй, эсвэл шинэ хуулиа гаргах юм бол одоо энэ бирж гэж ойлголт байхгүй. Цааш нь сайжруулна гэдгийг би огт ойлгохгүй байна. Юуг сайжруулах гээд байгаа гэдгийг ойлгохгүй байна.

Би танд хэллээ шүү дээ. Саяын олборлоод ил тод, нээлттэй, зах зээлийн үнээр борлуулах ёстой гэдэг энэ гурван үндэс чинь бүгдээрээ байхгүй байна. Гурвууланг нь өөрчилж байна. Тэгээд энэ бол ер нь Биржийн тухай хуульгүй л болсон нь дээр юм байна л даа.

Тийм учраас энэ хуулийг дэмжихгүй байгаагаа хэлье. Тэр ажлын хэсгийг нь харин ахална гэвэл яадаг юм бол. Эсвэл орж ажилладаг юм уу гэсэн тийм бодолтой л байна.

Энэ 2025 оны эхний 3 сар хэчнээн тонн нүүрс биржээр зарсан юм? 2024 онтой харьцуулаад нэг яриадах даа. 2025 оны эхний 3 сар. Мэдээлэл нь олдохгүй юм. Өгөөч гэхээр өгөхгүй байна. Байхгүй байгаад байгаа юм байлгүй дээ.

Тэгээд яагаад зэсийг зарахгүй байгааг би бас ойлгохгүй байна. Яагаад зэсээ зарахгүй байгаа юм. Үнэтэй байгаад байна шүү дээ. Зэс чинь үнэтэй байгаа шүү дээ. Тэгээд яагаад зарахгүй байгаа юм. Зэсээ биржээр яагаад зарахгүй байгаа юм. Үнэтэй болно гэдэг чинь эрэлт нь өсөөд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Ж.Ганбаатар сайдад баярлалаа. Тэгээд асуултад нь хариулъя.

Та санаа зовж хэлж байгааг ойлгож байна. Өмнө нь бас энэ салбарыг удирдаж байсан хүний хувиар. Дээрээс нь Уул уурхайн биржийн тухай хуулийг гол санаачилж батлуулсан хүний нэг учраас бас санаа зовж байгааг ойлгож байна.

Гол амин сүнсүүд бол энэ хууль дотор хэвээрээ байгаа. Бид сайжруулна. Биржийн тухай хуулийг зүйлчлэлийг нь цогцоох юм уу, байхгүй болгох асуудал огт яригдахгүй. Цлам цааш нь сайжруулаад төгөлдөршүүлээд явна. Амьдрал өөрөө баян учраас бас шинэ нөхцөл байдлууд, бид дээр нэлээн ийм сорилтууд орж ирээд байгаа юм.

Тэгэхээр энэ хуулиа зайлшгүй оруулж ирж энэ гацааг, энэ хүндрэлтэй нөхцөлөөс гарах гэж Засгийн газар оруулж ирж байгаа.

Экспортыг нэмэгдүүлэх зорилготой том ажлын хэсэг Б.Жавхлан сайдаар ахлуулаад ажиллаж байгаа. Энэ ажлын хэсэг дээр ч гэсэн энэ асуудлыг бас нэлээн нухацтай ярьж байгаа гэдгийг хэлье.

13 дугаар заалт дээр бид түрүүн хэлсэн учраас нэмээд хэлэхэд бид валютынхаа нөөцийг гаргаж, валютаа зарж бүтээгдэхүүн оруулах биш, өөрсдөд байгаа зүйлээрээ солилцоо хийж яагаад болохгүй гэж. Энэ угаасаа дэлхийд байдаг л зарчим. Маш олон улсуудад энэ зарчмаар бүтээн байгуулалтад яваад Монголоос бид нараас хол тасраад явчхаж байгаа юм.

Тэгэхээр бид бүхэн иргэдийгээ ажлын байртай байлгах, орлоготой байлгах, бүтээн байгуулалтаа зогсоохгүй явуулах гэдэг үүднээс л Засгийн газар арга чарга хайж энэ асуудлыг оруулж ирж байгаа.

Тэгэхээр ажлын хэсэг байгуулагдвал таныг ахлаад юм уу, дотор нь ороод ажиллаад хэдүүлээ энэ асуудлаа яриад гарц гаргалгаагаа хамтдаа гаргаад явъя гэж хүсэх байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Бирж. Б.Дөлгөөн захиралд хариулт өгье. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон.

Б.Дөлгөөн: Ж.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

- 2024 оны 04 сарын 11-ний байдлаар 7 сая 123 мянган тонн арилжаалагдсан.
- 2025 оны 04 сарын 11-ний байдлаар 1 сая 254 мянган тонн нүүрс арилжаалагдсан.

Зэсийн хувьд би Эрдэнэт үйлдвэрийн гүйцэтгэх захиралтай уулзсан. Тэгээд энэ жил 60 мянган тонн зэсийг Хөрөнгийн биржээр зарна гэсэн төлөвлөгөөтэй явж байгаа юм билээ.

Сард 5 мянган тонны арилжааны санал, хүсэлтийг бид нарт өгдөг.

Одоогийн байдлаар 5 мянган тонн арилжаалагдсан. 10 мянган тонн амжилтгүй болсон. Нийт 15 мянган тонны арилжааны хүсэлтийг хөрөнгийн биржид хүргүүлж, Хөрөнгийн биржээр орж дуудлага худалдаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон.

Б.Дөлгөөн: Тэгээд зэсийн хувьд энэ жил төлөвлөгөө ёсоор 60 мянган тонн арилжаална гэсэн хүлээлттэй байна. Сар болгон 5 мянган тоннын хүсэлт ирж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жамбалын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Ж.Ганбаатар: Ц.Туваан сайд аа, ярих цаг бага учраас энд ингээд би саяын ярьсан заалтуудаа ингээд 5 гол үндэслэлийг нь бичсэн байгаа юм. Танд өгье.

Наад хууль чинь Биржийн тухай хууль гэж биш болсон. Сайжруулах үндэслэл байхгүй. Би салбар луу дайраад байхыг хүсдэггүй юм шүү. Өөрийнхөө ажиллаж байсан салбар луугаа. Гэхдээ хэлэхээс өөр арга алга.

Энэ Биржийн тухай хууль биш. Үүнийгээ зүгээр хүчингүй болго. Хэрвээ ингэж өөрчлөлт оруулаад сэглэсний оронд энэ хууль байхын хэрэг ач холбогдол байхгүй.

Нүүрс дээр хэлэхэд, “Эрдэнэс Тавантолгой”-нхонд хэлэхэд наад 5 мянган тонн гээд байгаа зэсийг чинь өмнөх Засгийн газар зарсан шүү дээ. Тэрийг хэлээд байх шиг байна даа. Түүнээс хойш зэс зараагүй. Үнэтэй байхад нь заруулаач. Хуулиа баримтлаач. Тэгээд 7 сая тонн нүүрс зарж байсан. 1-хэн сая тонн нүүрс зарчхаад тэгээд хуулиа биелүүлээч. Энэ хууль чинь өнөөдөр хүчин төгөлдөр байгаа биз дээ. Байхгүй юм уу? Одоо өөрчлөх гэж байгаа юм байгаа биз. Эсвэл өөрчилсөн одоо хуулиа батлуулах гээд байгаа юм уу? Хуулиа баримталдаггүй юм уу? Чадахгүй бол тэгээд болиоч.

Хууль биелүүлж чадахгүй бол ажиллах боломжгүй биз дээ. Уг нь. Тэгээд 7 сая тонн нүүрс зарж байсан. 1 саяыг зарсан гээд баатарлаг хариулаад байх юм. Хууль чинь хүчин төгөлдөр байгаа биз дээ? Тэгээд хуулиа биелүүлж ажилладаггүй юм уу?

Засгийн газар хамгийн нэгдүгээрт хууль биелүүлэх ёстой юм биз дээ. Иргэд, аж ахуйн нэгжүүдийг уриалаад.

Хамгийн нэгдүгээрт нь урд нь гараад хамгийн нэгдүгээрт хууль биелүүлэх ёстой газар биз дээ. Тэгээд хуулиа биелүлдэггүй юм уу? Яагаад 7 сая тонн нүүрс зарж байхад 1-хэн сая тонн нүүрс зарчхаад тэгээд өнөөдөр ийм баатарлаг яриад байгаа юм. Тэгээд хаачсан юм? Үлдсэн нүүрсүүд нь хаачсан юм?

Эсвэл энэ чинь ерөөсөө тэр хуульгүй явсан юм бол энэ хуулийг одоо яриад яах гээд байгаа юм. Маш ойлгомжгүй байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе.

Уул уурхайн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгэхдээ ажлын хэсэг гаргаж нэлээн нухацтай үзэхгүй бол болохгүй байна.

Ер нь өргөн барих, боловсруулахаасаа эхлээд ерөөсөө асуудлууд маш хүнд байна. Энэ гурван тусдаа үзэл баримтлалтай орж ирэх асуудлуудыг аваачаад Уул уурхайн биржийн хуулийг дагаад оруулаад ирлээ.

Уул уурхайн биржийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаад энэ дотор нь энэ хуулийн зохицуулалтад ерөөсөө хамааралгүй VALUE EXCHANGE буюу “баялгийн солилцоо”-г оруулаад ирж байгаа байхгүй юу. Энэ чинь биржтэй холбоотой ямар ч харилцаа яваагүй байгаа шүү дээ.

Үүнийг би зарчмын хувьд дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ өөрөө эргээд энэ хуулийн асуудал биш. Аль хууль дээрээ байх юм. Нарийн процессыг нь оруулж ирмээр байна.

“Гуя дагуулж хүзүү” гэгчээр ч юм уу нэг юмыг ингээд бөөнд нь түлхээд, “нэг аргална даа” гэдэг нэг ийм сайхан концепц явж байна. “Хүчлээд гарна даа” гэдэг нэг ийм.

“Энэ хэдэн шинэковууд зүгээр ээ, батална аа” гэдэг ийм юм яриад байгаа байхгүй юу. Одоо үүнийг Засгийн газрын түвшиндээ Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны хууль зүйн техник энэ тэрийг бариулах юм уу, бариулахгүй юм уу. Эсвэл ингээд хууль батлахыг бүгдийг нь чихэж оруулж ирээд ерөөсөө ингээд нэг бөөндөх ёстой юм уу. Би мэдэхгүй байна л даа.

Тийм зүйл баймааргүй байна.

Дээрээс нь энэ дээр байна шүү дээ. Цөмийн энергийн хуулийг дагаад агентлаг байгуулж байгаа юм. Бид хэд уул уурхайн биржийн асуудал ярьж байдаг. Халхавчид нь агентлаг байгуулах гэж байгаа шүү. Хэрэгтэй байж магадгүй. Үүнийгээ Ерөнхий сайдын бүрэн эрхийн хүрээнд байдаг учраас тусдаа үзэл баримтлалыг нь боловсруулаад оруулаад л ир л дээ. Яагаад ингээд яваад байдаг юм бэ? Өргөн барихаасаа эхлээд ингээд гурван өөр харилцааг өргөн бариулчхаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээрээсээ анхаармаар байна.

Төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Тэгээд VALUE EXCHANGE гэдэг зүйл энэ хуулийн хүрээнд огтоосоо хамааралгүй зүйл ороод иржээ.

Үүнийгээ уг нь Засгийн газар тусдаа аль хууль дээрээ байх ёстой юм. Үүнийг бодож байгаад оруулж ирэх ёстой шүү гэдэг зүйлийг хэлмээр байна.

Тэгээд энэ Уул уурхайн биржийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 14.6 дээр бүтээгдэхүүний чанараас хамаараад индексийн хөдөлгөөнд тулгуурлан үнэд өөрчлөлт оруулна гэж байгаа юм.

Чанарын асуудлыг урд хөрш маань шийддэг юм. Чанар дээрээ том босго тавиад Монголын нүүрс бүгд объектоороо унана. Ийм ноцтой юмыг худалдан авагч талын гарт өгч оруулж ирж байгааг би ерөөсөө ойлгохгүй байна.

Ганцмод-Гашуунсухайтын хэлэлцээр дээр хүртэл үүнийг анхааруулсан. Үүнийг дагаад 3 хэлэлцээр байгуулъя. Энд тусаж байгаа гэсэн. Би одоо бүр итгэхээ байж байна шүү.

Энэ Х.Нямбаатар засагт Хууль зүй, дотоод хэргийн сайдаар ахлуулж байхад овоо хэлэлцээр хийсэн байсан. Энэ ингээд бүр Ганцмод-Гашуунсухайт дээр цөм үсрээд түүнээсээ дордсон юм баталсан. Одоо тэгээд том эрх ашгийнх нь төлөө ингээд явахаас өөр аргагүй гээд.

Тэгтэл одо Биржийн хуулиар үнийг шууд өөрсдөө зохиомлоор унагаагаад, нүүрсний экспортын объём ихсэх тусам үнээрээ ингэж бид хэд өөрөө хавхандаа орох гэж байна. Ингэж болж байгаа юм уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, уул уурхайн компанийг бид хэд тээврийн компани болгосон. Энэ тээвэр дээрээ санаа зовдог. Өнөөдөр Уул уурхайн компани өндөр ханштай байхад нүүрсээ зараад ашиг орлогоо аваад бандан тас байх байсан чинь тээвэрлэлтийг нь өөрсдөө уул уурхайн компанийг хий гэдэг байдлаар явсанаасаа болоод цаад талын нөгөө Хятадын талбайн эздийн хүсэл сонирхол гэх юм уу, зүгээр л Хятад дахь Ганцмод дахь нүүрс ачиж буулгах талбайн эздийн, тэрийг ажиллуулж байгаа хүмүүсийн бодлогын жижигхэн юугаар Монгол Улсын эдийн засаг тэр чигтээ хохирч байгаа байхгүй юу.

Юу вэ гэхээр НАБТ^[нүүрс ачиж, буулгах талбай]-ЫН талбай дүүрсэн учраас ачилт байхгүй. Таталт байхгүй учраас худалдан авалт хийсэн ч гэсэн үүнийгээ татаж авах боломжгүй байна. Чингэлэг ачааг явуулах бололцоогүй байна гэдэг байдлаар явахаар 140 доллароор зарсан нүүрс чинь 90 дээр очоод одоо тохируулга хийх гээд байж байна шүү дээ.

Үүний зөрүү 50 долларын алдагдлыг уул уурхайн компани, Монгол Улсын төсөв үүрэх гэж байна. Энэ чинь тэгээд зөв байсан юм уу?

Тэгээд би Ц.Туваан сайдад ганцхан хэлээд байгаа шүү дээ. Үнэнээ хэлье. Үнэнээ хэлэх шиг сайхан юм байхгүй.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

VALUE EXCHANGE буюу энэ бүтээгдэхүүн солилцооны асуудлыг агуулгаар нь дэмжиж байгаад баярлалаа.

Дээрээс нь энэ өөрөө Их Хурлын бүрэн эрх. Одоо хэлэлцэх эсэхээ хэдүүлээ шийдвэрлээд, тэгээд ажлын хэсэг дээрээ ярилцаад, зарчмын зөрүүтэй санал оруулаад, зөв заалт оруулаад солиод батлаад сайжруулаад явах эрх нь Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүдэд байгаа.

Чанартай холбоотой асуудал дээр тантай 100 хувь санал нэг байна. Бид хэд бас энэ дээр ярьсан. Түрүүн манай биржийнхэн хариулж байна лээ.

Ер нь олон улс дээр биржийн үнэ, үнэлгээ мэдээж чанартай уялдаж тогтдог. Өнөөдрийн бид нарын энэ нөхцөл байдал, энэ үнэ индексжүүлэх, дээшээ доошоо индексжүүлэх асуудал нүүрсний борлуулалт татан авалттай холбоотой үүсээд байгаа юм.

Тэгэхээр чанартай холбоотой асуудлыг хэлэлцүүлгийн шатад ажлын хэсэг дээр ярилцаад өөрчлөх боломж байгаа гэдгийг танд хэлье.

Энэ яаралтайгаар оруулж ирж байгаагийн бас нэг асуудал бол мэдээж бүгдээрээ л мэдэж байгаа. Нүүрсний үнэ “Трамп тариф”-тай холбоотой, дэлхийд үүссэн худалдааны дайнтай холбоотой тодорхойгүй нөхцөл байдлаар орлого тасалдах, борлуулалт байхгүй болох эрсдэл үүссэн. Үүнийг бид зохицуулах зорилготой энэ асуудлыг оруулж ирж байгаа.

Бид өмнө нь наана Цагаан хадан дээр 14, 15 сая тонн нүүрсний овоолго үүсдэг байсан бол одоо энэ овоолго хилийн цаана Ганцмод боомт дээр үүсчээд байгаа. Үнэн. Энд Зэлтэрийн гацаа шиг гацаа үүсчээд байгаа нь үнэн.

Тэгэхээр үүнийг гаргаад нүүрсээ бид биржээрээ зарсан үнээрээ борлуулъя гэхээр нөгөө тал буулгаж авах. Таны хэлээд байгаа талбай алга гэдэг шалтгаан хэлж байгаа.

Хоёрдугаарт, Монгол Улсын “Эрдэнэс Тавантолгой” компанид өнөөдөр ямар нэгэн чингэлэг байхгүй. Тэнд нүүрс бууж хоосон чингэлгүүд Монгол Улс руу орж ирж байж тэр лүү нүүрс ачигдаж борлуулагдах юм.

Тэгэхээр үүн дээр бас ийм гацаа байгаа юм. Гацааг арилгах зорилгоор үнийг индексжүүл гэдэг асуудал ярьж байгаа. Чанартай холбоотой асуудал дээр таны асуудлыг ажлын хэсэг дээрээ хэдүүлээ яриад зөв голдиролд нь оруулаад явах боломж байгаа гэж хариулъя.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Тэгээд зарчмаараа л хэдүүлээ явмаар байна.

Зарчмаа ярьж чадахгүй болохоороо бие биедээ сонин нүүрсний хулгай гэж ч юм уу, ингээд тогтоод яг үндсэн зарчим руугаа орохгүй. Сүүлдээ Монгол

Улсын эдийн засгийг бүхэлд нь ерөөсөө Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголд байгаа НАБТ_[нүүрс ачиж, буулгах талбай]-ын эздийн та гарт өгсөн шүү дээ. Энэ биржийн хуулиар.

Уул уурхайн компани тээврийн асуудал дээрээ санаа зовно гэдэг бол тэнэг байхгүй юу. Тэгээд өнөөдөр жишээ нь маш хурдтай маневрлаж болох байсан. Өнөөдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсад байгаа НАБТ-ын талбай чинь хоногоор мөнгө нь, тоолуур нь гүйдэг.

Гэтэл манай Цагаан хад дахь НАБТ-ын талбай чинь буулгаад ачих хүртлээ уг нь авч байсан байхгүй юу. Тэгээд бид хэд энэ Цагаан хад дээр юм буулгахгүй гэсээр байгаад сүүлдээ Хятадын НАБТ-ын талбайн бодлого л, одоо тэндээс татан авалт хийхгүй бол Монгол Улсын эдийн засаг зогсох байдал руу оруулчихаад. Ийм сонин юман дээр эдийн засгаа хоёрхон жилийн хугацаанд зүгээр НАБТ-ын талбай, эздийн гарт өгчхөөд одоо ингээд шогшроод их сүртэй гоё юм байсан юм гээд яриад байгаа байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд энэ дээр хариулт өгье.

Тэгээд ер нь энэ өөрөө Монгол Улсын эдийн засагт шууд нөлөө үзүүлдэг маш том асуудлыг бид ярилцаж байгаа.

Тэгээд өнгөц байдлаар баахан хулгай зэлгий яриад л, улс төрчид нь улс төр хийгээд өнгөрдөг байдлыг бид энэ танхим дотор хийж болохгүй ээ. Ялангуяа энэ өөрөө яг “тээвэрлэлт”, “олборлолт”, “борлуулалттай” холбоотой том тогтолцооны асуудлыг яриад байж байгаа үе дээр. Магадгүй тэр газар дээр нь ажилладаг, уурхай ажиллуулдаг, тээвэр хийдэг дотоодын компаниудтай энэ асуудлаар хэрхэн яаж ярилцсан, санал бодлыг нь сонссон бэ гэдэг асуудал маш их чухал асуудал шүү.

Түүнээс биш энд орж ирээд цагаан захтай баахан нөхдүүд мэдэмхийрч урдуур нь орж асуудал яриад, шийдвэр гаргадаг. Яг газар дээрээ ямар доголдол үүсэх вэ гэдгийг мэдэхгүйгээр шийдвэр гаргадаг асуудал үүсдэг шүү.

Тэгээд баахан худлаа үнэн хулгай зэлгий ярьдаг, мэдэмхийрдэг. Тэгээд өнөөдөр үүссэн асуудлыг зөвхөн өнөөдөрт нь бодож зохицуулах гэж асуудал ярьж байгаа нь бас их зохимжгүй байдал байдаг.

Тэгэхээр Ц.Туваан сайд энэ дээр их тодорхой хариулт өгье.

Ц.Туваан: Тодорхой хариулъя.

Энэ хуулийн өөрчлөлтөд “тээвэртэй”, “тээвэргүй” гэдэг зүйлийг оруулж ирж байгаа.

14.1 дээр “биржийн арилжааны үнийг олон улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршилтай уялдуулан тогтооно.” гэж албан ёсны хэллэг оруулж ирж байгаа.

Энэ бол “тээвэртэй”, “тээвэргүй” сонголтыг бий болгож байгаа.

Түрүүний таны хэлсэнтэй санал нэг байна. Уул уурхайн компани дээр тээвэр ямар хамаатай юм бэ гэж. Энэ хууль батлагдвал яг ийм болно. Өөрөөр хэлбэл уурхай олборлоод гаргаад ирнэ. Түүнийг биржээр худалдаж авсан компани өөрөө тэр тэмээндээ ачна уу, чингэлэгтээ хийнэ үү аваачаад Цагаан хадандаа буулгана уу, цаашаа аваад явна уу гэдэг худалдан авсан компанийн асуудал болох учраас бид ийм байдлаар энэ асуудлыг оруулж ирсэн.

Дээрээс нь тэндээс тээвэрлүүлэх компани маань тээвэрчдээ өөрсдөө сонгоод дотоодын тээврээр, ямар тээврээр ашиглахаа сонголтыг бий болгож байгаа ийм л зүйл байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн дахин тодруулж асууя.

П.Сайнзориг: Тэгээд би ер нь тэгээд хэлэлцүүлгийн явцад дэмжигдсэн тохиолдолд 16.3 дахь заалтыг анхаарна биз дээ.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр дамжуулан дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүд ажиллах журмыг бас дахиад журамлана гэж байгаа юм.

Бид хэд ерөөсөө бизнес явуулахгүй нь ээ. Нэг журамладаг. Тэгээд эцсийн дүндээ хил, гаалийн нэвтрүүлэх чадал, дээрээс нь үүний хяналт. Тэнд байсан дата жишээ нь устсан юм шүү. Энэ буруутнуудыг уул уурхайн компаниудад үүрүүлж болохгүй. Тэд нарт нэмэлт зардал үүсгэх байдлаар асуудлыг шийдэж байгаа мэтээр жүжиглэж болохгүй.

Тэгээд ерөөсөө нэг ийм улс төржүүлээд сэдвийг бие бие рүүгээ баахан займчуулдаг. Энэ зүйлээсээ татгалзаад одоо яг бодит үнэнээ яриад ийм нөхцөлүүд байж байгаа юм. Жишээ нь, гааль дээр тэр камержуулалт, тэр бүх юмаа шийдэх ёстой шүү дээ. Бүхэл бүтэн улсын эдийн засгийг авч явдаг боомт нь бараг л камергүй байсан шүү дээ. Тийм л биз дээ.

Энэ зүйлүүдээ ярихгүйгээр уул уурхайн компаниудыг дэгээдэж унагаадгаа болих хэрэгтэй байна.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд нэмэлт хариулт өгье.

Ц.Туваан: 16.3 дээр ярьж байна.

Энэ дээр биржийн арилжаан дээр нэг асуудал байсан нь юу гэхээр дотоодын компаниуд худалдан авах дээр нэлээн тийм сөрөг байдал үүсээд байсан. Ялангуяа энэ баяжуулах үйлдвэрүүд. Энэ хууль дотор цахилгаан, дулааны станцуудын нүүрс. Тодорхой хэлэх юм бол Багануур, Шивээ-Овоо, Шарын голын нүүрсийг дулааны станцуудад оруулах бол тэртээ тэргүй энэ хуульд ороогүй гадна байгаа.

Тэгэхээр энэ хууль батлагдсанаар юу болох вэ гэхээр дотоодын баяжуулах үйлдвэрүүд тэр бага агуулгатай хүдрийг аваад экспортлох зорилгоор дотооддоо баяжуулаад гаргахыг нь дэмжье л гэж байгаа юм.

Мэдээж энэ чинь уурхай дээр дан өндөр агуулгатай хүдэр байхгүй. Бага агуулгатай хүдэр ч гэсэн гардаг. Үүнийг бид хувийнхаа баяжуулах үйлдвэрүүдэд зараад нэмэлт үйлдвэрлэл хийгээд борлуулах асуудлыг нь л энэ заалтаар оруулж ирж байгаа.

Тэгээд Засгийн газар дээр журамлаад явсан нь одоохондоо зөв харагдаж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Журамлаад явсан нь одоохондоо зөв харагдаж байгаа л гэж байна. Журам гэдэг зүйлээс татгалзах зорилгыг төр тавьж байгаа шүү дээ.

Журам бол ерөөсөө л авлига, хүнд суртал. Хуулиар эрх олгосон гэж журам батална гэж оруулж ирж батлуулчхаад хуулиасаа давсан эрхийг хэрэгжүүлэх гээд журам батлаад албан тушаалтнууд ажиллаад байгаа шүү дээ.

Үүний чинь эсрэг зогссоноо гээд Улсын Их Хурал нь зорилго тавьж, стратеги тавьж ажиллаад байдаг. Тэгээд оруулж ирж байгаа хуулийн төсөл дээр журам боловсруулна гэдэг эрхийг, Улсын Их Хурлаар батлагдах ёстой эрхийг геологийн алба авах гээд сууж байна шүү дээ. Энэ чинь л буруу.

Ц.Туваан сайд аа, битгий залхуур л даа. Нарийвчилсан зохицуулалтаа хуульдаа тусгаад, хэн нэгэн хүнд суртал, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэхээс нь сэргийлэх зорилгыг тавиад байхад буцаагаад л журмаар зохицуулъя гэдэг л асуудлыг л тавьж орж ирээд байна.

Мэдлэг чадвар нь хүрэхгүй байгаад байгаа бол тэр албан хаагчдаа соль. Мэдлэг чадвартай албан хаагчдыг оруулж ирээд нарийвчилсан зохицуулалтаа хуулийн заалт болгож оруулах зохицуулалтаа хийх ёстой. Энэ дээрээ л та нар төвлөрч ажилла. Энэ бол үндсэн Улсын Их Хурлын ажил.

Тэгэхгүй тэгээд л хэм хэмжээ тогтоох асуудлыг анхан шат, дунд шатад аваачиж албан тушаалтнууд өөрсдөдөө зориулсан байдлаар гаргадаг энэ байдлыг таслан зогсоох хэрэгтэй.

Хоёрт нь, нэрээ өгсөн байгаа гишүүд танхимд орж ирэхийг анхааруулъя. Өмнөх долоо хоногт хэлсэн. Нэрээ өгчхөөд танхимд байхгүй байгаа гишүүдийг нэрсийн жагсаалтаас хасна гэсэн байгаа.

Тамгын газраас анхааруулаарай. Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Хуулийн төсөлтэй танилцлаа. Гишүүдийн асуулт хариултыг сонслоо. Биржийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг явуулахаас өөр аргагүй л юм байна.

Тийм учраас би хувь хүнийхээ хувьд дэмжиж байгаа юм.

Яагаад гэхээр эдийн засаг хүнд болсон. Одоо үүнийгээ өөрчлөхөөс өөр арга байхгүй болсон. Нуман тулгуурт орсон. Улс орны эдийн засаг ерөөсөө ганцхан нүүрс дээр л тулгуурласан. Манай эдийн засаг. Нөгөө нүүрсэн шүүлтүүртэй яндан гэдэг шиг нүүрсэн суурьтай эдийн засагтай ийм л улс.

Тэгээд нүүрсний нь унахаар зэрэг эдийн засаг нь хэвтээд. Тэгээд бүгдээрээ хийх ажилгүй болдог. Нэг төсвөө тодотгож бүх юмаа хасаад цалингаа аваад зүгээр суух, аль эсвэл биржийнхээ хуулийг хүчингүй болгоод тэгээд дотоодын борлуулалт, бусад борлуулалтуудаа хийдэг, бартерладаг, offtake гэрээ хийдэг, нөгөө хуучин руугаа ордог ийм юм руу орох хоёр сонголт л байгаа юм даа.

Тэгээд төсвийн тодотгол хийнэ гэхээр төсвийн тодотгол хийх нөхцөл үүсээгүй гээд байгаа учраас ингээд биржийн хуулиа өөрчлөх л болж байгаа юм.

Иргэдийн амьдрал ч гэсэн хүндрээд явлаа. Малчдын амьдрал, малчдын ноолуурын үнэ ямар байгаа билээ. Өнөөдөр зээл хуультай, түүнийгээ төлж чадахгүй хүндрэлтэй болсон. Жолооч нар, тээвэрчдийн асуудал ямар хүнд байгаа билээ. Өр зээлээр унаа тэрэг авсан. Тэр нь ажилгүй болсон. Айл болгоны хашаанд нэг шаланз ажилгүй, банкны өрөө төлөөд байж байгаа ийм дүр зурагтай. Иргэдийн амьдрал ч хүнд, улс орны эдийн засаг ч хүнд. Нэг ийм нөхцөлд одоо энэ хуулиа өөрчлөхөөс өөр арга байхгүй л болж байгаа юм шиг байна.

Тэгэхдээ энэ хуулиа өөрчлөхдөө бас учиртай, нэлээн ярьж байж өөрчлөхгүй бол орж ирж байгаа төслөөр бас түвэгтэй зүйлүүд их харагдаж байна. Хэлэлцэх эсэх нь дэмжигдээд дараа нь ажлын хэсэг байгуулагдаад нэлээн сайн ярих байх гэж бодож байгаа юм.

Тэр томоохон төслүүд дээр солилцоо хийгээд нүүрсээрээ ажлаа хийгээд явъя гэж байна. Энэ томоохон төслүүд гэж яг юугаа хэлээд байгаа юм. Жишээ

нь, хаанаас батлах юм? Нөгөө 14-өө хэлж байгаа юм уу, аль эсвэл нэг миллиард доллароос дээш төсөвт өртөгтэй ажлуудыг хэлж байгаа юм уу. Тухайлбал,

- ▶ Өмнөговь жишээ нь дулааны станцаа барья.
- ▶ Өвөрхангай руу холбоё.
- ▶ Шивээхүрэн рүү замаа тавья гэхэд болох юм уу?

Өөрийнхөө орон нутгийн өмчит Тавантолгойгоосоо нүүрсээрээ бартер хийгээд, ингээд концесс гэдэг юм уу, юу гэдэг юм. Ийм ажил хийгээд цаашаа явах ийм эрх нь нээгдэнэ гэсэн үг үү? Яана гэсэн үг вэ? Энэ дээр нэг.

Тэгээд үнээ яаж тооцох юм? Дотоодын борлуулалтын үнэ экспортын үнэ хоёрыг яаж салгах юм?

Экспортын үнэ бол тэр дэлхийн зах зээлийн үнэ, биржийнх гээд гараад ирэх байх. Дотоодын борлуулалтын үнээ яаж тооцох юм? Жишээ нь, бартераар хөрөнгө оруулалтын ажлууд хийе гэхэд нэг тонн нүүрсээ хэд гэж тооцох юм гэдэг нэг ийм асуудал байна.

Хоёрт нь, бартер, offtake гэрээгээр ажил хийгээд бараа солилцоогоор хийлээ гэхэд **value exchange** ч гэнэ үү, нөгөө Баялгийн сан руу чинь юм орох юм уу? Нөгөө уурхай чинь бодит cash-ээр орлого олж ирэх ирэхгүй учраас Баялгийн сан руу чинь АМНАТ, бусад юунуудаасаа, ногдол ашгаасаа шилжиж орж байх ёстой шүү дээ.

Тэгээд Баялгийн сан чинь хөдлөхгүй болох юм биш биз гэсэн хоёр дахь асуулт байгаа юм.

Гуравт нь, энэ олон ажилгүй болсон жолооч нар, тээврийн компаниуд дээр чинь нөлөө үзүүлэх үү? Одоо энэ хуучин биржийн юугаар худалдан авагч нь тээврээ хариуцна гэхээр мэдээж худалдан авагч нь хятадууд байгаа. Хятадууд нь хятад компаниа сонгоод л явж байгаа. Монгол компаниуд нь ажилгүй ажилгүй болж байгаа шүү дээ.

Тэгээд одоо энэ хуулийн өөрчлөлтөөр чинь энэ өөрчлөгдөх юм уу? Энэ ажилгүй байгаа олон жолооч нар, ажилгүй байгаа олон компаниуд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүнд 1 минут нэмж өгье.

Н.Наранбаатар: Тэгээд энэ тээвэр дээр нэг тодорхой хэлж өгөөч ээ.

Хуучин байдал нь өөрчлөгдөх юм уу, үгүй юм уу? Хэрвээ хуучнаараа явна гэвэл энэ чигээрээ маш олон хүмүүс өр зээлдээ баригдаж байгаа, амьдрал ахуй нь хүндэрч байгаа ийм асуудал байгаа юм.

Дараагийн дугаарт энэ орон нутагт ямар үр өгөөж байгаа юм бэ? Би үг хэлэх болгондоо л та бүхнээс асууж байгаа шүү дээ. Цогтцэций сум балгас байгаа, Цагаан хад балгас байгаа.

Тэгээд ер нь энэ жил Цогтцэций сум Өмнөговь аймагт “Эрдэнэс Тавантолгой” компаниас юу хийх юм? Х.Мөнхжаргал захирал яг тийм тийм юм хийнэ гээд хэлээдэх.

Дотоодын борлуулалт, зам тээвэр, замынхаа асуудлыг яаж шийдэх юм? Дотоодын борлуулалтууд нь ямар замаар явах юм. Нөгөө утаагүй түлш зөөгөөд хамаг зам эвдээд, байгаль орчин сүйтгэдэг шиг юм болох юм уу, яах юм? Хөрөнгө оруулалт юу хийгдэх юм? Орон нутгийг яаж дэмжих юм? Ажлын байр яаж нэмэгдэх юм? Ханган нийлүүлэлт яаж хийгдэх юм? Хөрөнгө оруулалт юу байх юм? Тэр орон нутагт нь ямар үр өгөөж үлдэх юм?

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: 10.3 дээр томоохон төслүүд гэж байгаа.

Энэ дээр бид бүхэн Засгийн газар дээр Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогоор явж байгаа. Нийтдээ 6 бүсийн төлөөлөлтэй. Засгийн газар дээр Ерөнхий сайд тэргүүтэй хүмүүс уулзаад бас саналуудыг авсан.

Яг үүн шиг төслүүдээ бид саналаа Засгийн газар дээр нэгтгээд, ялангуяа энэ дээр бүсүүдийн саналуудыг нэгтгээд, эрэмбээр нь хамгийн нэн шаардлагатайгаар нь эрэмбэлээд тэгээд энэ эрэмбэлснээ Засгийн газраар шийдвэр гаргаад Улсын Их Хурал руу. Жишээлэх юм бол говийн бүсээс говийг усжуулах төсөл нэгд байна гэвэл энэ байдлуудаар ингээд бүс бүсүүдийн саналаа аваад, тэгээд Засгийн газар дээр нэгтгэж хэлэлцээд Их Хурал руу оруулж ирнэ гэдэг ийм байдлаар төсөөлж байгаа.

Хоёрдугаарт, үнийг мэдээж тэр бүтээн байгуулалтын үнэ өртөг гэж нэг юм гарч ирнэ. Түүн дээр ТЭЗҮ зарлагдаад 1 тэрбум доллар ч гэдэг юм уу, нэг үнэ гарч ирнэ. Тэгэнгүүт тэнд төлөх манай бүтээгдэхүүн. Ганц нүүрс биш. Тийм ээ. Бусад биржээр арилжаалагдах бүтээгдэхүүнүүдээр үнэ нь мэдээж хөдөлдөг байдлаар тэр бүтээн байгуулалтын үнээс хасагдаад явах байдлаар тооцогдоод явна.

Тэгэхээр үнэ бол уян хатан энэ дээр тооцогдоно гэдгийг хэлье.

Та голчлон уурхай Өмнөговь аймагт говийн бүсүүд дээр явагдаж байгаа. Тэгээд энэ бүсийн төлөөллийн хувьд орон нутгийн асуудлыг Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажлын хэсэг Н.Наранбаатар гишүүн ахлаад маш идэвхтэй бид ажиллаж байгаа. Манай салбарын яам ч гэсэн энэ дэд ажлын хэсэгт нь ороод явж байгаа.

Эндээс их нэлээн хүлээлттэй байгаа. Гол концепц бол ерөөсөө алтыг нь аваад авдрыг нь хаядаг биш, авдарт нь юм үлдээе. Тухайлах юм бол орон нутагт нь бид тэр худалдаа, хангамж, ханган нийлүүлэх байгууллага энэ тэр гээд бүр деталь руу орж чадахгүй ч гэсэн ядахдаа АМНАТ-ийн хуваарилалтын менежментээ л зөв хийе.

Эндээс орон нутагт нь тодорхой юм үлддэг байя. Аймагт нь, сумд нь үлддэг. Тэнд нь тухайн уурхайг ашиглуулсан сум, аймаг илүү хөгждөг энэ нөхцөлийг бүрдүүлье гэсэн концепц бас явж байгаа.

Тэгээд энэ концепц дээрээ бид байгаа. Тэгээд хэдүүлээ ажлын хэсгээрээ хуулийнхаа шинэчилсэн найруулгыг боогоод Улсын Их Хурал дээр оруулж ирэх үед энэ дахин хэлэлцэгдэнэ. Бид хэд тийм бодлогын зарчим барьж байгаа.

Тээвэртэй холбоотой асуудал дээр...

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Тээвэртэй холбоотой асуудал дээр Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

Ер нь Засгийн газраас тээвэр дээр нэлээн онцгой анхаарах үүрэг өгсөн. Засгийн газрын тогтоол гарсан байгаа.

Тэгэхээр зэрэг энд бүх жолооч нарыг тээвэрт оруулна. Урьдынх шиг нэг компанитай нь, нэг Хятад компанитай ч юм уу, эсвэл өөрсдөө олон машин лизингээр өгсөн компани нь толгойлоод тээврийн гэрээ хийдэг юмыг зогсоож байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, “Ц” бичгийг олгохдоо бүх уурхайнуудаас ачиж болно гэдэг ийм түгээмэл байдлаар олгож байгаа. Ингэхээр зэрэг “Ц” бичиг авсан машин ганц том Тавантолгойн нүүрс биш, жижиг Тавантолгойн нүүрсийг ч ачиж болно. Мөн “Энержи Ресурс”-ийн нүүрсийг ч ачиж болно гэдэг ийм байдлаар олгох нь жолооч нарыг илүү.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд аа, 2022 онд тэр нүүрсний хулгай гэдэг сэдэв гарч ирэх үед Засгийн газар ямар зорилгоор тухайн үед шийдвэр гаргасан бэ гэхээр нүүрсний тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа

компаниудын бараг 90 хувь нь Хятадын хөрөнгө оруулалттай компаниуд байна. Тээврийн үйл ажиллагаа явуулаад татвараа Монголын талд маш бага хэмжээгээр төлөөд хилийн цаад талд их хэмжээний татвар төлөөд байгаа учраас тээврийн компаниудын татварыг 100 хувь дотоодод төлдөг болгоё гэдэг зорилгыг агуулж энэ сэдэв хөндөгдсөн шүү дээ.

Тэгээд энэ нь явж байснаа сүүлдээ нүүрсний хулгай болгоод, улс төрчид зарим нь бие биеэсээ өшөө авдаг хэрэгсэл болгоод хувиргаад улс төржүүлээд явсан.

Тэгэхээр энэ тээврийн компаниуд 100 хувь дотоодод татвараа төлж байна уу, үгүй юу? Нийтдээ 2 тэрбум орчим долларын эргэлттэй зах зээл дотоодод татвар төлдөг болох ёстой л гэдэг зорилгыг агуулсан шүү дээ. Тийм шийдвэр гаргаж байсан. Үүний үр дүн яаж гарсан? Та хариулт өгөөч.

Б.Дэлгэрсайхан: Нэгдүгээрт, “Ц” бичгээ тийм болгож байгаа.

Хоёрдугаарт, Зам, тээврийн яамнаас бүх тээврийн хэрэгслийг бүх жолооч нараа бүх боомтуудаар тооллого хийж байгаа. Ингэж байж маш тодорхой болгохгүй бол саяын Их Хурлын даргын хэлдэг үнэн.

Тийм учраас цаашдаа бид Монгол Улсад бүртгэлтэй, зөвхөн Монгол жолооч тээвэр хийнэ гэдэг. Монгол Улсынхаа нутаг дэвсгэр дээр Монголын жолооч тээвэр хийж энэ нүүрсийг хил гаргана гэдгийг урд хөрштэйгөө тохирч ярьж байгаа гэдгийг бас энэ ташрамд хэлье.

Тэгээд цаашдаа Монголд бүртгэлтэй компани, дээрээс нь Монгол жолооч нар тээвэр хийхийн тулд татвараа төлдөг журмыг “Ц” бичгийг олгохдоо давхар үзүүлэлт болгож оруулж өгч байгаа.

Тээврийн компаниуд Монголынхоо татварын бүртгэл дээр байж, тэгээд татвар нь Монголдоо орно. Янз бүрийн гаднын компаниуд тээвэр хийхгүй байх бүх хаалтыг хийж өгсөн. Зам, тээврийн яаман дээр.

Хэдийгээр өнөөдөр явдаггүй машин дээр хүртэл “Ц” бичиг авч байгаа асуудал гарч байгаа учраас энэ “Ц” бичгийн янз бүрийн дагасан авлига, янз бүрийн хэл амыг таслан зогсоохын тулд бүх машин явдаг, явдаггүйгээр нь тооллого хийгээд жолооч нараа бас дахин бүгдийг нь бүртгэлжүүлж байгаа. Тэгж байж энэ тээврийг цаашдаа явуулна.

Тийм ч учраас Засгийн газраас гаргасан тогтоолоор бүх уурхайн амнаас гарч байгаа тээвэр, төмөр замын танаалт дээр очих, дээрээс нь хилээр машинаар гаргах, мөн шууд ачигдаад гаргах энэ бүх тээврийн компани тээвэр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэр 2022 оны Засгийн газрын шийдвэрээс хойш яах вэ дотоодын компани байна уу, гадаадын компани байна уу гэдгээр нь ялгах гэж байгаа зүйл биш.

Монгол Улсын газар нутаг дээр тээвэр хийсэн компаниудын татвар бүрэн төлөгддөг болсон уу, үгүй юу л гэдэг асуулт явж байгаа байхгүй юу. Энэ дээр нэг тодруулж хариулт өгье.

Та тэр тухайн үеийн нөхцөлийг мэднэ шүү дээ? Тийм ээ. Монголын тээвэр эрхэлж байгаа компаниудаас 3-аас 4 дахин хямд үнээр гаднын компаниуд тээвэр хийгээд байсан. Шалтгаан нь цаад талдаа очиж өндөр үнээ мэдүүлж татвараа төлдөг байсан гэдэг зүйлийг л Засгийн газар тухайн үед илрүүлсэн шүү дээ.

Тэгэхээр ерөөсөө л Монголд тээвэр хийж байгаа компаниудын татвар Монгол Улсад үнэн зөвөөр, бодитоор төлдөг байх тэр нөхцөлийг хангая л гэдэг л зорилго агуулж байсан.

Та энэ дээр тодорхой хариулт өгөөч. Б.Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Засгийн газар Тавантолгойгоос тээврийг салгаж өгсөн Засгийн газрын тогтоол нь Их Хурлын даргын ярьж байгаа, бодож байгаа зүйлтэй яг санал нэг байгаа. Яагаад гэхээр нүүрс худалдан авагч өөрөө тээврээ давуу эрхээр нүүрс авсан гэдгээрээ өөрийнхөө тээврийн хэрэгслээр хийнэ гэдэг монопол эрх эдэлснээс болж хямд өртгийг зориуд бий болгоод хилийн цаана зөрүү мөнгийг нь өгч байгаа нь үнэн байсан.

Тэгэхээр үүнийг таслан зогсоох гэж байгаа зүйл нь бүх тээврийн хэрэгслийг дотоод байна уу, гадаад байна уу Зам, тээврийн яаман дээр хариуцаад тэгээд Авто тээврийн үндэсний төв дээр татварын байцаагч суулгаад хамтад нь үүнийг шийдвэрлэж явахаар ийм журам гарсан.

Тийм учраас цаашдаа зөвхөн машиныг тухайн жолооч хэдийгээр лизингээр авсан ч гэсэн зөвхөн дотоодын аж ахуйн нэгж байж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: “Эрдэнэс Тавантолгой”-гоос хариулт өгье. Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Х.Мөнхжаргал: Н.Наранбаатар гишүүний асуултад хариулъя.

“Эрдэнэс Тавантолгой” компани Ашигт малтмалын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн дагуу Өмнөговь аймагтай гэрээ байгуулан хамтарч ажиллаж байгаа.

Орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан мөнгө төвлөрүүлж байгаа. Аймаг, сум болон холбогдох компанийн ажилтнуудын хамтарсан ажлын хэсэг буюу хамтын хорооны хурлаар тухайн сумд хийж хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр ажлуудыг баталснаар хэрэгжүүлээд явж байгаа.

Ерөнхийдөө өмнөх хоёр жилд “Эрдэнэс Тавантолгой” компанийн зүгээс Цогтцэций сумын төв доторх засмал замуудын асуудлыг ерөнхийдөө шийдсэн байгаа.

2025 оны хувьд шинэ суурьшлын бүсийн орон сууц сургууль, цэцэрлэг зэрэг зураг төслөө хийлгэхээр бид шургуу ажиллаж байна.

Мөн аймгаас ирүүлсэн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Х.Мөнхжаргал: Аймгаас ирүүлсэн цэвэрлэх байгууламж, дэд бүтцийн зарим нэг ажлууд хөдөө аж ахуйн салбарыг дэмжих, мөн нөлөөллийн бүсийн хохирлын үнэлгээ хийх, гидрогеологийн судалгааны ажил хийх зэрэг ажлуудыг бид хамтран хийхээр төлөвлөж, энэ дээр компанийн зүгээс ажиллаж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулж асууя.

Н.Наранбаатар: Аль хэдэн сарын өмнө л аймагтай хамтарч ажиллах гэж байгаа, хамтарч ярих гэж байгаа, хорооны хурлаа хийх гэж байгаа л гээд байсан. Одоо хүртэл. Энэ чинь жилийнхээ талд орлоо шүү дээ.

Тэгээд энэ жил чинь бүтээн байгуулалтын ажил нь тэгээд амжих юм уу? Одоо хийх ажлаа ч төлөвлөөгүй. Тэгээд ажлаа төлөвлөсний дараагаар тендерээ зарлана, ажил нь эхэлнэ гээд өвөл болдог юм биш үү. Тэгээд энэ жил яг юу хийхээр төлөвлөж байгаа юм гэхээр хариулах тодорхой юм байхгүй нэг ийм байдалтай байх юм.

Би тэгээд түрүүн асуусан. Энэ биржийн хуульд орсон өөрчлөлтөөр, offtake-ээр, бартераар, бараа солилцоогоор нүүрсээ өгөх юм бол Баялгийн сан чинь яаж арвижих юм? Баялгийн сангаа яаж арвижуулах юм гэдэг асуулт асуусан шүү дээ. Хэн ч хариулсангүй.

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Би Н.Наранбаатар гишүүний бас түрүүний асуусан орон нутагт энэ суурьшлын бүсэд ямар үр өгөөж байх юм бэ гэж.

Энэ дээр “Монголын төмөр зам” компани, Тавантолгойн төмөр замын суурь бүтэц болоод хөдлөх бүрэлдэхүүн, ажилчидтай нь нийлүүлээд шилжүүлж авсантай холбогдуулаад аль болохоор орон нутгаас ажилчдыг авахаар сонгон шалгаруулалтыг хийж байгаа. Нэн тэргүүнд орон нутгийн иргэд төмөр замд хамгийн түрүүнд орно гэдэг ийм зарчмыг барьж байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт, энэ төмөр зам цаашдаа ирээдүйдээ олон жилийн насжилттай, олон жил явж, энэ тээврийн ирээдүйг харахад бүгд төмөр замаар явах учраас цаашдаа төмөр замын ажилчдыг орон сууцжуулах асуудал дээр “Монголын төмөр зам”, Зам, тээврийн яамнаас онцгой анхаарч байгаа.

Өмнө нь Тавантолгой төмөр замын бүтээн байгуулалт дээр 17 сая.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Дэлгэрсайхан сайд гүйцээж хариулья.

Б.Дэлгэрсайхан: 17 сая долларыг орон сууц барина гээд төлөвлөсөн байгаа юм билээ. Энэ мөнгөөр нь бид төмөр замын ажилчдыг орон сууцтай болгоод, орон нутгийн иргэдийг ажилтай болгосноор төмөр замыг ээлжийн ажил гэдгийг болиулахаар ирээдүйг зорьж байгаа.

Төмөр зам бол ер нь ээлжийн ажил биш. Төмөр зам үргэлж мөнхийн нэг хүн ажиллаад, жишээлбэл өртөөний дарга нэг л хүн ажиллаад хариуцлагаа үүрдэг.

Түүнээс одоогийн байдлаар уурхай шиг ээлжлээд явдаг ийм системээр ажилладаг тийм байгууллага биш ээ. Төмөр зам өөрөө онцлогтой. Сахилга бат хоёр дахин шаарддаг ийм онцлогтой байгууллага учраас ээлж гэж байхгүйгээр орон сууцжуулаад, суурьшлын бүс бий болгоод төмөр замын ажилчдаа тэнд нь байлгах ийм бодлого ирээдүйд явж байгаа гэдгийг зориуд хэлье гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баялгийн сантай холбоотой тодорхой хариулт өгмөөр байна. Хариултыг маш товч тодорхой өгөхгүй бол болохгүй. Яагаад гэхээр энэ хуулийг хэлэлцэх эсэх асуудлыг 150 минутын хугацаанд хэлэлцэхээр тов дараалал тогтохтой тогтсон. Одоо 14 гишүүн асуулт асуух үлдсэн.

Гэтэл бидэнд нэг цагийн хугацаа үлдсэн байж байгаа. Үндсэндээ 60 минутад 12 гишүүн зөвхөн асуулт асууж амжвал амжина.

Тэгэхээр олон гишүүд асуултаа асууж амжихгүй, цаг хугацаа дуусах гэж байгаа учраас хариултаа маш тодорхой товч өгөөрэй.

Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Н.Наранбаатар гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Бүх бүтээгдэхүүнээс АМНАТ авч байгаа. Жишиг үнээр. Одоо тэр

- ▶ коксжих байна уу,
- ▶ гуравны нэгийн нь коксжих байна уу,
- ▶ баяжуулсан байна уу,
- ▶ эрчим хүчний байна уу

бүгдээс нь авч байгаа. Бүх биржээр зарагдаж байгаа экспортод гарч байгаа бүтээгдэхүүнээс авч байгаа.

АМНАТ-ын орлого маань шууд өөрөө Баялгийн сан руу орж ирж байгаа. Баялгийн сан дээрээ ороод

- “Ирээдүйн өв сан”-д 65,
- “Хуримтлалын сан”-д 35 хувь гээд ингээд хуваарилагдаад явж байгаа.

Тэгэхээр бүгд АМНАТ нь орж байгаа шүү гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа. Энэ үнэхээр өндөр ач холбогдолтой хууль юм л даа.

Тэгээд яг үнэнийг хэлэхэд энэ нэмэлт, өөрчлөлтийг уншаад надад итгэл төрөхгүй байна. Сайжруулж байна гэж итгэл төрөхгүй байна л даа. Үнэ өсөж явахад биржийн хууль их сайхан ажиллажээ гээд. Үнэ буухаар биржийн хууль болохгүй байна. Энэ буруу шүү дээ.

Бирж үнэ өссөн ч, буурсан ч ажилладаг ийм л зохицуулалттай механизм байхгүй юу.

Тэгэхээр өнөөдөр тэр оношилгоогоо зөв хийсэн юм уу гэдэг дээр би эргэлзэж байна л даа. Өнөөдөр “Эрдэнэс Тавантолгой” дээр тулгамдаж байгаа асуудал биржийн асуудал юм уу, менежментийн асуудал юм уу. Энэ хуулиа зөв уншаад менежмент нь үнэ буурахыг таагаад. Энэ чинь прогноз нь ойлгомжтой байсан юм шүү дээ. Шаардлагатай арга хэмжээнүүдээ авсан бол өнөөдрийн асуудал гарахгүй л байсан.

Уг нь Засгийн газар “Эрдэнэс Тавантолгой” гадаад менежмент авна гээд л яриад л байсан. Энэ асуудлыг аль түрүүн шийдэх ёстой шүү дээ. “Эрдэнэс Тавантолгой” дээр үүсэж байгаа асуудал цаашдаа улам хүндэрнэ. Үүнийг биржийн, эсвэл нэг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр шийдэхгүй шүү, энэ танхимд

шийдэхгүй. Үүнийг газар дээр нь зөв менежмент, зөв арга хэмжээ авч байж л шийдэх байхгүй юу.

Тэгэхээр өнөөдөр энэ бол хуулийн доголдол биш менежментийн доголдол гэж би хувьдаа оношилж байна.

Тэгэхээр буруу оношлохоор яах вэ хууль дээр буруу нэмэлт, өөрчлөлт л орно гэж харж байгаа юм.

Энэ хууль батлагдсанаас хойш 2 жил 2 сарын хугацаа өнгөрсөн байна. Нийтдээ 16.9 их наяд төгрөгийн арилжаа хийгдсэн байгаа юм. Энэ бол Монгол Улсын 2025 онд баталсан төсвийн 50 хувьтай дүйцэхүйц хэмжээний мөнгө шүү. Хэрвээ энэ хууль батлагдаагүй байсан бол энэ 17 их наяд төгрөгийн арилжаа тэр компаниудын захирлын томилсон нэг үнэнч шалгаруулах комиссын 4 хүний шийдлээр л явах байсан байхгүй юу. Гол үнэ цэн энэ дээрээ байсан.

Энэ 2 жил 2 сар хагасын хугацаанд 17 их наяд төгрөгийн арилжаа хийгдэхдээ тэр анх бирж дээр зарласан үнэ, зарагдсан үнэ хоёрын хоорондын нийт зөрүү 1.3 их наяд төгрөг. Нийт арилжааны дүнгийн 7.7 хувь.

Тэгэхээр энэ бол ингээд Монгол Улсад маш зөв байсан нь энэ статистик нь өөрөө яриад өгчхөж байгаа юм.

Тэгэхээр энэ нэмэлт, өөрчлөлт дээр хоёр үндсэн амин сүнсийг нь хөндсөн асуудал орж ирээд байна л даа. Биржээр нэгэнт ил тод арилжаалагдсан бол тэр гэрээний үнэд өөрчлөлт оруулна гэдэг нь өөрөө олон улсын хэмжээнд ч гэсэн энэ чинь байж боломгүй асуудал шүү дээ. Нэгэнт арилжаагаар арилжаалагдсан. “Эрдэнэс Тавантолгой” дээр чанарын асуудал анх нүүрс гаргаж эхэлсэн цагаас хойш яригдсан юм. Энэ цоо шинэ асуудал биш.

Тэгэхээр энэ чанарын асуудлаас болж гэрээний үнэд арилжаалагдаад тохирсон үнэ дээр өөрчлөлт оруулна гэдэг бол өөрөө маш их асуудлыг дагуулна, маш их маргааныг дагуулна. Баахан компаниуд “Эрдэнэс Тавантолгой”-г шүүхэд өгнө. Тэгээд үнээ буулгана гэнэ.

Тэгэхээр энэ бол өөрөө том эрсдэл нэгдүгээрт гаргаж байгаа юм.

Хоёрдугаарт, энэ хуулийн 16.5, 14.1 дээр буцаад нөгөө “хил нөхцөл” гэсэн энэ хуулиар гол оруулж ирсэн зүйлийг буцаад та тээвэртэй, тээвэргүй сонголттой, эсвэл байршлийг нь Засгийн газар өөрөө тогтооно гэж байгаа юм. Энэ юу гэсэн үг вэ гэхээрээ бидний тэмцээд байсан буцаад нөгөө ам нөхцөл эргээд орно гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр би танаас хоёр маш энгийн асуулт асууя.

Нэгдүгээрт, энэ хууль батлагдсанаараа нийт гэрээний хэдэн хувь нь та өөрчлөгдөнө гэж бодож байна? Чанараас болоод.

Хоёрдугаарт, энэ хууль батлагдаад цаашаага арилжаа явахад нийт нүүрсний хэдэн хувь нь “ам нөхцөл”-өөр дуудагдана гэж бодож байна? Та. Тооцоолол хийсэн байлгүй.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя.

Бирж дээр яг үнэндээ дуудлага худалдаа яваад байгаа. Сонгодог биржийн гэрээ арилждаг зарчмаар бирж маань өнөөдөр ажиллахгүй байгаа. Үүнийг шулуухан хэлэх ёстой.

Тэгэхээр энэ зарчим руу орохыг олон гишүүд хэлсэн. Энэ рүүгээ бид бэлтгэл хангаж байгаа гэдгийг хэлье.

Биржээр борлуулсан нүүрсний үнэ дээр өгсөж байх үе дээр индексжүүлээгүй, нэг хатуу зарагдсан үнээр өгсөж байх үед ямар нэгэн хэл ам гарахгүй байгаа юм. Үнэ унаад ирэх үед тэр авсан компаниуд нь энэ чинь нэлээн бага үнийн уналт биш, нэлээн өндөр үнийн уналд ороод ирэхээр авсан компаниуд нь цааш цаашаага нүүрсээ борлуулж зарж чадахгүй маш их хэмжээний алдагдал хүлээх ийм бодит нөхцөл байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ дээр нүүрсний үнийг өгсөх үед нь өгсөөж индексжүүлдэг, буурах үед нь бууруулж индексжүүлдэг асуудлыг энэ хуульд тусгаж өгч байгаа.

Чанартай холбоотой асуудал дээр би түрүүн П.Сайнзориг гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Үүнийг ажлын хэсэг дээрээ эргэж хэлэлцэх эсэхээ шийдсэний дараа ярьж гэж.

“Эрдэнэс Тавантолгой”-н гаднын менежментийн баг авч ажиллуулах шийдвэр Засгийн газар дээр явсан. Энэ дээр бас ажлууд урагшаа явж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд индексжүүлж өгөөгүйгээс болоод биржийн арилжаал арилжаанд худалдан авагч оролцохгүй байгаа. Яагаад гэхээр хаана хүртэл унахыг мэдэхгүй. Тэр авсан хүн нь маргааш нь дахиад индексжихгүй унах учраас хүн ийм алдагдалд орно гэдэг байдлаар хүлээгээд арилжаанд оролцож өгөхгүй байгаа юм гэдгийг хэлье.

Тээвэртэй, тээвэргүй гээд. Бид 2-оос 12 сарын дотор биржээр арилжаалсан нүүрсийг хүргэж өгөх гэрээний үүрэг хүлээж байгаа. Дунджаар 3-аас 4 сарын дараа үүнийг DAF [Delivered At Frontier-Хил дээр хүлээлгэн өгөх] нөхцөлөөр манай

“Эрдэнэс Тавантолгой” компани тэр Ганцмод дээр байгаа терминал дээр аваачиж буулгаж өгч байгаа.

Тэгэхээр энэ дээр худалдан авсан хүн өөрөө тээврээ шийднэ гэвэл энэ дээр ямар нэг өөрөө тээврээр шийдээд “Цагаан хад” дээр буулгана уу, цаашаа аваад явна уу энэ хурд орж ирээд арилжаа нэмэгдэнэ гэдэг үндэслэлээр энэ заалтыг оруулж ирж байгаа гэж хэлье.

Хууль батлагдсанаар нийт нүүрс хэдэн хувь нь “ам нөхцөл”-өөр, хэдэн хувь нь DAF нөхцөлөөр зарагдахыг би хэлж мэдэхгүй байна. Энэ дээр манай биржийнхэн нэмээд хариул.

Гэрээн дээр нийтдээ 44 гэрээ өнөөдөр гацсан. Өөрөөр хэлбэл татан авалтаа хийхгүй байгаа. Тэр нь урд Ганцмодны терминал сул биш. Чингэлгээ суллаж өгөхгүйтэй холбоотой гацаа үүсээд байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Биржээс хариулах уу? “Эрдэнэс Тавантолгой”-гоос хариулах уу? Одоо энэ өөрчлөлт орсноор хэчнээн гэрээнд ямар өөрчлөлт орох вэ гэдэг асуудал явж байлаа шүү дээ. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон.

Хөрөнгийн биржийн захирал Б.Дөлгөөн хариулт өгье.

Б.Дөлгөөн: О.Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Хөрөнгийн биржийн захирал Б.Дөлгөөн байна.

Чанартай холбоотой асуудал яах аргагүй дараагийн том асуудал гэдэгтэй санал нэг байна. Өмнө нь үнийн асуудлуудыг бирж дээр намайг ажилласан нэг сард ажил авахад асар ихээр санал гомдол ирсэн.

Тэгээд үнэтэй холбоотой олон улсын туршлагуудыг бид судалж байгаад индекс гэдэг хувилбарыг гаргаж ирсэн байгаа.

Одоо дараагийн том гомдол бол чанартай холбоотой. Тэгээд таны хэлж байгаагаар яах аргагүй нүүрсний компаниуд дээр тулгамдаж байгаа асуудлын нэг. Нүүрсний компаниуд гэдэг бол би ганц “Эрдэнэс Тавантолгой”-г хэлмээргүй байгаа юм. Энэ дотор хувийн хэвшлийн компаниуд орж байгаа.

Мөн төрийн өмчийн компаниуд орж байгаа. Аль аль дээр нь энэ асуудлууд тулгарч байгаа гэдгийг энд дурдмаар байна. Тэгээд чанар дээр бид яагаад үүнийг оруулж ирж байгаа вэ гэхээр жишээлбэл хүхэр 1 хувь.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. 11 дүгээр микрофон.

Б.Дөлгөөн: Хүхэр 1 хувиар өсөхөд тэдэн центээр үнэ унаж байгаа. Хүхэр 1 хувиар буурахад тэдэн центээр үнэ өсдөг гэдэг туршлага олон улсын биржүүд дээр арилжаалагдаж байгаа гэрээнүүдэд байгаа.

Тэгэхээр олон улсын хамгийн сайн туршлагыг бид хөрөнгийн бирж дээрээ, арилжаан дээр оруулж ирснээрээ бид илүү олон худалдан авагчийг орох боломж, итгэл үнэмшлийг нь нэмнэ гэдэг чиглэлээр ажлаа явуулж байна.

Яг “ам нөхцөл”, “хилийн боомтын үнэ нөхцөл” гэдэг дээр бид нарын зүгээс хэлж мэдэхгүй байна. Гэхдээ өмнө нь явж байсан туршлагыг харахад тээвэр дээр тээврээ хэрвээ шууд худалдан авагчид өгнө гэж үзэх юм бол худалдан авагч тал түрүүний Н.Наранбаатар гишүүний хэлдгээр дийлэнх нь Хятад компаниуд байгаа. Хятад компаниуд өөрсдийнхөө Хятадын тээврийн компаниудаар эдгээр тээврийг хийлгэх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Отгоншарын Батнайрамдал гишүүн тодруулж асууя.

О.Батнайрамдал: Ийм чухал хууль дээр судалгаагүй орж ирнэ, яаралтайгаар орж ирнэ гэдэг нь өөрөө асуудал л даа.

Ер нь шийдэл олохоос өмнө хамгийн зөв прогнозоо, зөв оношилгоогоо хийх ёстой юм л даа. Тэгэхээр энэ бол оношилгооноосоо эхлээд алдаатай байна л гэж байгаа юм.

Тийм учраас энэ хуулийг миний хувьд дэмжих боломжгүй. Харин тэрний оронд менежментийн өөрчлөлтөө хийх ёстой шүү. Менежмент энэ тулгамдаж байгаа асуудлыг өөрсдөө олж шийдээд гарц гаргалгааг нь олно. “Эрдэнэс Тавантолгой”-д менежментийн цоо шинэ өөрчлөлт хийгээд энэ асуудлыг шийдье гэсэн бол хангалттай ашиг байсан шүү дээ. Ногдол ашиг болгож тараасны оронд дотоод асуудлаа шийдэхгүй юугаа хийсэн юм.

Хамгийн түрүүнд Монгол Улсад цаашдаа нүүрснээс хамааралтай болох нь ойлгомжтой.

Тэгэхээр хамгийн түрүүнд “Эрдэнэс Тавантолгой”-н менежментийг олон улсын үнэхээр сайн менежмент яаралтай авч байж л энэ асуудал шийдэгдэнэ шүү гэдгийг дахин хэлье.

Д.Амарбаясгалан: О.Батнайрамдал гишүүн үг хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн байхгүй байгаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу?

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас нь үзэхэд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нэг практик хэрэгцээ нь уул уурхайн бүтээгдэхүүн, нүүрсний үнэ буурсан. Үүнийг дагаад биржийн харилцаа огцом буурсан гэжээ.

Энэ дээр Засгийн газар ер нь уул уурхайн бүтээгдэхүүн, нүүрсний үнэ буурах эрсдэл байгаа талаар 2025 оны төсвийг хэлэлцэж байхад төслийг батлуулахдаа урьдчилан тооцоолсон, үүсэх үр дагаврыг хэрхэн шийдвэрлэх вэ, хүндрэлийг яаж даван туулах вэ гэж төлөвлөсөн зүйлүүд байна уу?

Судлаачид, мэргэжлийн хүмүүс, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл зэрэг нүүрсний үнэ унах төлөвтэй байна гэдгийг хэлж, ярьж, анхааруулж байсан. Үүнийг Засгийн газар анхаарсан уу? Анхаарч үзсэн үү? Үзсэн бол ямар бодлого гаргасан юм бэ? Төлөвлөлтөө яаж боловсруулсан юм бэ? Нүүрсний үнэ буурах, өсөх болгонд хувилбар 1, 2, 3, 4 гэдэг байдлаар төлөвлөсөн зүйл байгаа юу гэдгийг асуумаар байна.

Үүнийгээ тэгээд нэлээн тодорхой хариулж өгөөрэй гэж хүсье. Түүнээс яаралтайгаар хууль оруулж ирээд тухай бүрд нь дандаа хууль өөрчлөөд байх нь үр ашигтай биш гэж бодож байна.

Хоёрдугаарт, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3-т “төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төсөл, бүтээн байгуулалтуудын ажлыг хэрэгжүүлэх зорилгоор харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд бүтээгдэхүүн солилцох гэрээг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэж болно.” гээд бичсэн байна. “Болно” гэдэг нь хоёрдмол утгатай юу? Бас болохгүй ч байж болно гэж уншигдахаар. Тийм ээ.

Тэгэхээр ингэж өөрчлөн найруулсан гол үндэслэл нь юу юм бэ? Хэрэгцээ шаардлага нь юу байсан бэ? Энэ өөрчлөн найруулсны бодит үр нөлөө нь яаж гарна гэж тооцож байгаа вэ?

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгаас үзэхэд энэ дээр тодорхой туссан юм байхгүй байна.

Гуравдугаарт, энэ хуулийн 10.3-т заасан гэрээг байгуулахдаа тухайн бүтээгдэхүүний биржийн арилжааны дундаж үнийг баримтална гэсэн заалтыг хүчингүй болгох санал оруулж ирж байгаа юм байна.

Гэтэл энэ хэсгийг 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн.

Тэгэхээр нэмэлтээр оруулж ирсэн хуулийнхаа заалтын үр дүнг бүрэн үзэж чадахгүй, бүрэн хэрэгжүүлж чадахгүй болж байгаа юм биш үү? Энэ заалт

хүчингүй болсноороо нийгэм, эдийн засагт цаашдаа ямар сөрөг үр дагавар гарах юм? Энэ талаар судалж үзсэн, нарийвчилсан тооцоо байна уу гэдэг ийм гурван асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Д.Ганмаа гишүүний асуултад хариулъя. Маш чухал асуудлуудыг хөндөж байна.

Засгийн газар энэ асуудлуудыг улсын төсөв батлагдах үеэр аргачлал байдаг. Сангийн яамны. Нүүрсний үнийг сүүлийн 10 жилийн дунджийг аваад нэлээн багасгасан байдлаар. Ганцхан нүүрс ч биш. Бусад орлого оруулж ирдэг металлууд, нүүрс зэргийн үнийг нэлээн багасгасан байдлаар тооцож оруулж ирдэг.

Тухайн үед нүүрсний дундаж ханш 125 доллар байсан. Тэгэхэд 105 доллароор тооцож оруулж ирсэн.

Үүнийг 20 долларын маржтайгаар оруулсан боловч өнөөдөр ганцхан Монголд биш дэлхий даяараа худалдааны дайн ширүүсээд, геополитикийн асуудлууд хүндрээд, “Трамп тариф”-ын нөлөөлөл маш хурдтай. Өнөөдөр одоо бид юмаа яриад сууж байхад маргааш юу болохыг тооцоолох боломжгүй тогтворгүй нөхцөл байдал үүсээд байна л даа.

Тэгэхээр энэ дээр бид урьдчилж тооцсон боловч харамсалтай нь өнөөдөр нүүрсний үнэ, экспортын гол орлого маань багассан учраас энэ асуудлыг зохицуулах үүднээс л энэ хуулийг оруулж ирж байгаа. Амьдрал баян учраас шинэ нөхцөл байдлууд үүсээд байна.

Тэгэхээр мэдээж энэ дээр бодлого байлгүй яах вэ. Нүүрсний үнэ унасан тохиолдолд ямар менежмент хийх вэ гээд.

- Боомтын нэвтрүүлэх чадварыг сайжруулах.
- Нүүрсний тээвэрлэлтийн өртгийг бууруулах.
- Нүүрсний тонн тутам дахь зардлыг бууруулах

гэх мэт бодлогуудыг гаргасан.

Энэ бодлогоо бид экспортыг дэмжих ажлын хэсэг дээрээ яриад энэ асуудлуудаа шийдээд явж байгаа гэдгийг хэлье.

Бүтээгдэхүүн солилцооны тухай 10.3-ыг ярьж байна. Энэ дээр бид үндэслэл, хэрэгцээ зөндөө байгаа. Бүх гишүүд рүү хүмүүс сургууль баримаар байна, цэцэрлэг баримаар байна, эмнэлэгтэй болмоор байна, замтай болмоор байна, 14 мега төслийг хэрэгжүүлмээр байна гээд ярьж байгаа.

Тэгэхээр энэ ярьж байгаа зүйлүүдийг бид төсвийн хуулиараа хэрэгжүүлээд явах ямар ч боломжгүй болсон. Төсвийн хуулийг бид алдагдалгүй баталсан.

Хоёрдугаарт, бид валютын нөөцтэй холбоотой бүтээн байгуулалтыг хийхэд маш их хэмжээний импортоор бараа авчирч байж, валют зарж байж хийх нөхцөл үүсээд байгаа юм.

Тэгэхээр бид өөрт байгаа зүйлээрээ тийм ээ, одоо бид ард иргэд хүртэл юм зарахдаа нэлээн их ашигладаг болсон байна лээ шүү дээ. Бартер сонирхоно гээд. Түүн шиг өөрт байгаа бүтээгдэхүүнээрээ, ганцхан нүүрс ч биш, уул уурхайн бусад бүтээгдэхүүнээрээ бүтээгдэхүүн солилцоо хийлгэх дэд бүтцийн асуудлынхаа өртгөөс үнээ тогтоож хасах байдлаар л энэ асуудлыг оруулж ирэхээр төлөвлөж байгаа гэдгийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Тэгэхээр сая бид бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Архангай аймаг дээр Архангай, Өвөрхангай, Баянхонгор гээд 3 аймаг оролцсон бүсийн анхдугаар чуулганыг хийгээд бүсийн зөвлөл баталсан.

Энэ дээр 3 аймаг нийтдээ 100 гаруй сумдын Засаг дарга, хурлын дарга нар оролцоод маш олон хүн. Бараг 40 гаруй, 50-иад хүн үг хэлсэн. Бүх хүний үгэнд нэг ч хүний үгэнд орхигдоогүй гарсан нэг хүсэлт манай сум дээр ийм юм хийж өгөөч, манай сумаас хил хүртэлх тэр замыг тавьж өгөөч, ийм үйлдвэртэй болгож өгөөч гэдэг ийм саналуудыг хэлж байна лээ.

Тэгэхээр үүнийг бид гүйцэлдүүлэх арга хэрэгсэл нь үүнийг гэж Засгийн газар үзээд хууль дээр ийм байдлаар оруулж ирсэн гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ хууль анх батлагдахдаа улс төрийн гал намжаах хэрэгсэл болж батлагдсан. Сайн ч юм бий, муу ч юм бий.

Тэгэхээр муу юмыг нь одоо засах нь зөв. Хуулийн өөрчлөлтийг бүхэлд нь дэмжиж байгаа.

Энэ хуульд нэг зүйл тодорхойгүй байдаг. Энэ нь дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн эрх зүйн орчинг тодорхой болгож өгөөгүй хаясан.

Тийм учраас дотоодын боловсруулах, баяжуулах нөгөө тусгай зөвшөөрөлгүй үйлдвэрүүд чинь түүхий эдийн хомсдолд ороод зогсонги байдалд орсон.

Тэгэхээр бид дотоодын үйлдвэрлэлээ дэмжих бодлогоо магадгүй энд хаясан байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр яг ямар бодлого, ямар заалт оруулж ирж байгаа вэ, нөхцөл байдал яаж өөрчлөгдөх вэ гэдэг нэг асуулт.

Нөгөөдөх нь 16.3. Үүнийг маш боломжтой заалт гэж бодож байгаа. Бүтээгдэхүүн солилцох буюу бартер тийм үү. 10.3.

Нийгэм, эдийн засгийн үр өгөөжтэй ач холбогдол бүхий томоохон төсөл, бүтээн байгуулалтын ажлуудыг дэмжих зорилгоор харилцан ашигтай, тогтвортой урт хугацаанд бүтээгдэхүүн солилцох гэрээг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гэж байгаа юм.

Үнийг яаж баримтлах вэ? Яг энэ хэрэгсэхгүй болж байгаа 10.3-ын заалт дээр чинь “биржийн дундаж үнийг баримтална” гэсэн байгаа. Тийм ээ. Би магадгүй энд зүгээр нэг ийм болгоомжлол байна. 2012 онд хийж байсан Чалкогийн гэрээг давтах вий дээ. Монгол Улсын 6 Засгийн газар 7 жилийн хугацаанд төлсөн Чалкогийн гэрээг дахиад давах вий.

Тэгэхээр үнэ тус бүрийг хийх. Одоо жишээ нь үнэ тус бүрийг хийхдээ Улсын Их Хурал дээр орж ирээд хийлгээд байх юм уу? Магадгүй том төсөл гэдэг дээр 14 мега төсөл байх. Тийм үү?

Тэгэхээр 14 том мега төслөө оруулж ирэх тоолондоо үнийг нь Улсын Их Хурлаар батлуулаад байх юм уу, үнээ яаж баримтлах вэ гэсэн хоёр асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Цэвэгдоржийн Туваан сайд.

Ц.Туваан: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Дэмжиж байгаад баярлалаа.

Дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн асуудал энэ дээр орж ирж байгаа. Өмнөх хуулийн зохицуулалтаар бас нэлээн сул зохицуулагдсан ийм зүйл байсан.

Дотоодод бид боловсруулах, баяжуулах үйлдвэрүүдэд лиценз өгдөг. Дээрээс нь бид Үйлдвэр, технологийн паркийн тухай хуулийг батлаад, мөрдөөд ажиллаж байгаа.

Монгол Улсад аж үйлдвэрийн салбар үйлдвэр, технологийн паркийн дагуу парк байдлаар хөгжихөөр хуульчлаад өгсөн. Тэгээд энэ үйлдвэрүүдэд маань жишээлэх юм бол Дорноговь аймагт байдаг Алтанширээ, Гэрэлтнаран гэх мэтийн үйлдвэрүүд дээр жишээ авахад эд нар үйлдвэрээ бариад дууссан. Яг ингээд ажиллах гэхээр нөгөө бүтээгдэхүүнээ авч чаддаггүй. Ялангуяа бага агуулгатай хүдэр, мөн коксжих нүүрс, төмрийн хүдрийг авах гэхээр биржийн тухай хуулийн зохицуулалт дутаад байгаа.

Биржийн тухай хууль дээр ерөөсөө экспортлох зорилгоор хил нөхцөлөөр гээд заавал биржээр арилжина гээд заагаад өгсөн энэ асуудлууд жоохон тээг болоод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр биржээр арилжигдах нь арилжигдана. Тэгэхдээ тэр дотоодын үйлдвэрүүд нь аваад боловсруулалт хийгээд, баяжуулаад цааш нь экспортлох гэдэг энэ логикоор зохицуулалтыг хийж өгсөн байгаа гэдгийг хэлье.

Бүтээгдэхүүн солилцоон дээр мэдээж Л.Мөнхбаясгалан гишүүн ярьж байгаа. Говийн бүсийг усжуулах төсөл гээд жишээ аваад ярихад энэ төсөл дээр нэг ТЭЗҮ гараад нэг үнэ гарч ирнэ. Тэр үнийг их, бага гээд ямар нэгэн байдлаар ТЭЗҮ батлахад үнэ батлагдана. Энэ батлагдсан үнээс тэнд бүтээгдэхүүн солилцоо хийж байгаа валют биш. Монголд байгаа ямар нэгэн уул уурхайн бүтээгдэхүүнээр өгөхөд үүний үнийг тогтооно. Чалко компани дээр ч гэсэн үнэ нь явдаг шүү дээ. Үнэ нь байгаа. Энд үнэ нь хөдлөөд дээшээ, доошоо болоод борлуулагдаад л явж байгаа.

Тэгэхээр энэ үнийг хөдөлдөг үнэ. Үнэ болгоныг Улсын Их Хурлаар оруулж ирэхгүй. Концепц нь яаж явж байгаа гэхээр энэ саналуудыг Засгийн газар дээр нэгтгээд ганцхан 14 мега төслөөр хязгаарлахгүй. Бусад нийгмийн, эдийн засгийн, дэд бүтцийн бусад төслүүдийг Засгийн газар дээр саналыг нь авч багцлаад тэндээсээ Улсын Их Хурал руу оруулж ирнэ.

Түрүүн Д.Ганмаа гишүүн асууж байна лээ. “Болно” гэдэг чинь ямар учиртай юм бэ гэж. Энэ дээр Улсын Их Хурлын бүрэн эрхэд үлдээж байгаа юм. Их Хурал саяын Гашуунсухайт-Ганцмодны Засгийн газрын хоорондын хэлэлцээр шиг батлаад өгвөл бүтээгдэхүүн солилцооны энэ асуудал тухайн төсөл дээрээ явна. Батлахгүй бол зогсоно гэсэн ийм логикоо гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Говийн бүсийн гишүүний хувьд говийн бүсээс Монгол Улсын сангийн авдрын бараг 70, 80-аад хувийг төсвийн орлогыг бүрдүүлж байгаа.

Зөвхөн Өмнөговь аймаг гэхэд 1.7 их наяд, Замын-Үүд сум гэхэд зөвхөн гаалийн орлогоосоо их наяд гаруй төгрөгийг улсын төсөвт орлого болгож өгч байна.

Дээрээс нь манай бүсэд баяжуулах үйлдвэрүүд, боловсруулах үйлдвэрүүд баригдаж байгаа. Хувийн хэвшлийн хийсэн. Төрөөс хэзээ ч хийж чадахааргүй байсан тийм үйлдвэрүүд ашиглалтад орж байгаа.

Тэгэхээр хүсэх юм энэ хууль дээрээ дотоодын боловсруулах, баяжуулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангаад өрсөлдөхүйц бүтээгдэхүүн гаргаж экспортлох боломжийг нь хууль эрх зүйн хувьд сайн оруулж өгөхийг хүсье.

Мөн говийн усны төслийг. Ц.Туваан сайд өчигдөр Байнгын хороон дээр 14 мега төслийг эрэмбэлнэ гэж яриад байсан шүү дээ. Хэрвээ эрэмбэлэх юм бол хамгийн эхэнд говийн Орхон, Хэрлэн-Тооно.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би гурван асуулт асууя.

Уул уурхайн биржийн тухай хууль маань өөрөө 2022 онд батлагдсан. Хуулийн хэрэгжилтийн үнэлгээ гэдэг юмыг яг хийж байсан уу? Ядаж хэсэгчлээд гэсэн үг. Тийм ээ.

Тэгэхээр хуулийн хэрэгжилт дээр хаана ямар асуудал байгаа гэдгийг мэргэжлийн арга зүйн үүднээс нь хийсэн үү гэдгийг нэг тодруулъя. Танилцуулга материал дээр энэ ерөөсөө орж ирээгүй байсан.

Хоёрдугаарт, хуульд орж байгаа нэмэлт, өөрчлөлттэй холбоотой эрх ашиг нь хөндөгдөж байгаа уул уурхайн компаниуд гээд олон оролцогч талууд байгаа. Тэдгээр саналыг авсан уу, хэлэлцүүлэг хийгдсэн үү?

Хэдийгээр яаралтай горимоор орж ирж байгаа ч гэсэн бас энэ асуудал дээр ямар үйл ажиллагаа явуулсан бэ?

Дагалдаж орж ирж байгаа Цөмийн энергийн тухай хууль гээд. Би П.Сайнзориг гишүүнтэй санал нэг байна. Цөмийн энергийн тухай хууль яагаад энэ хуулийг дагалдаж орж ирж байгаа юм бэ? Тэгээд бүхэл бүтэн хэрэгжүүлэгч агентлаг байгуулагдахаар орж ирж байна. Энэ чинь бүр шал өөр бүтцийн. Энэ хуулийнхаа үзэл баримтлалтай нийцэхгүй ийм асуудлуудыг бид дагалдуулж оруулж ирж байгаагаа цаашдаа анхаарах хэрэгтэй.

Гурав дахь асуулт. Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага нь шийдвэрлэнэ гээд аль алийг нь “болно” гээд

оруулсан байна. Энэ чинь өөрөө хууль тогтоомжийн тодорхойгүй байдлыг үүсгэхгүй юу?

Тэгэхээр яагаад үүнийг заавал ингэж болно гэж аль алин дээр нь оруулж ирж байгаа юм бэ гэсэн ийм асуулт байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Энэ хууль хэрэгжээд явж байгаа. Маш хэрэгтэй хууль. Нэлээн олон асуудлуудыг зохицуулсан. Орлого төвлөрүүлэх байдлаар асуудлыг шилэн нээлттэй болгох, шударга болгох, үнийн өрсөлдөөнтэй болгох гэдэг асуудлуудыг зохицуулдаг хууль.

Мэдээж амьдрал баян учраас цааш нь жоохон сайжруулах, ялангуяа сүүлийн үед үүсээд байгаа борлуулалтын гацаатай байдал зэргээс болж бид Засгийн газар яалт ч үгүй амьдралын шаардлагаар гэдэг шиг оруулж ирж байгаа хууль гэдгийг Та ойлгоорой.

Дээрээс нь хэрэгжилтийн үнэлгээн дээр манай төрийн нарийн хяналт шинжилгээнээс мэдээлэл аваад сүүлд нь нэмээд хариулчхаарай.

Уул уурхайн компаниудаас авалгүй яах вэ. Бид энэ хуулийн төсөл дээр суухдаа бүр хэдэн өдөр ажлын хэсэг байгуулж, яаман дээр, ордонд бүгдийг нь цуглуулж байгаад нэлээн их хэлэлцүүлэг Засгийн газар дээр ч хийсэн, яаман дээр ч хийсэн гэдгийг хэлье.

Энэ өөрөө төрийн болон төрийн өмчит, орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хэдхэн компанийн хуулийн хүрээнд заавал биржээр арилжих асуудал орж байгаа юм.

Одоо ингээд л нэрлэх юм бол “Эрдэнэс Тавантолгой”, жижиг Тавантолгой гэж бид яриад байдаг “Тавантолгой” хувьцаат компани, “Дархан төмөрлөг”, “Эрдэнэт” гэсэн ийм үйлдвэрүүд. Тэр сүүлд нь “Эрдэнэс критикал минерал” болсон “Монголросцветмет” гээд ийм л компаниудын хүрээнд энэ хуулийн зохицуулалт явагдаж байгаа.

Тэгэхээр хэлэлцүүлэг хийж энэ компаниудтайгаа сууж ажилласан. Өнөөдрийн ажлын хэсэгт ч гэсэн энэ компаниуд маань орж ирсэн сууж байгаа гэдгийг гишүүнд хэлье.

Цөмийн энергийн хууль яагаад орж ирж байгаа вэ гээд. Энэ хэлэлцэгдэхгүй орхигдоод маш удсан байсан ийм асуудал юм. Бид хэд бас үүнийг зохицуулахгүй бол Олон улсын атомын энергийн агентлагийн өмнө хариуцсан асуудлууд байна. Маш олон конвенцоор хүлээгдсэн үүргүүд байна. Мэдээллээ өгөх.

Дээрээс нь энэ “Орона”-тай холбоотой асуудлыг яг барьж аваад хэрэгжилтийг нь хангуулаад явах асуудал байна. Цаашдаа Чех, Хятад, Оростой гээд маш олон ураны төслүүд хэрэгжих гэж байна. Ийм асуудлууд бид нарт байгаа.

Тэгэхдээ бид 2025 оны төсөв батлагдсан учраас энэ дээр ямар нэгэн орон тоо нэмэх асуудал байхгүй. Цөмийн энергийн эрхлэх асуудал Боловсролын сайдын хүрээнд байж байгаад уул уурхайн салбарын Засгийн газрын төв байгууллагын харьяанд ирсэн.

Энэ дээр нийтдээ 33 хүн байгаа. Энэ 33 хүний тоо нэмэгдэхгүй.

Дээрээс нь зохицуулалтгүй орхигдсон нэг харилцаа бол салбарын энэ цөмийн энерги хариуцсан хяналтын нийслэлд ажиллаж байсан 9, салбар дээр ажилласан 6 байцаагчийн асуудал энд хаана харьяалагдах нь мэдэгдэхгүй байж байгаа.

Тэгэхээр агентлаг хэрвээ байгуулагдвал байцаагч нар цөмийн энергийн агентлагтаа ороод явах юм л гэсэн логик.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт. Ажлын хэсгээс. Ажлын хэсгийн 10 дугаар микрофон.

Б.Жавхланбаатар: Д.Ганмаа гишүүний асуултад нэмж хариулъя. Б.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга.

Хуулийн төслийг нэн яаралтай журмаар өргөн барьсан байгаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-ийг үндэслэсэн. Нэн яаралтай журмаар учраас таны асуусан нөлөөлөх байдлын үнэлгээнүүд хийгдээгүй байгаа.

Гэхдээ үзэл баримтлалыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд баталж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн барьсан.

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн асуулт асууя.

Д.Батбаяр: Өдрийн мэндийг хүргэе.

Тэгэхээр Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль маш чухал ач холбогдолтой хууль болоод байгаа юм. Ялангуяа улс нь өөрөө уул уурхайн бизнес хийдэг учраас манай нөхцөлд борлуулалтыг нь шилэн байлгах, бүгдэд

ил байлгахын тулд биржийн хуулийг баталсан. Тодорхой хэмжээгээр үүргээ биелүүлээд явж байгаа.

Гэхдээ энэ нь засаж сайжруулах шаардлагагүй гэсэн үг биш. Тийм учраас сайжруулаад явах ёстой.

Ер нь уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтыг зөвхөн гадагшаагаа чиглүүлж ирсэн нь өөрөө дотоодын боловсруулах үйлдвэрүүдийн хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа юм. Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг гаргах энэ сэдлийг нь байхгүй болгож байгаа юм.

Үүний нэг жишээ бол манай Дархан, Сэлэнгэ. Дарханы төмөрлөгийн үйлдвэр бүтэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна.

Мөн Дархан хотыг тойрсон бага оврын хувийн аж ахуйн нэгжүүдийн боловсруулах үйлдвэрүүд бүгдээрээ хаалгаа барьсан. Ажлын байр байхгүй болсон. Иргэдийн орлого тасарсан ийм л байдалтай байгаа юм.

Тийм учраас энэ хуулийг засаж сайжруулах, шинэчлэн өөрчлөх нь нэн чухал байгаа. Энэ утгаар нь хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа.

Тэгээд шинээр орж ирж байгаа хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 10.5 дээр нь заасан байна л даа. Уул уурхайн бүтээгдэхүүний баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж экспортлох зорилгоор дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт биржээр дамжуулах арилжиж болно гээд. Энэ заалт маш зөв заалт болоод байгаа юм л даа.

Тэгэхдээ энэ дээр анхаарах нэг асуудал байгаад байна. Ц.Туваан сайд аа. Тэр нь юу вэ гэхээр дотоодын баяжуулах үйлдвэрүүд чинь яг биржийн худалдаанд оролцоход гаднын том том компаниудтай үнэ хаялцаад оролцох боломж нь байхгүй.

Тэгэхээр дотоодын боловсруулах баяжуулах, үйлдвэрүүдийг нэгэнт дэмжье, биржийн худалдаанд, борлуулалтад оролцуулъя гэж байгаа бол яг энэ сул талыг нь байхгүй болгох тал дээр ямар бодлого барих вэ? Яг энэ хууль дээр ахиад дэлгэрэнгүйгээр зааж өгөх бололцоо байгаа юу? Ахиад Засгийн газрын журмаар ч юм уу шийднэ гэдэг байдлаар оруулах юм бол ахиад л засах, ахиад л засварлах хэрэг гарч ирж таарна.

Яг боловсруулах үйлдвэр маань өөрөө бага агуулгатай хүдрийг л боловсруулж байгаа. Бага агуулгатай хүдэр өнөөдөр жишээ нь Дарханы төмөрлөгийн үйлдвэр дээр маш их хэмжээгээр хадгалагдаад үлдсэн. Тэгээд энэ бирж дээр орж ирээд яг ингээд үнэ хаялцаад явна гэх юм бол манай үйлдвэрүүд чинь өрсөлдөх боломжгүй болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тусгай нөхцөл байдаг юм уу, яадаг юм. Яг зах зээлийнхээ зарчмаар үнэ хаялцаад явахад манай үйлдвэрүүд өрсөлдөж чадахгүй. Үүнийгээ хууль дээрээ бас нэг жоохон тусгаад өгмөөр байна.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Далайн Батбаяр гишүүнд баярлалаа. Дэмжиж байгаад.

Тэгээд бас асуудал нь ч гэсэн маш тодорхой зөв зүйтэй асуудлыг хөндөж байна. Ялангуяа төвийн бүсээс Дархан-Уул аймагт үүссэн нөхцөл байдалтай холбоотой энэ тойргоос сонгогдсон гишүүний хувиар маш нарийн сайн мэдээлэлтэй байгаа учраас энэ асуултыг асууж байна.

10.5 дээр энэ зохицуулалтыг оруулж ирсэн.

Түрүүн бид хэлээд байгаа юм. Энэ Уул уурхайн биржийн тухай хууль хэрэгжээд 2 жил болж байгаа. Энд концепцын хоёр л асуудал байгаа юм.

Нэгдүгээрт нь, уул уурхайн бүтээгдэхүүнийг төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой гээд. Ийм л компаниуд энд оролцоно.

Дээрээс нь эндээс биржээр “заавал” гэдэг концепц явж байгаа. Хууль дээр байгаа. Заавал арилжина.

Тэгэхээр бид биржээр оруулахаас өөр гарц байхгүй.

Тэгэхээр түрүүн бас Ж.Ганбаатар гишүүний үгэнд ч гарч байсан. Энэ хуулийн амин сүнс тэй холбоотой асуудал ярьж байгаа.

Тэгэхээр амин сүнс нь “заавал биржээр арилжих” гэдэг дээр байгаа.

Дээрээс нь дараагийн бас нэг зарчмын асуудал нь “экспортод чиглэх” гэдэг зарчим байгаа юм.

Тэгэхээр мэдээж баяжуулах үйлдвэрүүд маань бас худалдаж аваад нэмээд дахин боловсруулалт, баяжуулалт хийгээд экспортод гаргах зорилготой. Үүнийг нь бид дэмжиж өгсөн гэдгийг хэлье.

Дээрээс нь, хэлэлцэх эсэхээ шийдээд, хэлэлцүүлгийн шатад таны бүрэн эрх дээр энэ дээр зарчмын зөрүүтэй санал оруулах, дээрээс нь ажлын хэсэг дээр ажиллаж заалт нэмэх гэсэн энэ бүрэн эрхүүд нь байгаа гэдгийг хэлье.

Тэгэхээр таны саналтай санал нэг байна.

Д.Амарбаясгалан: Далайн Батбаяр гишүүн тодруулж асууя.

Д.Батбаяр: Баярлалаа.

Тэгэхээр хэлэлцэх эсэх нь шийдэгдээд ажлын хэсэг байгуулагдах юм бол ажлын хэсэгт орж ажиллах сонирхолтой байгаа гэдэг үгээр мэдэгдье.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Өдрийн мэнд хүргэе.

Биржийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт орохоор төсөл орж ирж байна. Одоо ирсэн байгаа материалтай танилцаад үзэхээр 6 гол агуулгыг хөндөж байна гэж үзэж байгаа. Үүнийгээ тайлбарлана.

Тэгээд түрүүн Х.Баасанжаргал гишүүн, П.Сайнзориг гишүүдийн асуултыг сонсоод, хариултыг авахаас өмнө энэ 6 агуулгын 4-ийг нь хүлээн зөвшөөрөх юм гээд бодож байлаа. Одоо бол нэг дээр нь л ирээд л байна л даа.

Тэгэхээр хэлэлцэх эсэхийг нь бүгдээрээ бас сайн тунгааж шийдэх ёстой байх.

Санал нэгдэж байгаа ганц байгаа зүйл нь уул уурхайн бүтээгдэхүүнийг дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт биржээр дамжуулан арилжихыг нээж өгөх ёстой. Энэ орхигдсон байсан зүйл. Тэгэхдээ өгүүлбэр нь бас “болно” гээд төгссөн байгаа. Тэгэхээр энэ ямар учиртай юм бол? Хэрвээ хэлэлцэх нь шийдэгдэх юм бол ажлын хэсэгт орохдоо “арилжина” гэдгээр нь, одоогийн байгаа хуулийн үг, өгүүлбэрийн агуулгатай нь төстэй байдлаар оруулах ёстой байх.

Хоёрдугаарт, бүтээгдэхүүний үнэд зах зээлийн үнийн индексийн хөдөлгөөн хийнэ гээд байгаа юм. Чанар дээр О.Батнайрамдал гишүүний саналтай 100 хувь санал нэг байгаа. Чанар нэлээд хэцүү зүйл. Тэгээд манай нүүрсний чанар сайн байх юм бол тэгээд үнэ маань өсөх юм. Тэгэхээр үүнийг тогтооход ч хэцүү дээ.

Тэгэхээр үнийн индекстэй холбоотой би ойлгохдоо Хөрөнгийн биржийн Б.Дөлгөөн захирал хариулах байх. Индексийг нь нэг оруулсан байдлаар журмаар шийдвэрлэх талаар ярьж байсан даа.

Тэгэхээр энэ дээр бас тайлбар хийгээд өгөөрэй. Б.Дөлгөөн захирал аа.

Үүнийг ер нь дэмжиж байгаа. Үнэ буурч байгаа үед яах вэ, үнэ нь ихсэж байгаа үед яах вэ гэдэгт нь хөдөлгөөнийг оруулдаг байх ёстой. Яаж оруулах вэ гэдгийг нь мэргэжлийн хүмүүс нь шийдэх байх.

Гуравдугаарт, дагах хуулиар Цөмийн энергийн агентлагийг байгуулах нь миний л ойлгосноор сая хуульч гишүүдийн хэлснээр тусдаа үзэл баримтлалдаа орж ирэх ёстой байсан байх юм. Тэгээд үүн дээр бас энэ үзэл баримтлал гээд бид дээр орж ирсэн материал дээр О.Алтангэрэл сайд гарын үсэг зурсан байх юм.

Тэгэхээр хуулиа мэдээж зөрчиж зураагүй байлтай. Яах ёстой юм бол. Мэдэхгүй. Үнэхээр шаардлагатай бол тусад нь дахиад Цөмийн энергийн агентлагаа оруулаад явмаар юм.

Тэгээд ер нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамандаа ажиллаж байсны хувьд угаасаа дотор ажиллаж байгаа хүмүүсийнхээ ямар чадвартайг ч мэдэж байгаа учраас тэд нарынхаа хийсэн бүх зүйлийг дэмжээд явдаг. Чадварлаг хүмүүс ажилладаг юм.

Гэхдээ энэ урантай холбоотой асуудал дээр дуугарсан гишүүд нь адлуулаад, яг яам нь олигтой хариултыг өгөхгүй л байгаа. Тэгээд Цөмийн энергийн агентлаг байгуулаад өгдөг болоод, яг хамгаалдаг болох юм болов уу? Гэхдээ цөмийн энергийн алба нь байгаа шүү дээ.

Тэгэхээр тэр цаанаа олон улсдаа хүлээсэн үүргээрээ мэдээллээ өгөөд явах субъект нь байж л байгаа. Тэгэхээр энэ асуудал бас ингээд эргэлзээтэй болоод явчхаж байгаа юм.

Дөрөв дээр нь, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь бүтээгдэхүүн солилцох гэрээ буюу том том бүтээн байгуулалтаа дэмжье гэж байгаа юм. Энэ нь одоогийн хууль дээр байгаа л заалт шүү дээ.

Тэгээд **“стратегийн”** гэдэг үгийг нь л авч байгаа юм билээ. Тэгээд үүнийг бас эргэлзээд эхэллээ.

Тавдугаарт нь, биржийн арилжааны үнэд “ам нөхцөл”-ийг эргэн сэргээхтэй холбоотой.

Энэ дээр би түрүүн гишүүдийн групп дээр D-Parliament-ын линкийг оруулсан. Яг энэ 14.1 гэсэн заалт D-Parliament дээр харагддаггүй. Ц.Туваан сайд аа. Тэгээд download хийхээр харагдаад байдаг.

Тэгэхээр чинь хэлэлцүүлэг яаралтай гээд хийгдээгүй. Тэгээд ямар нэгэн байдлаар D-Parliament дээр орж ирэхдээ яг энэ заалт нь орж ирээгүй.

Тэгэхээр хэн ч мэдээгүй. Ингээд үзэл баримтлалдаа болохоор “Олон улсын худалдааны танхимаас гарсан журмыг батална.” гээд. Танхимаас журам баталдаггүй. Тэгээд зүгээр худалдааны нөхцөлийг л ярь.

Тэгэхээр үүнийг одоо яах вэ? Тэгээд миний минут дуусах гээд л байх юм. Эхлээд Б.Дөлгөөн захирлаас үнийн индекстэй холбоотой хөдөлгөөн хийх асуудлыг журмаар тодорхойлох эсэх дээр нь хариултыг авъя даа. Тэгээд дахиад үргэлжлүүлээд асууя.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон өгье. Хариулт өгье.

Б.Дөлгөөн: Б.Уянга гишүүний асуултад хариулъя. Хөрөнгийн биржийн захирал Б.Дөлгөөн байна.

Энэ “үнийн индекс”, “чанарын индекс” гэдэг, энэ “чанарын тохируулга” гэдгийг яах аргагүй Монголын хөрөнгийн биржээс оруулсан санал байгаа.

Энэ нь ямар учиртай юм бэ гэхээр түрүүн О.Батнайрамдал гишүүний хэлснээр үнэ унахад ч гэсэн арилжаа явагдаж байдаг, үнэ өсөхөд ч гэсэн арилжаа явагдаж байдаг энэ зарчмыг баримталж ирээдүйд олон улсын жишигт дөхүүлэхийн тулд энэ өөрчлөлтийг оруулах зайлшгүй шаардлага байгаа.

Яг одоогийн хуулиар энэ индексийг “ашиглаж болно”, “ашиглахгүй байж болно” гэсэн тодорхой заалт байхгүй байгаа.

Тэгээд Хөрөнгийн биржийн ТУЗ-аар үнийн индекстэй холбоотой арилжааг идэвхжүүлэх талаас тодорхой журмуудад өөрчлөлт оруулсан. 03 сарын 19-ний өдөр өөрчлөлт оруулаад Санхүүгийн зохицуулах хороогоор баталсан байгаа. Улмаар өнөөдрийн арилжаанууд огцом өөрчлөгдөөд явж байгаа.

Тэгэхээр 3 сарын сүүлээр орсон өөрчлөлтүүдээс улбаатайгаар өнгөрсөн долоо хоногт жишээлбэл 500 мянган тонны арилжаа явагдсан байгаа. Шинэчилсэн журмаар гэсэн үг. Энэ долоо хоногт бид дахиад 600, 700 мянган тонны арилжааг явуулахаар ажиллаж байна.

Тэгэхээр үнэ унасан ч арилжаа явагдаж байдаг, үнэ өссөн ч арилжаа явагдаж байдаг. Ийм учир шалтгаан дээр хууль дээрээ маш тодорхой оруулах юм бол цаашид арилжаанд маш эергээр нөлөөлөх боломжтой гэж үзэж байгаа юм.

Чанарын хувьд тантай санал нэг байгаа. Юу вэ гэхээр чанар дээр бид яг 100 хувь гүйцэтгэл гаргаад явна гэдэг бол хүнд ажил гэдэгт итгэлтэй байна. Гэхдээ олон улсын биржээр бид бараа, бүтээгдэхүүнээ ирээдүйд зарна гэдэг зорилт тавьж байгаа чанар дээр анхаарахгүй бол худалдан авагчдын дараагийн тавьж байгаа гомдол саналын хамгийн их хувийг чанар эзэлж байгаа.

Тэгэхээр нэгэнт бид маргааш яг энэ чанараа өөрчлөөд, эсвэл 05 сарын 01-ээс чанар дээр 100 хувь огцом шийдэл гаргахгүйгээр харин хууль дээрээ бид тусгаад, харин чанарыг олон улсын биржийн түвшин, стандартад хүргэхийн тулд гурав, дөрвөн алхмын өөрчлөлтүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх юм бол дараа жилийн өдийд гэхэд бид олон улсын биржээр зарах түвшинд чанар стандарт, лабораторийн дамжлагуудыг бүгдийг нь хийж чадна гэдэгт би итгэлтэй байна.

Тэгээд яагаад итгэлтэй байгаа вэ гэхээр Монголын хөрөнгийн бирж дээр өнгөрсөн 2 сарын хугацаанд ажиллаад тодорхой замын зургийг гаргасан. Чанар дээр бид олон улсын лабораториудтай хэд хэдэн удаагийн уулзалт хийсэн. Online call-ийг хийсэн байгаа. Тэгээд замын зургийг нь гаргаад ажиллаад явж байна.

Д.Амарбаясгалан: Болдын Уянга гишүүн тодруулж асууя.

Б.Уянга: Энэ хуулийн төслийн өөрчлөлтийн 5 дахь агуулгыг нь сая Б.Дөлгөөн захирлаас хариулт авлаа.

Тэгэхээр хуульд заагдсан, заагаагүйгээр Хөрөнгийн бирж өөрсдөө дотоод журмаараа индексийг оруулаад ирээд амжилттай явж байгаа жишиг гарч ирсэн байгаа юм.

Зургаа нь, дотооддоо борлуулах журмыг яам өргөн бариад засаг батална гээд. Тэртээ тэргүй нээгээд өгчхөж байгаа юмыг чинь яам орж журам батлах нь илүүц байх. Үүнийг дэмжихгүй байгаа юм.

Биржийн тухай хууль батлагдах болсон үндсэн шалтгаан нь энэ “ам нөхцөл”-тэй холбоотойгоор маш олон сайхан залуусын нэр нь хугарсан учраас баталсан шүү дээ. Ц.Туваан сайд аа.

Тэгээд бүгдээрээ дахиж олон сайхан залуусын нэрийг хугалах ийм зүйл рүү ухарч болохгүй байх аа. 1.5 жил, 2 жил ч хүрээгүй хэрэгжээд явж байгаа хууль нь нэг голдиролдоо орж байтал ухарч болохгүй байх аа.

Тэгээд энэ 6 агуулгын 5-ыг нь дэмжихгүй байгаа учраас хэлэлцэх эсэхийг нь яагаад ч дэмжиж чадахгүй юм байна.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу? Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Биржийн тухай хуулийн өөрчлөлт үнэхээр бас нэг тийм урагшлах биш ухрах араандаа хийсэн нэг ийм л хуулийн өөрчлөлт орж ирж байгаа.

Энэ дээр гишүүд байр сууриудаа хэлж байна. Би Байнгын хороон дээр ч бас байр сууриудаа хэлсэн. Нэмээд нэг зүйлийг асууж тодруулъя. Бас байр суурь илэрхийлье.

Зөвхөн энэ “бартер” гэдэг үгийн цаана зөвхөн эдийн засгийн нэг арилжаа, хувилбар гэдэг зүйл энд гарч ирж байгаа төдий биш. Би бас үүнийг Сангийн сайдаас, Сангийн сайд байна уу. Бас хариулаасай гэж хүсэж нэг асуулт тавих гээд байгаа юм.

Энэ өөрөө бартер гээд арилжаа юм шиг. Гэтэл үүний цаана улсын төсвөөр дамжиж хийгдэх бүтээн байгуулалтын гэдэг ажлыг төрийн өмчит компани гэрээлээд шууд хийлгэх юм байна л даа.

Тэгэхээр энэ чинь Монгол Улсын Их Хурлаар ордог, Монгол Улсын нэгдсэн төсвөөр дамждаг, төсвөөр хийдэг санхүү, эдийн засгийн төсвийн тогтсон тогтолцоог чинь нураах нь байна шүү дээ. Энэ чинь одоо. Төрийн өмчит компани бартераар нэг гэрээ хийлээ. Тэрийг очоод сургууль, цэцэрлэг ч барина гэнэ, баахан бүтээн байгуулалтын гээд гоё нэртэй ажлуудыг хийнэ.

Гэтэл энэ чинь төсвөөр орохгүй, Улсын Их Хурлаар орохгүй, Улсын Их Хурлын тэр хөрөнгө оруулалтын хэсэгт суухгүй. Улсын Их Хурлаар хэлэлцэнэ гэж байгаа юм. Тэгэхдээ Монгол Улсыг хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх төсөвтэй нь болгох нь байна шүү дээ.

Ингээд үүний цаана дахиад нөгөө нэг том төр гэдэг чинь, төрийн өмчит аж ахуйн нэгж гэдэг чинь яаж данхайж байна, томорч байна. Үүнийг дагаад засаглалгүй, авлигалын асуудал руу орж байна гэж бид үздэг, ярьдаг. Үглэсээр л ирцгээдэг. Гэтэл нөхцөл байдал яг улам л энэ рүү чинь улам өдөөсөн ийм тогтолцоо руу орох юм биш үү? Биш үү ч гэж дээ. Одоо үүнийг бас ингээд янз бүрээр л та нар “үгүй”, Улсын Их Хурлаар тэгнэ, ингэнэ гээд ярина л даа.

Тэгэхдээ л энэ чинь төсвийн гадуур төрийн өмчит компани дээр асуудал шийдэгддэг. Нөгөө OFFTAKE гэрээний асуудлуудыг бид ярьж байсан. Улсын Их Хурал дээр төсөв гээд 3 их наядын төсвийн хөрөнгө оруулалтыг хуучин 76 гишүүн, сая 126 гишүүн 40-өөд хоног намаржингаа ярьдаг.

Гэтэл 18 их наядын OFFTAKE гэрээг төрийн өмчит компани дээр хийгээд хаясан байсан шүү дээ.

Улсын төсвөөр ярьдаг хөрөнгө оруулалтаас 6, 7 дахин ихийг төрийн өмчит компанийн захирлаар гарын үсэг зуруулаад, улсын нууцад аваад, тэгээд үүнийгээ хөрөнгө оруулалтын ажил, гоё гоё ажлуудад нэрлээд хийсэн.

Яг л үүнийг чинь одоо бүр ингээд тэр гарсан авлигалын схем, авлигалын сүлжээг чинь одоо нэг гоё нэрийн доор яг хуульчлах гээд байна шүү дээ. Бүр

ингээд хууль ёсны болгож, төсвөөс гадуур, Улсын Их Хурлаас гадуур бүтээн байгуулалтын ажил нэртэйгээр санхүү, эдийн засгийн тогтолцоог нураах ийм л хор, одоо тийм үр дагавар өндөртэй ийм нэг гэрээний зүйл, заалт л яриад байна гэж бодож байна. Энэ дээр Сангийн сайдыг бас нэг тайлбар өгөхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Ийм юм байгаа юм. Монгол Улс нэг хүнд ногдох газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийд нэгд. Нэг хүнд ногдох байгалийн баялгаараа эхний 20-д.

Гэтэл нэг хүнд ногдох үндэсний орлогоороо 100-аас хойш байгаа юм. Энэ хоорондох зөрүү хаана байгаад байна вэ? Үүнийг бид эргэлтэд оруулж чадахгүй хоцроод байгаадаа л учир байгаа юм.

Тэгэхээр бид жил ирэх тусам төсвөөс хамааралтай эдийн засаг, төсвөөс хамааралтай улс орон гэдгээ багасгая гэдэг энэ зарчим руугаа орсон. Та бид цуг сууж байгаад үүнийгээ концепцоо шийдсэн.

Тийм учраас бид газрын доор байгаа энэ түүхий эдээ баялаг болгож ашиглах нь өнөөдөр бидний хамгийн том зорилго болж ирж байгаа.

Тэгэхээр төсвөөс гадуур гэдэг ойлголтоо бид төсөв, төсөвтэй эн зэрэгцэх тэр түүхий эдийг яаж баялаг болгох вэ. Төсвөөрөө бид эмч нарынхаа цалинг тавья, багш нарынхаа цалинг тавья. Харин бүтээн байгуулалт, хөгжлийг урагшлуулдаг энэ том асуудлуудаа бид яаж ямар эх үүсвэрээр, өөр боломжит ямар боломжууд байна тэр болгоныгоо бид тодорхойлж хуульчилж байгаа нь л энэ.

Их Хурал өөртөө улам л итгэлтэй л болох ёстой шүү дээ. Бид энд хуульчилж байна. Хуульгүй байж болохгүй. Хэлэлцэх ёстой. Хуульчилж дүрэмтэй болгож цаашаагаа яаж явах вэ л гэдгээ тодорхойлох гэж байгаа юм.

“Баялгийн солилцоо” өөрөө шинэ харилцаа. Шинэ харилцаа. Бидэнтэй ижилхэн байгалийн баялагтаа өнөөдөр бид нарын туулж байгаа энэ шийдэл хүлээсэн зовлонтой асуудлуудыг 20, 30 жилийн өмнө туулаад өнгөрүүлсэн. Өнөөдөр тодорхой үр дүнд хүрсэн дэлхийн туршлагууд байна.

Бид суралцах ёстой. Мууг нь хаяад сайныг нь авч хэрэглээд эндээ хөрсөн дээрээ буулгаад, эндээ хэлэлцээд Их Хурлаараа хууль болгоод цаашаа явах нь л чухал. Хуульгүй явж болохгүй. Хууль болгож орж ирж байгаа чинь өөрөө энэ маш чухал байхгүй юу. Бид нарын парламентын засаглалтай энэ улс орны маань хамгийн гол үнэт зүйл энэ.

Хөрсөн доор байгаа түүхий эдийг баялаг болгох нь бидний нэг том боломж.

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах юм уу? Б.Жавхлан сайд. Болсон уу?

Яах вэ, О.Цогтгэрэл гишүүний асуугаад байгаа нэг л зүйл байгаа шүү дээ. Засгийн газар 2025 онд жишээ нь 80 сая тонн нүүрс экспортод гаргана гээд төлөвлөсөн байж байгаа. Тийм ээ.

Тэгэхээр энэ бартерын харилцаа, баялаг солилцооны харилцаа ороод ирэхээр тэр 80 сая тонн дотор чинь орвол яах юм? Орохгүй юм уу? Эсвэл тусдаа харилцаа үүсэх юм уу? Үүнийг л тодорхой хариулах юм бол болох юм шүү дээ.

Тэгэхээр Б.Жавхлан сайд энэ дээр гүйцээгээд хариулъя.

Б.Жавхлан: Төсвийн хууль гэдэг өөрөө хууль. Хууль дээр цэг, таслалгүй тоо бүгдийг нь заасан байдаг.

Тийм учраас энэ хоорондоо холилдох юм байхгүй. Нэмэгдэж хасагдах юм байхгүй. Бид төсвийн хуулиа л барих ёстой.

Нэмэгдэж гарч байгаа энэ асуудлууд тусдаа өөр асуудал шүү. Өөр асуудал. Төсвийн хуулиас тусдаа яригдах эх үүсвэр л гэж ойлгох хэрэгтэй. Төсвийн хуультай ерөөсөө уялдаж болохгүй.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Цаад авах гэж байгаа гадаад улсын эрэлт чинь тогтмол нэг л дүнгээр байна л даа. Тэр дотор ихэнхийг нь баялгийн солилцоо гээд гоё нэрээр бартердаад өгнө. Нөгөө талд нь тэр бэлэн мөнгөөр хийгддэг, биржээр хийгддэг, зах зээлийн өрсөлдөөнөөр хийгддэг арилжаа гэдэг зүйл чинь өөрөө асар.

Нэгдүгээрт нь, үүгээрээ зах зээлээ эвдэх юм. Дахиад миний хэлээд байгаа нь Б.Жавхлан сайд та Их Хурлаар ороод хууль болоод батлагдвал ямар байдлаар явсан ч ер нь яадаг юм гэдэг л юм хэлж байна л даа.

Гэтэл энэ хуулийн чинь эх үүсвэр нь Монгол Улсад салбар салбарт тогтсон систем, тогтолцоо гэж юм байгаа шүү дээ.

Монгол Улсад өнөөдөр санхүү, эдийн засгийн төсөв, татвар энэ бүх бодлого чинь Улсын Их Хурлаар дамжиж, улсын төсвөөр дамжиж, хэрвээ

төрийн өмчит компани бол төрийн өмчит компани ашигтай ажилласан бол ногдол ашгаа улсын төсөвт хураалгаад, энэ ноогдол ашгаар улсын төсвийн зарлага талыг санхүүжүүлдэг шүү дээ.

Гэтэл үүнээс гадуур энэ бүгдийг явуулна.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: О.Цогтгэрэл гишүүн ээ. Ийм л юм байгаа юм л даа. Одоо нэг хүнд ногдох үндэсний орлого маань дөнгөж 7 мянга гарч байна.

Гэтэл бид байгалийн баялгаараа дэлхийн топ 20 улсын нэг нь. Одоо тэгээд хэдүүлээ ингээд байгаад байх уу. Төсвөө бид нэлээн журамлаад, төсвөөс хамааралтай эдийн засгаа багасгаад яваад байдаг. Гэтэл байгалийн баялаг нь байгаад байдаг. Үүнийг яаж эргэлтэд оруулж, айл өрх бүрд, хүн бүрд хүргэх вэ л гэдэг л ийм л шийдлийг бид ярьж байгаа шүү дээ.

Ингэж байгаа юм. Та хардаа. Одоо хууль болбол хууль яадаг ч юм биш шүү дээ. Хууль хууль. Та бид сууж байгаад энэ хуулийг батална. Батлах эсэх нь эндээ шийдэгдэнэ. Нэгэнт батлагдсан хуулийг тэгээд л бид хууль гээд хэрэгжүүлнэ шүү дээ.

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайд аа, О.Цогтгэрэл гишүүн болон ер нь гишүүдийн асуугаад байгаа зүйл юу юм бэ гэхээр бидний гаргадаг нөөц боломж маань хэмжээтэй. Худалдан авагч талын худалдаж авдаг нь бас төлөвлөгөөтэй, хэмжээтэй.

Тэгэхээр бид мөнгөөр зардаг зүйлээ дотор нь “баялаг солилцоо” гэж оруулж ирэхээр яг энэ хэмжээн дотор чинь баригдахаар асуудал яах вэ л гэдэг зүйлийг яриад байна л даа. Тийм ээ.

Жишээлбэл, Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтоор гардаг экспортын бүтээгдэхүүний хэмжээ нэг тогтсон байж байдаг. Хүчин чадал нь түүндээ нийцсэн байж байдаг.

- Ханги-Мандал,
- Шивээхүрэн,
- Замын-Үүд,
- Бичигт гээд.

Одоо энэ Булган-Такашикэний боомтоор гардаг хүчин чадлууд чинь яг тогтсон хэмжээтэй л байгаад байна шүү дээ.

Тэгэхээр **хэмжээндээ тулаад**, **“мөнгөөр зардаг”** дотор **“баялаг солилцоогоор зардаг”** чинь орж ирнэ шүү гэдэг асуудал хөндөгдөж байна гэсэн үг. Тэгээд үүнийгээ сайн бодож тунгаана биз.

Тэгээд нэгэнт Засгийн газар дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой, түүхий эдийн үнийн уналттай холбоотойгоор биржээр зарж байгаа харилцаан дээр хүндрэл үүсэж байна.

Үнэ унаад ирэхээр биржээр зарагдах нөхцөл улам бүр удааширч байна. Энэ нь өөрөө улсын эдийн засагт оныхоо төгсгөлд маш том сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэл бий болж байгаа учраас ийм хуулийн өөрчлөлт хэрэгтэй байна гэдэг байдлаар яаралтай горимоор энэ хуулийн төслийг өргөн барьж орж ирсэн.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бид огт хэлэлцэхгүй гээд буцааж болохгүй байх л гэсэн байр суурь байгаа юм.

Зүгээр хэлэлцэх эсэхээ шийдээд, Улсын Их Хурал дээр маш өргөн хүрээний ажлын хэсэг байгуулагдаад, гишүүдийн хөндөөд байгаа асуудлуудыг Улсын Их Хурлын ажлын хэсгийн түвшинд засаад, янзлаад шинэ гарцаа бий болгоод явах нь зөв байх л гэж бодож байгаа юм.

Болохгүй гээд буцаахаар Засгийн газар дээр өөр гарц байхгүй. Ингээд улсаараа хүнд байдалд орох нөхцөл рүү явах уу, үгүй юу гэдэг асуудал энд хөндөгдөж байгаа учраас л энэ асуудлыг өнөөдөр хэлэлцээд явж байна.

Ер нь шүүмжлэлтэй асуудал бол үүнийгээ маш өргөн хүрээнд сайн судалж, хэлэлцүүлэг хийж байж оруулж ирэх ёстой байсан уу гэвэл байсан. Тийм л байдал байгаа юм.

Б.Жавхлан сайд нэмж хариулт өгье.

Б.Жавхлан: Биржийн хуульд орж байгаа өөрчлөлт бол биржийн хамрах хүрээг улам тэлж байгаа гэж би бүр яг нюансийг нь хэлье. Түрүүн Д.Батбаяр гишүүн асууна лээ. Ийм юм байгаа юм.

Одоо байгаа биржийн хууль дээр зөвхөн экспортод зориулсан түүхий эдийг гэж байгаа юм.

Гэтэл одоо бид нарын оруулж ирж байгаа зүйл дээр экспорт, нэмэх нь дотоодын баяжуулах үйлдвэрүүд дээр ч гэсэн биржээр явуулж болно гэж оруулж ирж байгаа юм. Өөрөөр хэлбэл хүрээг нь дахиад тэлж байгаа гэсэн үг. Аливаа цоо шинэ харилцаанд орж ирэхэд ингээд дутуу тооцоолсон, алдаа гарахыг үгүйсгэдэггүй юм байна. Энэ дээр ерөөсөө яг ийм юм байгаа байхгүй юу. Зөвхөн бирж рүүгээ бид экспорт гээд явсан. Гэтэл дотоодын үйлдвэр, дотоодын баяжуулах энэ аягүй том эдийн засаг маань аягүй хэлмэгдээд үлдсэн.

Тэд нар ямар ч харилцаа байхгүй болсон. Баяжуулаад экспортолъё гэхээр экспортолж чадахгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайдад нэмэлт минут өгье.

Б.Жавхлан: Тийм. Баяжуулаад экспортолъё гэхэд экспортолж чадахгүй болчихоод байгаа.

Одоо энэ харилцаагаар, энэ хуулийн өөрчлөлтөөр дотоодын тэр баяжуулах үйлдвэрүүд маань биржээрээ тэр түүхий эдүүдээ аваад баяжуулаад экспортлоход бүрэн хуулийн боломжтой болж ирж байгаа. Тэгэхгүй тэнд ингээд нэг ийм хар зах үүсчхээд байгаа байхгүй юу. Иймэрхүү сул талуудыг энэ удаагийн өөрчлөлтөөрөө бид бүрэн зохицуулж байгаа.

Тийм учраас биржийн тухай энэ удаагийн өөрчлөлт ухрах биш харин ч хүрээг нь тэлээд, улам боловсронгуй болгоод, ингээд хоцорсон байсан, хэлмэгдсэн байсан тэр боловсруулах үйлдвэрүүдийг харин ч түүхий эдээ бүрэн ил тод худалдаж авах, энэ нь аягүй тодорхой хуульчлагдаж ирж байгаа гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Ингээд даргын дэргэдэх зөвлөлөөс уг хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг 150 минутад хэлэлцэнэ гэж орж ирсэн. Тэгээд 2 цаг 30 минутын хугацаа 10.00 цагаас эхэлсэн чуулган 12 цаг 30 минут хүртэл хуралдаад ингээд үндсэндээ хугацаа дуусаж байна.

Гэхдээ 6, 7 гишүүн асуулт асуухаар нэр үлдсэн байгаа учраас дэгийн тухай хуулийн 36.7 дахь заалтыг үндэслээд гишүүдийг асуулт асууж дуустал хэлэлцэх хугацааг сунгаж байна. /алх цохив/

Ингээд Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Баярлалаа.

Ингээд энэ Уул уурхайн биржийн тухай хуулийг бид хэлэлцэх. Энэ бол бас их чухал юм. Үнэхээр батлагдаад удаагүй байгаа. Дээрээс нь энэ хууль өөрөө шинэ тутамдаа хэрэгжиж байгаа учраас алдаатай оноотой янз янзын байдлаар батлагдсан зүйлүүд ч бас байгаа.

Тэгээд ийм их чухал асуудлыг яг энэ цаг үед оруулж ирж байгаа нь бас гарцаагүй л бид нарын өнөөдрийн тулгараад байгаа энэ эдийн засгийн нөхцөл байдалтай ч холбоотой, улс орны энэ төсвийн бүрдэлтэй ч хамааралтай ийм л хуулийг бид ярилцаж байна.

Тэгээд энэ хуулийг дэмжиж байгаа миний хувьд. Үнэхээр бид байгалийн баялгийнхаа түүхий эдийг баялаг болгож экспортлох, борлуулах, эдийн засгаа

тэлэх олон суваг, боломжуудыг нээх нь зөв шүү дээ. Засгийн газрын бас нэг талаас үүрэг.

Өнөөдөр үүнийг оруулж ирж байгаа манай Ц.Туваан сайд, мөн Б.Дэлгэрсайхан сайд. Энэ сайд нар маань бас энэ чухал асуудал дээр гал аваад санаачилга гаргаад энэ Засгийн газрын нүүрийг таглаж байгаа цөөхөн сайд нарын нэг мөн.

Тийм учраас би энэ сайд нарынхаа асуудлыг дэмжинэ. Зарим нэг гишүүд бас нэг улс төрийн өнгө аяс үнэртүүлээд тэр асууж байна.

Тэр ногдол ашиг 90 мянган төгрөг хавтгайд нь тараасан асуудал чинь энэ Эрдэс баялаг, аж үйлдвэрийн сайдаас асуугаад байх юм уу, тийшээ наагаад байх асуудал мөн юм уу, биш юм уу? Тэр Ерөнхий сайддаа, Сангийн сайддаа хэлэх хэрэгтэй байх гэж бодож байгаа.

Тэгээд хууль хэлэлцээд явахад яалт ч үгүй манай говийн бүстэй л холбогдож байна л даа. Нэг мөнгө хэрэгтэй болохоор л Өмнөговь руу давхидаг. Нэг тээврийн асуудал зохицуулах болохоор л Дорноговь руу давхидаг, Өмнөговь руу давхидаг нэг ийм л юм болоод байгаа.

Тэгээд бүс нутгийн хувьд өгөөж гэх юм уу, бүс нутгийн хувьд хөрөнгө оруулалт гэх юм уу ийм зүйл нь байдаггүй. Эдийн засаг хүндрэхээрээ л тийшээ давхиж очоод л бөөн бөөнөөрөө очиж хуралдаад л яваад байдаг.

Энэ тал дээр ямар үр өгөөжийн талаар оруулах вэ гэдгийг энэ дээр бас яримаар байна.

Миний асуух гээд байгаа асуулт бол энэ 10.5 дээр уул уурхайн бүтээгдэхүүний баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж, экспортлох зорилгоор дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт биржээр дамжуулан арилж болно гэсэн дээр яг ямар ямар уул уурхайн бүтээгдэхүүнүүд ер нь байгаа юм бэ? Энэ зөвхөн нүүрс юм уу, тэр зэс, төмөр бусад юунууд орж байна уу гэдгийг нарийн асуумаар байна.

Дээрээс нь энэ биржийн хууль шинэчлэгдээд явбал хэчнээн сая тонн нүүрс юм уу, бүтээгдэхүүнээр нэмэгдэх боломж байгаа юм бэ гэдгийг бас асуумаар байна.

Мэдээж үүнийг баяжуулаад, боловсруулахаар ус хэрэг болно. Энэ ус нь хаана байгаа юм? Гүний усаар хийх юм уу яах юм. Энэ говийн бүс чинь усгүй болоод сүйд болж байгаа.

Д.Амарбаясгалан: Тодруулж асуух 1 минутаа нэмж авъя гэж байна. Ц.Мөнхбат гишүүнд 1 минут нэмж өгье.

Ц.Мөнхбат: Хоёрдугаарт нь, тээвэртэй, тээвэргүй үнийн нөхцөл гээд байгаа.

Энэ тээвэртэй тээвэргүйгээс болоод яг тэр “хил нөхцөл”-өөр худалдсанаас болоод маш олон тээврийн компаниуд дампуурсан. Хятадын томоохон гэрээ хийсэн том аж ахуйн нэгжүүдийн тээвэр яваад байдаг. Жижиг манай Монголын нэг цөөн хэдэн машинтай тээвэргүй нөхцөлөөр гэрээ хийсэн тохиолдолд зөөдөг байсан тэр компаниуд бүгд дампуурсан.

Тэгэхээр энэ дээр ямар зохицуулалт орж ирэх вэ? Ер нь энэ тээврийн тендер чинь өөрөө зөв шийдэл мөн үү, биш үү гэдгийг Б.Дэлгэрсайхан сайдаасаа асууя.

Бас энэ “Эрдэнэс Тавантолгой”-н захирлаас асуух гэсэн юм. Энэ сая нэг юм сонин юм ярих юм. Нийгмийн хариуцлагын хүрээнд тэр орон нутаг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Цаг бага байгаа учраас тодорхой товчхон хариулъя. Ц.Мөнхбат гишүүн дэмжиж байгаад баярлалаа.

10.5 дээр ямар ямар уул уурхайн бүтээгдэхүүн орох юм бэ гээд.

- Бага агуулгатай төмрийн хүдэр орно.
- Бага агуулгатай жонш орно.
- Нүүрс орно. Баяжуулагдах зорилгоор.

Ийм 3 бүтээгдэхүүн орж байгаа гэдгийг хэлье.

Баяжуулах үйлдвэрүүд дээр мэдээж ус хэрэглэнэ. Тэгээд энэ дээр усны хайгуулыг, гидрогеологийн хайгуулыг хийж нөөцөө тогтоож байгаад усны газар дээр гэрээ байгуулаад энэ усыг ашиглана.

Яг үнэндээ өнөөдөр Монгол Улсад тулгамдаад байгаа 3 томоохон асуудал байгаа.

- > Нэгдүгээрт, эрчим хүчний асуудал.
- > Хоёрдугаарт, усны асуудал.
- > Гуравдугаарт, боловсон хүчний хомсдол байгаа.

Тэгэхээр энэ усны асуудлыг бид шийдье гэхээр энэ дээр нэлээн том хөрөнгө оруулалт шаардана. Хэрлэн-Тооно, Орхон-Онги дээр.

Тэгэхээр энэ асуудлыг манай говийн бүсийн гишүүд маш тодорхой тавьж байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг шийдэхэд тэр 10.3 дахь заалт буюу бүтээгдэхүүн солилцоогоор шийдэж болох юм гэж. Ялангуяа уул уурхайн салбарыг түлхүү дэмжиж ашиглуулж байгаа говийн бүс дээр энэ маш том боломжийг үүсгэнэ гэж харж байгаа.

Тээвэртэй тээвэргүйг сонголттой болгож өгч байгаа. Энэ дээр шууд DAF нөхцөл гэхээр уурхайн компани нь өөрөө хил хүргэж өгөх, боомт дээр тэр терминал дээр буулгаж өгөх үүрэг хүлээж байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэлээн ачаалал үүсэж байгаа. Тухайлах юм бол Дархан төмөрлөгийн үйлдвэр дээр гэхэд яг хэвийн биржээр зарсан бүтээгдэхүүнээ арилжаалахад 1450 вагоны хэрэгцээ байгаа. Яг өнөөдөр гэхэд 850 орчим вагоноор энэ юмаа хийж байгаа.

Тэгэхээр энэ дээр жишээлбэл бирж дээр тээвэргүйгээр зарах юм бол худалдан авсан компани өөрсдөө тээврээ хариуцаад явах боломжит сонголтыг бий болгож байгаа.

Ц.Мөнхбат гишүүний нэг асуудалтай 100 хувь санал нэг байна. Юу гэхээр биржээр арилжаалсан нүүрсэн дээр уул уурхайн, тухайлах юм бол “Эрдэнэс Тавантолгой” тендер зарлаад явахаар томоохон шинэ техниктэй, чингэлэг ачих бололцоотой улсууд тээвэрт нь ороод явдаг. Нөгөө хэдэн орон нутгийн компаниуд, жолооч нар маань бас өмнө нь задгайгаар ачдаг ч юм уу ийм техниктэй улсууд ихэвчлэн орхигдоод байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг шийдэх.

Хоёрдугаарт, тэр хүн өөрөө биржээр авсан нүүрсээ хэдий хугацаанд аваад явах вэ гэдэг боломжийг нь гаргаж өгөх сонголтоор энэ тээвэртэй, тээвэргүй гэдэг энэ заалт хуульд орж ирж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Ц.Мөнхбат гишүүний асуултад хариулъя.

Ц.Мөнхбат гишүүн яг л зөв л асууж байна л даа. Үндсэндээ нүүрс худалдаж авч байгаа компаниуд нь өөрсдөө тээврээ сонгоод, тэгээд ихэвчлэн Хятадын компаниуд орж ирдэг. Тэгээд Тавантолгой компани өөрөө сүүлийн үед. Сүүлийн үед яах вэ, ер нь тээврийн тендер зарладаг явдал газар авсан. Энд хэдхэн компани л ялдаг. Дандаа хятад эзэнтэй. Тэгээд Тавантолгой компани дотроосоо оролцоотой.

Тэгээд би одоо өнөөдөр үүнийг баримтгүй яримааргүй байна. Тэгээд дараа нь үүнийг хэрвээ баримт хүсвэл би гаргаж өгч болно.

Тийм учраас цаашдаа би Тавантолгой компанид нэг л юмыг хэлж байгаа юм. Олборлодог нь олборлодгоо хий. Ачиж өгдгөө л хий. Тээвэрлэдэг компани нь тээврээ хийнэ. Түүнээс биш бүгдийг Тавантолгой хийнэ гэж байхгүй. Энэ дээр Зам, тээврийн яамнаас хатуу бодлого барьж байгаа.

Тийм ч учраас Засгийн газар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дамбын Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Одрийн мэнд хүргэе. Хуулийн төсөл дээр хувийн хэвшлийн баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлүүдийг дэмжих зохицуулалтууд оруулж өгөх гэж байгаа. Энэ сайн зүйл юм. Би энэ талаас нь дэмжиж байгаа.

Тэгэхдээ гуя дагаж хүзүү гэгчээр нөгөө нүүрсний offtake гэрээний томсгосон хувилбар шиг зүйл болох вий дээ гэж харж байгаа.

Өнгөрсөн хугацаанд бид тэр нүүрсний offtake гэрээнээс ямар хохиролтой болж хоцорсон юм бэ? “Эрдэнэс Тавантолгой” компани 5 их наяд төгрөгийн хохиролтой болоод хоцорсон байна.

Яагаад гэвэл offtake гэрээгээр бид нэг тонн нүүрсийг дэлхийн зах зээл дээр 180-аас 190 доллар байхад 60 доллароор гэрээ байгуулсан. Тэр байтугай нэг ширхэг талхыг 25 мянган төгрөгөөр нийлүүлж байсан гэсэн яриа ч байдаг шүү дээ.

Ийм нөхцөл байдалд орох зүйлүүдийг бид ингээд хуульчлах гээд сууж байна гэж би харж байгаа шүү. Энэ бол уул уурхайн бүтээгдэхүүн болоод хувирч байгаа. Нүүрс биш, бүр зэс орно, жонш орно, төмөр.

Энэ хуулийн төслийн 14.6-д уул уурхайн бүтээгдэхүүний чанар, үнийн индексээс хамаарч биржийн үнэд өөрчлөлт оруулж болно. Тэр нь уул уурхайн бүтээгдэхүүн гэж. Бүр гаргалгаатайгаа шүү энэ. Одоо бүр хууль. Нөгөө журам бүр цаашаа болсон. Гэрээгээр зохицуулах нь. Нөгөө үнийг.

Ингэж гаргалгаа гаргасан зүйл чинь хулгай том хувилбар луу л хөтлөөд явна шүү. Үүнээсээ бид яаж хамгаалж чадах юм. Үүнийг хэн батлан даах юм.

Одоо яг төслөөрөө бол тэгж л уншигдаж байна. Байгалийн баялгийг ашиглахын тулд хууль гаргаж байгаа. Үнэн. Хууль гараад тэрийгээ мөрдөж байгалийн баялгаасаа ашиг шим хүртэх гэж байгаа зорилго нь зөв. Хууль чинь тодорхой л байх ёстой юм байгаа биз дээ.

Тодорхой бус байдал чинь, түүнийг дагасан журам, гэрээ тэр зүйлүүд чинь л өнөөдөр offtake гээд нэг тийм хүний идэш болсон, хулгай болсон зүйл рүү

л хөтлөөд байгаа шүү дээ. Тэгвэл бид яагаад ахиад энэ алдаанаас суралцахгүй ийм зүйл рүү чиглүүлсэн хууль эрх зүйн зохицуулалтуудыг оруулж ирж байгаа юм бэ? Ийм зүйл болохгүй гэж хэн батлан даах юм? Энэ дээр надад нэг хариулт өгөөч ээ.

Хоёрдугаарт нь, бид уул уурхайн бүтээгдэхүүнийхээ, баяжмалынхаа агуулгыг хэрхэн тодорхойлж байгаа юм. Би тодорхой асууна. Зэсийн баяжмал, молибдены баяжмал, төмрийн баяжмал, жонш энэ бүхэн чинь агуулгаасаа хамаарсан өөр өөрийн үнэтэй.

Өнгөрсөн жил хэдэн сая тонн нүүрс, зэсийн баяжмал, уул уурхайн бүтээгдэхүүнийг бид экспортод гаргасан. Түүнээс хэдэн тонноос дээж авч агуулгыг нь тодорхойлсон. Энэ бүхнийг бид хянаж чадаж байгаа юм уу? Үүний чинь цаана бас том асуудал яригддаг шүү. Өас хулгайтай холбоотой асуудал.

Энэ бүхнийгээ биржийн тухай хуульдаа оруулж өгч зохицуулах боломж байхгүй байсан юм уу. Энэ дээр хариулт аваад тодруулга хийе.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Д.Батлут гишүүний зарим асуултад нь мэдээлэл өгье.

Тэр хууль дээр бид индексжүүлж байгаа нэг ийм юм байгаа юм аа, гишүүн ээ.

Одоо байгаа хууль маань бид байгалийн баялгаа ил тод болгосон. Тэгэхдээ нэлээн бас хатуу ширүүн ийм заалтууд орсон байна. Үнэ өсөж байх үед манай биржийн зохицуулалт маань сайн яваад байна. Үнэ унаж байх үед бирж маань таг зогслоо. Таг зогслоо. Одоо яах вэ. Ийм байж болохгүй.

Тэгэхээр бирж бол өөрөө санхүүгийн зуучлагч байгууллага. Өсөж байх үед ч тэр, унаж байх үед ч тэр явж л байх ёстой. Ийм л уян хатан. Бид ямар ч тохиолдолд энэ байгалийн баялгаа нийтэд ил тод, биржээр явуулдаг байх энэ зарчим руу л оруулж байгаа.

Тийм учраас индексжүүлж байгаа. Өсөж байхад ч гэсэн дагаж байдаг, унаж байхад ч гэсэн дагаж байдаг. Тэгэхгүй өндөр байх үед, өсөж байх үед авсан, зарсан. Тэгээд 6 сарын дараа тэнд аваачиж өгнө, Ганцмод дээр аваачиж өгнө, Ханги дээр аваачиж өгнө. Тэнд аваачиж өгнө гээд заасан байж байдаг. Энэ хооронд үнэ унахаар таг зогсдог. Одоо яг ийм байдалтай л байгаа.

Тэгэхээр өнөөдөр бүх юм шийдэгдэж байгаа биш. Цаашдаа ч бид үеийн үед энэ бирж гэдэг юмаа амьд байлгахын тулд бүхий л боломжууд дээр нийтэд ил тод. Энэ нь өөрөө амьд явж байдаг энэ боломжуудаа л хуульчилж байгаа юм.

Түүнээс биш одоо тэр үнэ, ашиг бол дараагийн асуудал.

Нэгдүгээрт, байгалийн баялаг өөрөө биржээр олон нийтийн өмнө ил тод байх ёстой шүү гэдэг энэ зарчмаа улам их чанаржуулж байгаа гэсэн үг. Чанаржуулж байгаа гэсэн үг.

Одоо ингээд үнэ буугаад ирэхээр буцаагаад далд хар зах руу яваад ордог байж болохгүй. Харин ч унаж байхад ч тэр, өсөж байхад ч тэр илүү их сонирхолтой. Тэнд улам л буцалж байдаг ийм зарчим руу нь оруулж байгаа л гэж харж байгаа.

Тэр offtake гээд. Offtake дээр өнгөрсөн түүхүүд бол хар түүх үлдээсэн. Бид үүнийг зөндөө ил тод, бүгдээрээ ингээд шүүсэн. Гэхдээ энэ бол бас бидний хувьд хөгжлийн том боломж тэнд байсаар байгаа. Бид төсвөөсөө шийддэг асуудлуудаа улам хумьж байгаа. Хумьж байгаа.

Гэтэл энэ газрын хөрсөн доор байдаг энэ түүхий эдээ баялаг болгож чадахгүй байсаар байх уу. Нэг хүнд ногддог.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Б.Жавхлан сайд.

Б.Жавхлан: Тийм. Тэр баяжмал агуулгыг нь мэргэжлийн сайд нь хариулсан нь дээр байх. Би сайн хэлж мэдэхгүй байна. Тийм.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон хариулт өгье. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр эрдэс баялгийн яам Г.Намчинсүрэн. Д.Батлут гишүүний асуултад нэмж тайлбар өгье.

Үндсэндээ биржээр арилжаалах бүтээгдэхүүний чанарын хяналтыг 13 дугаар зүйл дээр бүхэл бүтэн зүйл болгоод заагаад өгсөн байгаа. Энэ дээр чанарын хяналт тавих асуудлыг нь хөрөнгийн бирж дээр хяналтыг нь тавихаар заасан байдаг.

Ер нь Монгол Улсын хэмжээнд гаалиар гарч байгаа бүтээгдэхүүний чанарын хяналтыг гаалийн төв лаборатори үндсэндээ хяналтыг нь тавьж байгаа.

Мөн Гаалийн ерөнхий газрын гаалийн хяналтын лабораторийн нөгөө итгэмжлэл авсан лабораториудаар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Маш тодорхой хариулт. Ажлын хэсгийн 9 дүгээр микрофон.

Энэ гишүүдийн шаардлага ер нь зөв шүү. Заавал албатай юм шиг оногдсон минутад багтааж л нэг баахан оршилтой, тойруулсан, бараг асуулт асуусан хүн нь марттал тойруулж хариулдаг хариултаа л боль. Тодорхой хариулт. Тоо.

Г.Намчинсүрэн: 3 мянгаас 5 мянган тонн тутамд нэг дээж авч байгаа.

Д.Амарбаясгалан: Дамбын Д.Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Бид хууль давсан журмуудаар их олон асуудал зохицуулж байгаа. Тэр нь их алдаа дутагдал гаргаж байгаа. Бас нөгөө хулгай зэлгий, нийгмийн болж бүтэхгүй байгаа бүх зүйл үүнтэй холбоотой гэж ярьж байгаа. Одоо бүр цаашлаад гэрээгээр зохицуулдаг байж болохгүй ээ. Хууль тодорхой байх ёстой.

Тэгэхээр энэ хуулийн төслийг яах ёстой юм бол. Би илүү тийм товч тодорхой байж энэ уул уурхайн баялгийг зүй зохистой ашиглах, буцаагаад нийгэмд өгөөжтэй салбарт нь хөрөнгө оруулалт хийдэг байх, янз бүрийн хулгай зэлгий байхгүй болох ёстой гэж харж байгаа.

Манай гаалийнхан, мэргэжлийн газрынхан битгий худлаа ярьцгаагаарай та нар. Зэсийн баяжмал 6.9 сая тонн гарсан. Та нар 10-хан мянган тоннд л агуулгын хувьд тодорхойлсон байгаа шүү. Ийм худлаа мэдээллийг гишүүдэд өгөөд сууж байгаа. Өнөөдөр. Бод доо. 6.9 сая тонны 10-хан мянгад нь агуулгын хувьд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Би удаа дараа хэлээд байгаа нэг зүйл Засгийн газар яаралтай горим гэдэг нэрийн доор маш том хуулиудыг, маш том асуудлыг оруулж ирж байна.

Ер нь Засгийн газрын шийдвэр гаргах процесс дээр

- хууль зүйн талаас Хууль зүйн сайд, Хууль зүйн яам,
- төсөв, санхүү талаас Сангийн сайд, Сангийн яам,
- захиргааны хяналт талаасаа Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хэрэг эрхлэхийн сайд хяналт тавьж зөвшөөрсөн бичиг өгсний үндсэн дээр энэ хуулийн төслүүд өргөн баригддаг байх ёстой.

Яаралтай горимоор орж ирж байгаа хууль, тогтоолын төслүүд дээр мэдээж энэ 3 яам, энэ 3 сайд гарын үсэг зурсан бичигтэйгээ хамт орж ирдэг.

Гэхдээ орж ирсэн төсөл нь өнөөдөр Улсын Их Хурал дээр засаж сайжруулах, нягтлах, бүр тэр битгий хэл олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлага үүсгээд байна.

Үүнийгээ нягтлахгүйгээр яаралтай горимоор өргөжсөн төслүүд нь өнөөдөр ингэж хэрүүл дагуулаад явж байна. Тэгээд маш олон төслийг буцаах шаардлагатай зүйлс байна.

Тэгээд буцаагаад өгөхөөр Улсын Их Хурал нь өргөн барьсан төслийг авдаггүй, эсвэл Улсын Их Хурал нь Засгийн газрынхаа бодлогыг дэмжсэнгүй гэдэг асуудал үүсэж байдаг.

Тэгээд гадаа гарахаараа Улсын Их Хурал дээр өргөн барьсан төсөл хэлэлцүүлэхгүй байна гээд л яриад сууж байдаг энэ байдлыг таслан зогсооно.

Манай Улсын Их Хурлын гишүүдийн шүүмжлэлтэй би санал нэг байгаа юм. Улсын Их Хурал Засгийн газрын хуулийн тасаг шиг ажиллахгүй ээ. Зарим зүйл дээр хатуу байр сууриа илэрхийлж буцаах тэр эрхээ хэрэгжүүлнэ гэдэг ийм л байр суурьтай байгаа.

Одоо бүр амар юм болох нь. Хуулийн шаардлага хангаагүй төслүүд өргөн барьчхаад, одоо Улсын Их Хурал үүнийг авч хэлэлцүүлэхгүй байна гэж хэвлэлд яриад зогсож байдаг болсон байна.

Хайр найргүй буцаах энэ асуудал дээр хандана шүү. Би анхааруулж хэллээ шүү. Бас Засгийн газар маань ажил хийх гээд байгаа гэдэг бодлогоор бодлоор асуудлыг нь дэмжих гээд хичээгээд ажиллаад байх тусам буруу зөрүү асуудалд хандаж байна. Одоо бүр нөгөө “даварсаар даварсаар дагны оронд” гэгчээр өөрсдөө хууль хэрэгжүүлэхгүй, хуулийн шаардлагыг хангахгүйгээр хуулийн төслүүд өргөн барьчхаад одоо хэлэлцсэнгүй гэж байна.

Зөвшөөрлийн хуулийг дагаад Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах гээд ороод ирж байгаа байдал өөрөө ариун явдал мөн юм уу, биш юм уу. Би энэ гишүүдийн шүүмжлэлтэй санал нэг байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуулт асууя.

Ш.Бямбасүрэн: Их Хурлын дарга болон гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Эдийн засаг сайжирсан үед нь ашигт малтмалын эрэлт ихэссэн үед бирж хэрэгтэй. Хямарсан үед нь бирж хэрэггүй болдог энэ л хамгийн ойлгомжгүй асуудал болоод байгаа юм л даа. Уг нь энэ ашигт малтмалын биржийн үйл ажиллагаа төлөвших нь Монгол Улсын урт хугацааны хөгжилд их тустай салбар гэж боддог юм.

Тэгэхээр бид ер нь хэзээ тогтвортой урт хугацаандаа ажилладаг системтэй болох юм бэ гэж асуумаар байгаа юм.

Хоёрт нь, хуулийн 10.3-т өөрчлөлт оруулахаар тусгасан байна. Тэгээд одоо хүчин төгөлдөр байгаа, өөрчлөлт оруулах гэж байгаа 10.3-ын заасан зохицуулалтаар ер нь өнгөрсөн хугацаанд биржээр дамжуулахгүйгээр хэчнээн гэрээг хэнтэй, ямар үнээр, ямар үнийн дүнтэй гэрээ ер нь байгуулсан бэ? Тэгээд эдгээр гэрээг ер нь байгуулагдаж байх үед тухайн үед Ашигт малтмалын бүтээгдэхүүний биржийн дундаж үнэ нь ер нь ямар байсан талаар мэдээлэл байна уу гэж.

Тэгээд одоо энэ өөрчлөх гэж байгаа оруулж ирж байгаа 10.3-ын заалт маш их ноцтой заалт л даа.

Ер нь үр дагавар нь хэдэн 100 сая доллароор хэмжигдэх ийм ганц заалт байгаад байгаа юм.

Тэгэхээр 10.3 дээр “Монгол Улсын Их Хурал шийдвэрлэж болно.” гэдэг өгүүлбэрээр төгсөж байгаа нь ерөөсөө ойлгомжгүй байгаад байна л даа. Энэ оруулахгүй байж болох ч юм шиг. Их Хурлаар. Ийм заалт байгаа. Үүнийг юу яаж болохгүй байсан юм уу гэж асууж байгаа юм.

Тэгээд хуулийн 10.5 дээр дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт биржээр дамжуулж болно гээд бас ахиад ороод ирсэн.

Тэгэхээр үүнийг ер нь зөвхөн биржээр дамжуулж арилжина гэдгээр ер нь оруулах нь зүйтэй юм биш үү гэж би асуух гээд байгаа юм. Яагаад ингэж асуух гээд байна вэ гэхээр жишээлбэл Эрдэнэт үйлдвэр баяжмалаа катодын зэс үйлдвэрлэж нэмүү өртөг шингээж экспорт хийх зорилгоор дотоодын аж ахуйн нэгж “Эрдмин”, “Ачит ихт” ч гэдэг юм уу энэ компаниудад худалдаж болохоор байгаа юм л даа.

Тэгтэл энэ нь бас биржийн бус болоод, нөгөө ил тод яваагүйгээсээ болоод ахиад бөөн хэл ам гарах асуудал байгаа байхгүй юу. Яг энэ биржийн хуулийн амин сүнс чинь өөрөө ил байдал гэж аягүй олон хүмүүсийн амнаас гараад байгаа байхгүй юу.

Тэгэхээр дотоодын борлуулж байгааг ч гэсэн ил тодоор явуулахын тулд биржээр явуулах нь зөв юм биш үү гэсэн ийм юмыг асууя.

Д.Амарбаясгалан: Б.Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Ш.Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя.

Энэ ийм юм байгаа юм. Одоо энэ биржийн хуульд орж байгаа нэмэлтүүд маань харин улам их хүрээгээ тэлж байгаа байхгүй юу. Одоо байгаа зохицуулалтаараа зөвхөн экспорт гэж байгаа юм. Баяжуулах нь орхигдсон.

Харин энэ удаагийн өөрчлөлтөөр баяжуулах үйлдвэрүүдэд ч гэсэн дотоодын биржээр явуулна гэдэг нэмэлт зохицуулалт орж ирж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл биржээр явах байгалийн баялаг маань хүрээ нь нэмэгдэж байгаа гэсэн үг.

Тэгэхээрээ тэрийг болно гэж оруулах уу, заавал оруул гэх үү. Одоо хэлэлцэх үедээ үүнийг шийдвэрлэж болох байх гэж бодож байна.

Ямар ч байсан хүрээгээ тэлж байгаа юм. Илүү их ил тод болж байгаа гэсэн үг. Ард түмний байгалийн баялаг илүү их нүдэн дээгүүр явна л гэсэн үг.

Тэгэхгүй болохоор одоо хэдэн баяжуулах үйлдвэрүүд маань ингээд баахан хөрөнгө оруулалт хийсэн. Эд нар түүхий эдээ хаанаас авахаа мэдэхгүй. Авсан хойноо баяжуулдаг. Экспортлох гэхээр хил дээр очоод, боомт дээр очоод таг гацаж байгаа байхгүй юу. Экспорт байхгүй.

Биржийн хууль гарснаас хойш энэ баяжуулах үйлдвэрүүдийн экспорт таг зогссон. Бид нарын алдаа байсан. Одоо үүнийг үнэнээ хэлэх хэрэгтэй байна. Үнэнээ хэлээд үүнийгээ явуулъя. Гэхдээ зөвхөн биржээр шүү. Ийм л зохицуулалт нэмж орж ирж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Ц.Туваан сайд нэмэлт хариулт өгье.

Ц.Туваан: Ш.Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя.

Биржийн тухай хуулийн 10.2 дээр уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр “заавал” арилжина гэж байгаа юм.

Тэгэхээр бид одоо хүчин төгөлдөр байгаа хуулийнхаа энэ концепцыг хөндөхгүйгээр л бүх асуудлуудаа заавал арилжъя. Дотооддоо ч баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд арилжъя гэдэг энэ санаагаар орж ирж байгаа гэдгийг хэлье.

10.3 дээр өмнө нь стратегийн орд эзэмших төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой шийдвэр гарсан тохиолдолд нүүрсийг тогтвортой, урт хугацаанд борлуулах гэсэн зүйл, заалт байсан. Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын төмөр замын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулагдсанаар энэ заалт хэрэглэгдэхгүй болсон.

Тэгэхээр үүний оронд тэр бүтээгдэхүүн солилцооны заалтыг оруулж ирсэн.

Д.Амарбаясгалан: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Өнөөдөр ам.долларын ханш 3560 төгрөг, евро 4070 төгрөг, юань 489 төгрөг байна. Нэгдүгээр улирлын байдлаар төсвийн алдагдал 1.2 их наяд болсон гэсэн мэдээ байна.

Тэгээд нүүрсний үнэ анх төсөв хэлэлцэж байсан үеэс 30, 40 хувь унасан гэж ойлгоод байгаа юм.

Тэгээд ашгүй Б.Жавхлан сайд ороод ирлээ. Энэ хэлэлцүүлгийн төгсгөлд.

Та төсөв хэлэлцэж байх үед төсөвт нүүрсний үнийг 105 доллароор оруулж ирэхэд “Би ёстой хар толгойгоороо хариуцъя”. Нүүрсний үнэ унахгүй. Цаана чинь ёстой өчнөөн худалдан авагч нар байна. Та нар энэ Ганцмод-Гашуунсухайтыг л батлаадах. Энэ төсвөө ингээд аваад гарна гээд байсан.

Гэтэл бид үнэнтэйгээ нүүр тулсан. Тэгээд нүүрсний үнэ чинь ингээд унасан. Тэгээд гол хуулиа ингээд өөрчлөөд сууж байна шүү дээ.

Тэгэхээр одоо энэ төсөв энэ тэрээ тодотгохгүй юм уу? Энэ валютын ханш чинь замбараагаа алдлаа. Энэ бүхний хор уршгийг хэн хүлээж байна вэ гэхээр бор зүрхээрээ амьжиргаагаа залгуулж байгаа иргэд, бор зүрхээрээ бизнес хийж байгаа аж ахуйн нэгжүүд энэ бүхний золиос болоод байна шүү дээ.

Тэгээд одоо ямар зүйл ажиглагдаад байна вэ гэхээр Засгийн газар ерөөсөө нөгөө төсөвт тодотгохгүйгээр бүх зүйлээ авч гарахын тулд хаана нэгтээгээс нэг мөнгө олох зорилгоор л ерөөсөө яаралтайгаар янз бүрийн юмнууд оруулж ирдэг.

Нөгөө Зөвшөөрлийн хуулийг оруулж ирж байгаа үндэслэл нь гэсэн чинь жил болгон 500 сая ам.доллар гадагшаагаа урсаад байна. Бид ханшаа алдах гээд байна гэсэн зүйл ярьж байгаа.

Тэгээд тэр хууль нь хууль зүйн техникийн хувьд ч гэсэн бүх зүйлийн хувьд алдаатай. Өчнөөн олон хүмүүс бас тэр хуулийн золиос болох боломжтой ийм хууль оруулаад ирж байгаа.

Энэ хууль ч гэсэндээ ялгаа байхгүй. Бид нүүрсний хулгайг зогсооё. Тэр уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтыг ил тод болгоё гээд Биржийн хуулийг 2022 оны 12 сарын 23-нд баталсан.

Тэгээд түүнээс хойш нэг жилийн дараа дахиад нэг өөрчлөлт оруулсан байгаа юм. Одоо яг энэ 10.3 дугаар заалт. Тэгээд энэ 10.3 дугаар заалт дээрээ одоо жишээлбэл ахиад нөгөө яриад байгаа хэрэгтэй, хэрэггүй мега төслүүдээ санхүүжүүлэх юмнуудынхаа “Шинэ үеийн offtake гэрээ” гээд манай гишүүдийн яриад байгаа тэр зүйлийг оруулж ирж байгаа байхгүй юу.

Нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон төсөл, бүтээн байгуулалтын ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор харилцан ашигтай, тогтвортой, урт хугацаанд бүтээгдэхүүн солилцох гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гээд.

Тэгэхээр нөгөө яригдаад байгаа мега төслүүд гэдэг, нөгөө ган татлагат гүүр энэ тэр гэх мэтчилэн тиймэрхүү зүйлүүдээ энэ нүүрс, зэс, бусад зүйлээрээ солих, бартерлах тухай асуудал яриад байна шүү дээ.

Тэгээд энэ уул уурхайн түүхий эд чинь манайд валют олж ирэх ёсгүй юм уу? Бид чинь валютын нөөцийнхөө асуудлыг ярих ёстой биз дээ. Гэтэл одоо бүр ингээд бартерлая гээд сууж байдаг. Offtake гэж хэлэхээр хүмүүс дэмжихгүй. Нүүрсний хулгай ярина гэж бодоод байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо бүр бартер луугаа шилжлээ.

Тэгэхээр одоо бид үнэтэйгээ нүүр тулаад энэ төсвөө тодотгох юм уу, тэр мега төслүүдийнхээ зарим нэгийг нь болих юм уу, яах юм. Тэр асуудлуудаа яримаар байна шүү дээ.

Цаана чинь нөгөө нийслэл чинь бүр галзуурч байна. 5, 6 их наядын төсөв баталсан. Сая “Туулын хурдны зам” гээд 1.9 их наядын тендер зарлаад. Энэ мөнгө нь хүрэхгүй байна. Ахиад 300, 400 тэрбумаар нэмж байгаад тэгээд 2 их наяд гаруй төгрөгөөр зам барья гэсэн юм оруулж ирээд сууж байна шүү дээ.

Та нарт ер нь тийм уялдаа байна уу? Нийслэл дээр чинь бүр ийм вант улс үүслээ.

Тэгэхээр үнэнтэйгээ нүүр тулаад хэзээ төсвөө тодотгох юм. Энэ янз бүрийн мега гэгдээд байгаа зүйлүүд дээрээ тодорхой хязгаарлалтууд хийхгүй юм уу?

Одоо бид нарт нөхцөл байдал шал өөр боллоо шүү дээ. Мөчлөг чинь шал өөр тийшээ явлаа шүү дээ. Ийм асуулт байна. Тэгээд тодруулъя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Б.Жаргалан гишүүний асуултад хариулъя.

Хэдүүлээ тодотгол хийгээд ашиг нь нэмэгдээд, нүүрсний үнэ нэмэгдээд, биржийн арилжаа нь нэмэгддэг өдөр болгон тодотгол хийцгээе. Бүр цаг болгон ч тодотгол хийцгээе.

Харамсалтай нь тийм боломж байхгүй байна.

Дээрээс нь тодотгол өөрөө гэнэт нэг өглөө босож ирээд хийдэг зүйл биш. Төсвийнхөө ерөнхий хууль дээрээ бид нөхцөл заасан байдаг. Энэ хүрээндээ л явна.

Тодотголтой, тодотголгүй энэ жилийн хуулийг алдагдалгүй байна гээд бид хуульчилсан. Б.Жаргалан гишүүн ээ, та өөрөө оролцож байгаад. Өөрөөр хэлбэл орлогынхоо хэмжээнд зарлагаа гаргана шүү гэдгийг л заасан. Энэ жил тэгж л явна. Үүнийг бид зөрчихгүй. Тэр чинь ямар ч боломж байхгүй. Энэ нь өөрөө тодотголоос илүү ийм суурь зарчмаа бид хуульчилсан.

Баялгийн хувьд ярьж байна. Мөн л бид цаашдаа төсөв маань эдийн засагтайгаа бид нарын харилцаа улам илүү их чанартай, үр өгөөж нь өндөр. Өөрөөр хэлбэл төсвийн тоо нь багасаад, эдийн засгийн өсөлт нь өөрөө нэмэгдэж байдаг энэ зарчим руугаа орж ирж байгаа.

Тэгвэл энэ орон зайг бид яах вэ. Харсаар байтал бид баялагтай, баялагтай л гээд байдаг. Үүнийгээ яаж эргэлтэд оруулах вэ. Тэгвэл үүнээс өөр ямар сайн хувилбар байна. Төсвөөс гадуур төсөвтэйгөө зэрэгцэх, хөрөнгө оруулалт хийх, баялаг бүтээх ямар боломжууд байна вэ. Тэгвэл үүнийгээ гаргаад бүгдээрээ ярилцах хэрэгтэй.

Олон улсын практик, уул уурхайн эдийн засагтай, байгалийн баялагтай ийм эдийн засгуудын алдсан, оносон сайн практикууд нь энэ байна. Бид үүнийг хөрсөн дээрээ буулгаж ашиглая л гэж байгаа. Үүнийгээ хуульчилъя. Үүгээрээ явах гээд үзье.

Хэрвээ төсөвтэйгөө хэдүүлээ зууралдаад байх юм бол бид зорьж байгаа иргэн бүрдээ байгалийн баялаг, ард түмний баялаг байх ёстой, айл өрх бүрээр орох ёстой, айл өрх бүрд хүртээмжтэй байх ёстой эдийн засгийн өсөлтүүд маань ингээд цаасан дээрээ л үлдэнэ.

Энэ боломжийг л наашлуулах гэж байгаа ийм л нэг сонголт. Үүнийгээ Их Хурал дээрээ нээлттэй ил тод ярилцъя, сайжруулъя. Боломж болгоныг нь гаргаж ирж ярилцъя. Үүнийгээ хуульчилъя гэж байгаа ийм л зарчим гэж бодож байгаа.

Нийслэлийн хувьд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайдад нэмэлт минут өгье. Гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Нийслэлийн хувьд бид төсвийг нь энд баталдаг шүү дээ.

Монгол Улсын нэгдсэн төсөв дотор нийслэлийн төсөв, орон нутгийн төсөв бүгд орсон л явж байгаа. Бүгдээрээ харж сууж байгаад “ба”, “бэ”-гүй, цэг, таслалгүй баталсан. Энэ хүрээнд л явж байгаа.

Түүнээсээ хэрвээ гадуур явж байгаа асуудал байвал харин энд хариуцлагын асуудал яригдана. Тийм.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Их Хурал Засгийн газрын өргөн мэдүүлсэн явуулж байгаа төслийг аль болох дэмжээд л өнөөдрийг хүртэл хүрсэн шүү. Ц.Туваан сайд аа.

Тэгээд чуулган танхимд худлаа ярьж боломгүй баймаар байна. Бид бүхий л асуудлыг дэмжээд явж байгаа.

Тэгээд одоо энэ том төслүүд дээр бартерын асуудал оруулж ирж байна. Байж болох л хувилбар. Гэхдээ тэндээс яаж татвар авах юм? Үнийг яаж тогтоох юм? Тэрийг нь бүгдийг нь журмаараа хийнэ гээд оруулчхаж байгаа юм.

Үнэ журмаар шийддэг асуудал мөн үү, үгүй юу? Тэгэх юм одоо энэ биржийн хуулиа цөмөөрөө яах юм? Тэгээд засаг дээрээ сайхан ярилцаад л, үнэ тогтоогоод л, гэрээгээ хийгээд л явдаг болмоор байна.

Аль болох дэмжье л гээд л байгаа шүү дээ. Тэгэхдээ нэг юм хийхээрээ нэг бол энэ чинь ингээд л агентлаг байгуулаад л, баахан хүн авна гээд л явдаг. Нэг юм хийхээрээ одоо энэ чинь ингээд хуульчилсан хуулийн хулгай хийнэ гээд сууж байдаг. Арай дэндэж байгаа юм биш үү. Ц.Туваан сайд аа.

Одоо улс төрч нар нь орж ирж худлаа ярина. Төрийн албан хаагч нар нь орж ирж худлаа ярина. Энэ Улсын Их Хурлыг та нар ер нь яг юу гэж ойлгоод байгаа юм. Аан. Энэ дээр би нэг хариу авмаар байх юм.

Тэгээд үүнийг хэрэгжүүлэхээр Баялгийн сангийн хууль чинь яаж хэрэгжих юм? Уг нь дэмжмээр байна. Та нарын асуудлыг бид дэмжээд л явдаг шүү дээ. Тэгээд ийм юм оруулж ирээд ингээд гүлдийгээд суугаад байдаг байж болохгүй шүү дээ.

Баялгийн сангийн хууль яаж хэрэгжүүлэх гэж байгаа юм? Татварын орлогыг яаж бүрдүүлэх гэж байгаа юм?

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Цэвэгдоржийн Туваан сайд.

Ц.Туваан: Засгийн газраас Та бүхний байгуулж өгсөн, хүлээлгэсэн Засгийн газар. Тэгээд ажлаа л хийж байгаа. Эрхлэх асуудлынхаа хүрээнд асуудлаа оруулж ирж байгаа.

Хэлэлцэн батлан шийдвэрлэх бүрэн эрх нь бага ард түмэн Улсын Их Хурлын гишүүдэд байгаа.

Тэгээд өнөөдрийг хүртэл Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж явдагт нь бас талархлаа илэрхийлье. Цаашдаа ч гэсэн бид хэд Монголын ард түмний нэг номерын эрх ашгийн төлөө нэг нэгнийгээ сайлах муулах биш, нэг нэгнийгээ доромжлох биш хамтарч ажиллаж байж ард нь гарна.

“Худалдааны дайн”, “Трамп тариф” гээд бид нарын хэзээ ч тооцоолоогүй, бодож байгаагүй нөхцөл байдал үүссэн шүү. Ковидын хууль гэдэг шиг ийм нөхцөл байдал бас үүссэн байгаа шүү.

Тэгэхээр бид урьд урьдаас илүү эвтэй, урьд урьдаас илүү хамтын ажиллагаатай байж үүний ард гарна гэж бодож байна.

Х.Ганхуяг гишүүн татварын хуулийн асуудлыг ажлын хэсэг ахлаад явж байгаа. Тэгээд бид бүхэн олон зүйл дээр саналаа солилцоод, санал нэгдээд явж байгаа.

Баялгийн сан өөрөө 2019 оны Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу 2024 онд батлагдсан ийм хууль. Баялгийн сан өөрөө АМНАТ-ын татвараар бүрддэг. Доторх 3 сан нь Тогтворжуулалтын санд орж ирээд тэндээс гарч ирсэн АМНАТ-ын мөнгөөр энэ сангууд бүрддэг.

Тэгэхээр АМНАТ-ын татварыг гарч байгаа, борлуулж байгаа, биржээр зарсан, зараагүй бүх бүтээгдэхүүнээс жишиг үнэ тогтоогоод авч байгаа.

Тэгэхээр АМНАТ-ын төлбөр дээр ямар нэгэн өөрчлөлт орохгүй гэдгийг энд хэлье.

Ард иргэдийн маш их шүүмжлэл байгаа. Маш их хэмжээний уур уурхайг ашиглаж байна, борлуулж байна, зарж байна. Ард иргэдэд, улс оронд наалдаж байгаа юм алга байна гэдэг ийм шүүмжлэлийг хүлээж авч байгаа. Энэ үүднээсээ Баялгийн санг дүүргэх үүрэг нь Засгийн газарт, тэр дундаа энэ уурхайн асуудал эрхэлж байгаа сайд надад байгаа.

Тэгэхээр энэ асуудлын гацааг гаргаж, шийдвэр гаргах гэсэн ийм байдлаар энэ хуулийн өөрчлөлтийг оруулж ирэхгүй бол цаг, минут өнгөрөх тусам асуудал хүнд байна. Гишүүн ээ.

Тэгэхээр энд оруулж ирж байгааг ойлгоорой гэж хүсье.

Нөгөө бүтээгдэхүүн солилцооны асуудал дээр та дэмжиж байгаа. Энд талархаж байгаа. Тэгэхээр өөр арга байхгүй байна л даа. Иргэдтэй уулзахаар яг өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод гэхэд 157 сургууль шаардлагатай байна. Үүнийг барих төсвийн чадамж алга.

Тэгэхээр бид Японы “Өвсний үндэс”-ээр манай сургуулиудын шинэчлэлийг хийсэн шиг иргэдийнхээ нийгмийн асуудлыг шийдэхэд Засгийн газарт өөр арга алга. Дэд бүтцийн томоохон. Та бүхний Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт баталж өгсөн мега төслүүдийг хэрэгжүүлэхэд мөнгө хөрөнгө оруулалт хэрэгтэй байна.

Тэгэхээр өөр арга алга. Тэгээд л оруулж ирж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: Хуулийн төслийг чинь яах вэ, цөмөөрөө дэмжээд хэлэлцүүлгийн шатанд.

Тэр агентлаг байгуулах асуудлыг бол болимоор байна. Агентлаг ингэж байгуулахгүй ээ. Төсөв байхгүй. Ажлын албыг шууд агентлаг болгоод жилийн дундуур оруулж ирээд байгуулаад явдаг асуудал биш байхгүй юу. Төрийн захиргааны төв байгууллага байгуулах гэж байгаа шүү дээ. Та.

Тэгээд нэг хууль дагуулаад л дэмжмээр байдаг. Тэгэнгүүт нь залгуулаад л агентлаг байгуулна. Ингэнэ тэгнэ гээд л ийм юм руу орж болохгүй шүү дээ. Ц.Туваан сайд аа. Нэг тэр хэсгээ татаж авмаар байна.

Д.Амарбаясгалан: Ц.Туваан сайд.

Ц.Туваан: Тэгээд зовлон байгаа.

Тэгэхээр тэр болгоныг яриад яах вэ. Тэгээд энэ агентлагийн асуудлыг хэлэлцэх эсэхээ шийдээд тэр үед нь шийдье. Энэ дээр заавал байгуулна гээд. Дээрээс нь орон тоо нэмэх гэсэн асуудал огт байхгүй.

Мэдээж та ойлгож байгаа. Төсвийн хуулиар төсвийг нь батлаад өгсөн. Цалинтай ажилчдын тоо нэмэгдэх ямар ч боломж байхгүй.

Өнөөдөр Боловсролын сайдаас над дээр асуудал нь ирсэн. 33 хүнтэй. Өмнө нь 103 хүнтэй байсан агентлаг өнөөдөр 33 хүнтэй ажлын алба байдлаар л үйл ажиллагаа явуулж байгаа. Өнөөдөр урантай холбоотой асуудал дээр хэрэгжилт дээр маш их асуудал байна. Энэ гадна талаас та энэ дайралтууд энэ

тэрийг бас харж л байгаа байх. Н.Учрал сайд, бид хэд дээр, Б.Жавхлан сайд бид хэд дээр маш их юм ярьж байна.

Тэгэхээр энэ дээр сурталчлан таниулахаас өгсүүлээд, мэдээ мэдээллээ өгөхөөс өгсүүлээд хүн хүч хүрэхгүй байгаа.

Ер нь цаашдаа энэ асуудлыг бас зайлшгүй шийдвэрлэх л хэрэгтэй байгаа юм.

Д.Амарбаясгалан: Ренчинбямбаагийн Сэддорж гишүүн асуулт асууя.

Р.Сэддорж: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Биржийн хууль үнэ өсөлтийн үед сайн явж байсан. Сая 47 арилжаа хийгээд 12 нь л амжилттай болсон байна. Тэгээд өөрчлөх шаардлагатай юм байна гэж орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Засгийн газраас орж ирж байгаа.

Тэгэхээр төрийн өмчийн компаниуд тээврийн салбар луу орсон нь энэ хуулийг засах шаардлагатай болсон байна л гэж үзэж байгаа. Худалдан авагч компани нь юугаараа тээвэрлэнэ үү тэр худалдан авагчийнх нь асуудал. Хэзээ гаргах нь тэр худалдан авагчийнх нь асуудал байвал өрсөлдөөнтэй тээврийн бизнес тэндээ явах юм болов уу.

Одоо энэ тээврийн компаниуд бүгд хүнд байдалд орж дампуурсан. Хэдхэн машинтай. Нэг машинтай хүмүүс. 10 машинтай тээврийн компаниуд маш хүнд байдалтай, маш их зээлийн дарамтад байгаа гэдгийг иргэд хэлж байна. Тэгээд энэ хуулийг дэмжиж байгаа. Тэгээд чингэлэг тээврээ хэрхэн нэмэгдүүлж байгаа болоо.

Тэгээд ер нь уурхай олборлолтоо хийгээд л, уурхайн асуудлаа л хариуцна. Тээврийн асуудал Зам, тээврийн яам, Авто тээврийн үндэсний төв хариуцна. Хил, гаалиар гарахыг Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, бусад хил дээр ажиллаж байгаа мэргэжлийн байгууллагууд хариуцна.

Тэгэхээр “Эрдэнэс Монгол”-оос асууя. Би өчигдөр мэдээлэл авснаар жонш, төмөр, зэс, нүүрсийг биржээр борлуулж байгаа.

Тэгээд хэдэн тонн зэс, нүүрс хил дээр агуулах дүүрчхээд байгаа вэ? Төмөр хэдэн тонн гарч, ямархуу байдалтай байна вэ гэдгийг асууя.

Тэр чингэлэг тээвэр, задгай тээвэр хоёр хэдэн хувьтай байгаа вэ? Үүний чинь ард олон тээвэрчдийн, олон иргэдийн хувь заяа байгаа шүү гэдгийг хэлье. Тэгээд тээврээ салгах гэж төсөл дээр орж ирж байгаа нь маш зөв. Багц үнэхээр томдсон байна лээ. Тийм өндөр багцаар Хөрөнгийн бирж дуудлага худалдаа

зарлахад хамгийн том компани л авна. Хамгийн том тэр барьцаа хөрөнгө эд нарыг тавих, урьдчилгаа шилжүүлэх компани бол хамгийн том компани л авна.

Тэгэхээр бусад жижиг компаниуд, худалдан авагчид хаачсан бэ? Ийм том компаниудтай харьцаад л тэгээд л энэ хамаг юм чинь түгжрээд байгаа юм биш үү? “Эрдэнэс Тавантолгой”. Энэ дээр хариулаач ээ.

“Эрдэнэс Монгол” тэр хос зам яасан бэ? Одоо төмөр замын хил холболт дуустал жил гаруй болно. Цогтцэцийгээс Гашуунсухайт хүртэлх хос зам хийж байгаа компани таг болсон. Үүнийгээ тодорхой тайлбарлаж өгөөч? Үүнээс чинь болоод маш олон хүний амь нас, эд хөрөнгө сүйдэж байгаа.

“Эрдэнэс Тавантолгой” тэр Цогтцэций суманд нийгмийн хариуцлагын хүрээнд юу хийж байна вэ? Орон нутагт, тухайн бүс нутагт нь юу хийж байна вэ? Орон сууц эд нараа хэзээ барих вэ? Ажилчдаа зөөдгөө хэзээ болих вэ? Усны төсөл дээр яаж оролцох төлөвлөгөөтэй байна вэ гэсэн ийм асуултууд байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ажлын хэсгийн 8 дугаар микрофон.

Н.Жавзанпагма: “Эрдэнэс Монгол” Н.Жавзанпагма. Эрхэм гишүүний асуултад хариулъя.

Ганцмод боомтын нүүрсний үнэ 2024 оны мөн үетэй харьцуулахад өнөөдөр 45 орчим хувиар буурсан байгаа. Энэ үнийн уналтаас шалтгаалж “Эрдэнэс Тавантолгой” компанийн биржээр арилжаалсан 31 гэрээний 6.8 сая тонн татан авалт зогссон. Нүүрс дээр зогссон. 6.8 сая тонн нүүрс зогссон байдалтай байна.

Мөн манай “Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд багтдаг “Дархан төмөрлөгийн үйлдвэр”, “Эрдэнэс критикал минерал” компаниудын маань 15-аас 40 хувийн бага агуулгатай 2.5 сая тонн хэмжээтэй, ойролцоогоор 42 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий төмрийн хүдэр, завсрын бүтээгдэхүүний овоолго өнөөдөр үүсээд байна.

Одоогийн байдлаар төмрийн хүдэр, завсрын бүтээгдэхүүний хадгалах агуулга 87 хувийн дүүргэлттэй. Цаашид үйлдвэрлэлийн процесс тасралтгүй явуулахад хүндрэл үүсэх ийм нөхцөл байдал үүссэн байна.

Сая хос авто замын асуудал хөндөгдлөө. Манай авто замтай зэргэлдээ хувийн хэвшил, концессын гэрээгээр авто зам барьж байгаа ажил явж байгаа. Гэхдээ ажлын гүйцэтгэл маш бага. Шороон далангуудын хэмжээнд явж байгаа. Тэгээд энэ асуудал хувийн хэвшилдээ хамааралтай, концессын гэрээтэй бас яг ийм хамааралтай холбогдолтой ийм асуудал яваад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Р.Сэддорж гишүүний ярьж байгаатай санал нэг байна.

Ер нь тээврийн компаниудыг салгах нь зөв. Ингэхгүй бол тээврийн компаниуд их багаасаа болоод жижиг компаниуд ажлын байргүй болоод, орон нутгийн иргэд бухимдал ихтэй байгаа.

Тийм учраас үүнийг Засгийн газраас тогтоол гаргаад бүх тээврийг Зам, тээврийн яам хариуцахаар болж байгаа гэдгийг Р.Сэддорж гишүүнд зориуд хэлье.

Замын асуудал дээр “Тал нутгийн зам” гэж компани ажлаа эхлүүлээд үндсэндээ Концессын гэрээ хийснээс хойш 3 жил гаруй зогсож байна.

Тэгээд миний бие 02 сар гаруйн өмнө дуудаж энэ компанитай уулзсан. Тэгээд энэ компанийн хийсэн нэг гэрээнд 50, 50 километрийн ойр орчимд өөр зам.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Минут нэмж өгье. Гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Өөр зам тавихгүй гэдэг ийм заалттай байсан учраас Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн Шадар сайдтай зөвлөөд гэрээг нь өөрчлөөд энэ компанийн барьж байгаа зам 87 хувийн гүйцэтгэлтэй байна. Тэгээд өөрсдөө үүнийгээ нэн даруй дуусгана гэдэг ийм үүрэг авсан.

Хажуугаар нь 50, 50 километрийн зайд дахиж зам тавихгүй гэдэг заалтыг нь хүчингүй болгоод бусад зам тавья гэсэн компанид боломж олгохоор Зам, тээврийн яамнаас шийдэж байгаа гэдгийг зориуд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон хариулт өгье.

Х.Мөнхжаргал: Гишүүний асуултад хариулъя.

Чингэлэг тээврийн хувьд биржээр борлуулагдсан нүүрсний хувьд 100 хувь чингэлэг тээврээр явж байгаа. Манай урт хугацаат гэрээний хувьд ерөнхийдөө нийтдээ 147 мянган ачилт хийгдсэнээс 117 мянга буюу нийт урт хугацаат гэрээний 24 хувь нь зөвхөн задгай чингэлгээр ачиж байгаа.

Ерөнхийдөө компанийн цаашид баримталж байгаа бодлого чингэлэг тээврээр бүх нүүрсээ ачих зорилготой байгаа.

Мөн биржийн арилжааг жижиглэнгээр хийхгүй байна гэдэг, жижиг дүнгээр зарахгүй байна гэдэг асуудал дээр 2024 оны эцсээс эхлээд компани ер нь жижгээр борлуулалт хийхээр доод тал нь 12 мянга 800-аас эхлээд 32 мянга, 64

мянга гээд борлуулалтуудаа тавиад зарим арилжаанууд амжилттай болоод.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Ийм том асуудал, ийм чухал хуулийг яаралтай горимоор хэлэлцүүлж гэж орж ирж байгаагийн эсрэг байгаа. Хэлэлцэхгүй буцаах саналыг дэвшүүлж байна.

Анх ер нь асуудал яаж босож ирсэн гэхээр Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулаад хил дамнасан төмөр зам байгуулах чухал юм байна. Хэдийгээр манай талд хүнд нөхцөлүүд байсан ч гэсэндээ дэнсэлж үзээд шийдвэр гаргаад хэлэлцээр байгуулсан.

Тэр хэлэлцээрийг хэрэгжүүлэхийн тулд биржийн хуулийн 10.4 дээрх заалт буюу үнийг нь биржээр тогтооно гэдэг нь өөрөө зөрчилтэй учраас хасах шаардлага үүсэж байгаа.

Тэгэхээр үүнийг хасахын тулд яаралтай хэрэгжүүлж байгаа юм уу гэдэг асуулт босож иртэл түүний ард түмэн янзын аягүй том асуудлууд ороод ирж байгаа юм. Эдийн засгаа аврах гээд байгаа ийм санаа байгаа юм уу л гэж харагдаж байгаа.

Одоо бид орлого багаслаа, үнэ уналаа, төсөв хэцүүхэн байна.

Тэгэхээр зэрэг төсөв тодотгох нөхцөл нь үүсээгүй юм гэхэд бид чинь идэвхжүүлэхийн тулд мөнгө хэрэгтэй. Тэгэхээр мөнгөө олохын тулд ерөөсөө энэ төслүүдээсээ буцахгүй ээ. Ямар ч байсан тэр цемент зураад нүхээ гаргаад юмаа хийнэ.

Тэгэхээр бүтээгдэхүүнээрээ бартердъя гэдэг юмыг оруулж ирж байна. Энэ маш том мөнгөний асуудал.

Тэгэхээр зөв, бурууг нь дараа ярьж болно. Энэ ажил хариуцсан Засгийн газрын хүмүүс хэцүү л байгаа байх. Тэгэхдээ энэ чинь биржийн тухай хуульд өөрчлөлт оруулах гээд байгаа гол зорилго нь биш. Том юм орж ирж байгаа учраас яаралтай горимоор хэлэлцэж болохгүй гэж бодож байгаа. Яагаад гэхээр жишээлбэл одоо нөгөө үнэ. Үнийн индекс ойлгомжтой. Худалдаж авчхаад сар болоод хил хүрэх гэсээр байтал үнэ нь уначхаад байхаар хүмүүс орж ирэхгүй байна.

Тэгэхээр тохиргоо хийж болно. Гэхдээ тэр нь буцаж үйлчлээд, одоо мөнгийг нь төлсөн, овоолсон байгаа нүүрсүүд чинь тооцох юм бол хэдэн 100 сая доллар, их наяд төгрөг болно шүү дээ. Тэгээд тэрийг яахаараа бид бүгдээрээ төлөх ёстой юм. Бизнес хийж байгаа эрсдэлээ хүлээсэн хүмүүс.

Татаж аваагүй, төлбөр хийгээгүй дээр нь тодорхой хэмжээний зохицуулалт бас орж болох л байх. Тэгэхдээ тэрийг яаралтай горимоор 10.4-ийн заалттай хамт шийдэж болохгүй гэж үзэж байна. Энэ бол нийт монголчуудын мөнгө төгрөгийн асуудал байгаа.

Тээврийг худалдан авагч тал нь хариуцна, уурхай нүүрсээ цэгцтэй юм шиг. Гэхдээ энэ чинь 2022 оны асуудал руу буцаагаад аваачна. Хил нөхцөлөөр нийлүүлэе гэдэг юм ярьсан. Одоо байхгүй. Буцаад тээвэр. Тээврийг худалдан авагч тал нь хариуцахаар өөрийнхөө тээврийн компанийг л оруулна шүү дээ.

Тэгээд саяын Монголбанкны мэдээг харсан. Гадаад худалдааны алдагдал үйлчилгээний салбарт 1.6 тэрбум байгаагийн 1.3 тэрбум доллар нь тээвэр. Ачаа тээвэр 1.1 тэрбум доллар. Монгол Улс тээврээ хийж чадахгүй байна. Монголын газар нутаг дээрх тээвэр дандаа гадныхан хийж байна. Үүнийг бас анхаарах хэрэгтэй байгаа юм.

4 том OFFTAKE гэрээн дээр саяын “Чайна Энержи” нэмэгдээд 5 болоод үндсэндээ өндөр чанарын коксжих нүүрс бирж дээр бараг арилжаалахгүй үлдэж байгаа.

Тэгэхээр нөгөө биржийн үнэ бага байх нь цаашдаа тодорхой. Тэгээд ийм нөхцөлийг шууд болон шууд бус байдлаар өөрсдөө бүтээчхээд, бий болгочоод бирж ажиллахгүй байна гэдэг нь өөрөө буруу дүгнэлт байхгүй юу. Үнэ унахаар бирж мэдээж гүйлгээ нь багасаж л таараа.

Тэгэхээр энэ асуудал олон ийм төвөгтэй байгаа. Хамгийн гол нь тэр төрийн өмчийн компани бүтээгдэхүүнээрээ солиод. Солих юм чинь хямдхан л өгч таарна. Тэгээд эцсийн дүндээ өөрсдөө хавханд ороод уул уурхай нүүрснийхээ салбарыг тэр чигээр нь унагаах ийм аягүй хүнд нөхцөл байна.

Тийм болохоор хэрэгцээ шаардлагыг нь ойлгож байгаа. Яаралтай горим гэдгийг татгалзах нь зөв. Яагаад яаралтай гээд заавал оруулж ирэх гээд байгаа юм бэ гэдэг асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя.

Энэ 10.4 “Чайна Энержи”-тэй байгуулах Гашуунсухайт-Ганцмодны хэлэлцээрт огт хамаагүй. Сүүлийн үед худалдааны дайн, Трамп тарифын Монголд тусчхаад байгаа сүүдрийг яаралтай арилгах зориулалттай л орж ирж байгаа хууль. Бид хэн ч бай, ямар ч засаг бай орлогоо нэмэгдүүлэх, тасалдуулахгүй байх, ажлын байр8 иргэдийнхээ орлогыг байлгах гэдэг энэ талд л ажиллах байх.

Тэгэхээр үндсэн концепц, зорилго ийм байгаа.

Хоёрдугаарт, 10.3 дугаар заалт дээр бид мэдээж энэ чинь хүн ажил хийж байж, цалин авч байж орлоготой байна. Хаана ажил хийх юм. Бүтээн байгуулалт дээр ажил хийнэ. Бүтээн байгуулалтыг хийхийн тулд бид нарт төсвөөр мөнгө алга.

Тэгэхээр хаанаас олох юм. Бид нарт байгаа баялгаараа бүтээгдэхүүн солилцох замаараа хийе гэдэг ийм л концепц дээр энэ хуулийн юм явж байгаа шүү гэдгийг гишүүнд хэлье.

Мөн одоогийн тэр хилийн цаана гарсан байгаа, гацчихаад байгаа 4.3 сая тонн нүүрсний овоолготой ямар ч хамаагүй. Тэр бол таны хэлснээр зарагдсан нүүрс.

Тэгэнгүүт энэ гэрээний хүрээнд нөгөө компаниуд чинь нэмж биржээр Тавантолгой тээвэр хийгээд аваачаад өгье гэхээр авах талбай байхгүй. Терминал дүүрсэн. 90 гаруй хувь нь дүүрчихсэн.

Хоёрдугаарт, Монголын тээвэрлэлт, нүүрс чинь тэр худалдан авсан компаниудын чингэлгээр буцаж чингэлэг дотор ачигдаж зарагдаж байгаа.

Тэгэхээр нөхдүүд талбай байхгүй гээд чингэлгээ буцааж өгөхгүй байгаа учраас цусны урсгал нь гүйж өгөхгүй энэ гацаа үүсээд байгаа юм. Тэгэхээр энэ хуультай энэ хамаагүй.

Дээрээс нь яаралтай оруулж ирсэн нь үнэхээр яарах нөхцөл байдал үүссэн юм. Засгийн газар дээр Б.Жавхлан сайдаар ахлуулсан экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэг өдөр болгон ажиллаж байгаа.

Энэ хүрээнд ч гэсэн бид нэлээн олон төлөөлөл ороод ажиллаж байгаа. Энэ хүрээндээ бид яарахгүй бол энэ орлого, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалт энэ тэр гээд цаг тулсан маш олон чухал асуудлууд байгаа.

Дээр нь бүтээн байгуулалтын улирал.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Уг хуулийн төслийг хэлэлцэх дэгийн хуулийн хугацаа дууссан. Нэг цагаар сунгасан. Сая хугацаа дууссан учраас дэгийнхээ хуулийг барих нь зүйтэй.

Хуулийн төсөлтэй холбогдуулж урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллаар гишүүд үг хэлэхээр байгаа. Үг хэлнэ. Нэг гишүүн байна. Лхагвасүрэнгийн

Соронзонболд гишүүн. 2 гишүүн байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн үг хэлье. 1 дүгээр индэрт урьж байна. 1 дүгээр индэр энэ голд байна.

Л.Соронзонболд: Энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж байгаа.

Өнөөдөр зах зээлийн нөхцөл байдал, ийм нөхцөлд борлуулалтаа нэмэгдүүлэх зорилгоор энэ хуулийн төслийг оруулж ирж байна гэж үзэж байгаа. Ялангуяа дотооддоо баяжуулах үйлдвэрт нүүрсээ борлуулах боломжийг олгож байгаа нь чухал юм гэж бодож байгаа. Өөрөөр хэлбэл баяжуулсан нүүрсний экспорт нь өөрөө нэгдүгээрт чанар мууддаггүй.

Хоёрдугаарт, борлогдох боломж нь илүү байна гэж харж байгаа юм. Тийм учраас энэ төслийг би дэмжиж байгаа юм.

Нөгөө талдаа анхаарах асуудал юу байна вэ гэхээр олон улсын худалдааны нөхцөлөөр уурхайнхаа амнаас тийм ээ, хилийн талбай дээр, хилийн цаана гээд аль ч нөхцөлөөр ер нь борлуулах боломж байх ёстой.

Тийм учраас энэ хуулийн төсөл дээр орж ирж байгаа нь олон улсын худалдааны нөхцөлөөр борлуулна гэдэг нь зөв гэж үзэж байгаа. Гэхдээ энэ дээр анхаарах асуудал.

Яагаад гэхээр олон улсын худалдааны нөхцөлөөр хэрвээ тухайн гэрээнд заасан бүтээгдэхүүнийг яг тухайн чанараараа тухайн хүн дээр нийлүүлж чадахгүй бол эргээд хариуцлагын асуудал үүсдэг. Энэ дээр маш том хэмжээний торгууль ногдох боломжууд байгаа.

Тийм учраас үүнийг цаашдаа хэрвээ Улсын Их Хурал хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжих юм бол ажлын хэсэг нь анхаарах ёстой байх гэж бодож байна.

Дээрээс нь худалдааны нөхцөлөөр уурхайн амнаас хилийн талбай, хилийн цаана гаргаж байгаа энэ бүхэн дээр үнэ стандарт байх ёстой гэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл зайнаас хамаараад гарч байгаа зайлшгүй стандарт зардлуудаар л үнийн зөрүү гарах ёстой болохоос биш уул уурхайн амнаас авч байгаа нь хэт бага үнэтэй, хилийн саатах нь хэт өндөр үнэтэй ч байдаг юм уу ийм байж болохгүй гэдгийг анхаарах ёстой гэж бодож байгаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ. 1 дүгээр индэрт урьж байна.

Л.Мөнхбаясгалан: Хуулийн төслийг дэмжиж байгаа.

Яагаад дэмжиж байгаа гэдэг олон шалтгаан байгаа. 6.8 сая тонн нүүрс татан авалт нь удаашраад зогссон байгаа. Зах зээлийн үнээс 45 хувиар буурсан гэж байна.

Бид аливаа хуулийг нийгмийн шаардлагаар баталж болно. Тэрийгээ засаж болно. Дэлхийн геополитикийн чиг хандлага, одоо үүсээд байгаа эдийн засгийн нөхцөл байдлаас болоод хуульдаа өөрчлөлт хийж болно.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад эдийн засгийн хохиролтой байдал үүссэн учраас энэ хуулийг яаралтай горимоор оруулж ирж байгаа. Бид хуулийг өөрчилж болно. Тухайн үед нь засаж залруулж болно гэдгийг л маш сайн ойлгох хэрэгтэй байна.

Дотоодын баяжуулах боловсруулах үйлдвэрүүд өнөөдөр түүхий эдээ хэрхэн авах нь ойлгомжгүй болоод энэ хуульд эрх зүйн асуудал нь шийдэгдээгүй учраас хүлээлтийн байдалд орсон, сул зогсож байгаа. Бид өнөөдөр үйлдвэр, технологийн паркийг хийх ёстой гээд Засгийн газраас Улсын Их Хурлаас дэмжлэг гаргаад бодлогоор явуулж байгаа.

Гэтэл нөгөөдүүл нь түүхий эдээ яаж авах нь ойлгомжгүй. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдсан олон үйлдвэрүүд сул зогсож байна.

Дээрээс нь агаарын бохирдлыг шийдэж өгөөч ээ, агаарын бохирдлоос салгаж өгөөч ээ гэж иргэний хүсэлтээр бид сая сонсгол хийсэн. Хүмүүс үүнийг яаралтай шийдвэрлэж өгөхийг хүсэж байна.

Дээрээс нь Монгол Улсад 95 цэцэрлэг, 108 сургууль хэрэгтэй байна. Хэрлэн-Тооно, Орхон-Онги говийн усны төслийг шийдвэрлэхэд 4.6 их наяд төгрөг хэрэгтэй байгаа юм. Энэ мөнгийг хаанаас олох юм. Эх үүсвэр нь хаана байгаа юм. Манай улсын төсөв үүнийг төсвөөрөө хийж чадахгүй.

Гэтэл Улсын Их Хурал өнөөдөр том төслүүдээ явуул гээд батлаад өгчихсөн. Засгийн газарт үүргээ өгсөн. Мөнгийг хаанаас олох вэ.

Тэгэхээр энэ хуулийн 10.3 бартер, бүтээгдэхүүн солилцох энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Бид бололцоотой бүх нөхцөл байдлаараа асуудлыг шийдвэрлээд явах ёстой.

Түүнээс биш энэ хууль нүүрсний хулгайн үед батлагдсан шүү, үгүй мөн их Пи Ар тус болсон шүү. Одоо энэ хууль дээр шаардлагатай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулснаараа хулгайч болохгүй ээ.

Тийм учраас бид өнөөдрийн үүссэн нөхцөл байдлаа хараад эдийн засгийн болон геополитикийн нөхцөл байдлаа хараад Засгийн газарт ажил хийх боломжийг нь олгоод хуулийг дэмжиж өгөхийг хүсэж байна.

Тэгэхээр хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дэмжиж өгөөч ээ гэж эрхэм гишүүдээс хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөж байна. Санал хураалтыг маргааш өглөө үдээс өмнөх чуулганаар санал хураалтаа явуулъя.

Зүгээр яах вэ, ийм байна. Энэ өргөн баригдсан хуулийн төсөл яалт ч байхгүй өндөр ач холбогдолтой зүйл. Зүгээр үүнийг харин хэлэлцүүлгийнхээ шатанд ажлын хэсгээ байгуулаад, гишүүдийн хөндөж байгаа асуудлыг заавал цэгцлэх шаардлагатай. Яаралтай горимоор өргөн баригдсан асуудал.

Гишүүд энд зүгээр эсэргүүцье гэж эсэргүүцэж байгаа зүйл биш. Зарчмын хувьд хэлж байгаа санал гэдэг талаасаа үүнийг бид ярилцах ёстой.

Зүгээр санал хураалтыг харин Засгийн газрын төсөл өргөн барьсан Ц.Туваан сайд байж байна. Б.Жавхлан сайд.

Маргааш өглөө санал хураалтаа явуулах уу, эсвэл ирэх долоо хоногийн бүлгийн хурлууд дээр асуудлуудаа нарийвчилж сайн ярилцаад, ирэх долоо хоногийн дөрөв дэх өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан дээр санал хураалтаа явуулах уу гэдэг сонголт байна.

Маргааш хураах уу? Тэгвэл санал хураалтыг ирэх долоо хоногийн дөрөв дэх өдрийн Пүрэв гарагийн чуулганы нэгдсэн хуралдааны эхэнд явуулна. Тэр хүртэл улс төрийн намууд, бүлгүүд дотооддоо энэ асуудлаа сайтар ярилцах нь зүйтэй гэж үзлээ.

Чуулганы үдээс өмнөх хуралдаан өндөрлөлөө. /алх цохив/

15.00 цагаас үдээс хойших чуулганы хуралдаан эхэлнэ.

Хуралдаан 13 цаг 35 минутад завсарлаж, 15 цаг 02 минутаас үргэлжлэв.

Үдээс хойших нэгдсэн хуралдаан эхлүүлье.

Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сарын 17-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан эхлүүлье. /алх цохив/

Хэлэлцэх асуудал.

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын
сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг
хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан,
анхны хэлэлцүүлэг/**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Гишүүд танхимдаа орж ирье.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлаас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг, Монгол Улсын үндсэн хуулийн холбогдох хэсэг, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Улсын Их Хурал 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.

Мөн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно, 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад төрийн байгууллагад

сонгох сонгогдох эрхтэй гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын 2025 оны 32 дугаар тогтоолыг баталсан.

Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох хэсэгт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, гишүүдэд Б.Батбаатар, О.Номинчимэг, Г.Уянгахишиг, Ө.Шижир нар ажилласан.

Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг буюу Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаар нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй байх агуулгатай хэсгийг хүчингүй болсонд тооцох.

Мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийн Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор зохион байгуулсан уулзалт болон тус хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэсэн зохицуулалтыг хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор зохион байгуулах уулзалтыг аливаа этгээдэд нээлттэй байхаар өөрчлөлтийг тусгасан хуулийн төслийг боловсруулсан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасан ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор эд зүйл тараахыг хориглосон зохицуулалтад ажлын хэвлэмэл тайлан хамаарахаар байна гэж үзэж тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийг хүчингүй болгохоор төсөлд тусгасан болно.

Тус хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтад заасан эд зүйл тараах гэдэгт хийсэн ажлын цахим тайлан хамаарахгүй байна гэж ажлын хэсэг үзсэн болно.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.5-д заасан журмын дагуу боловсруулж, Байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу явууллаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар төслийн 1 дүгээр зүйлийг боловсруулахад ажлын хэсэг өөр хувилбарын талаар ярилцсан эсэх, төсөлд аливаа этгээд гэсэн өөрчлөлт оруулж байгаа нь өмнөх зохицуулалтаас өргөжүүлж, сонгуулийн жил эхэлснээс нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх хүртэл зохион байгуулсан уулзалтыг агуулга, хэлбэрийн хувьд хянаж чадахгүй байх эрсдэл үүсэх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа ажлын хэсгээс боловсруулсан төсөлд аливаа этгээд хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор уулзалт хийх зохицуулалтыг нээлттэй байхаар тусгасан нь зүйтэй талаар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасныг үндэслэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хорооны боловсруулсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүнийг танилцуулъя.

Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна.

Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн алга байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн алга байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Энэ дунд суудлын цэцийн шийдвэрийг хүлээн авахыг тухайн үедээ би бас эсэргүүцэж байсан.

Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 2 гишүүний бүрэн эрх хэзээ эхлэх вэ, хэзээ дуусах вэ. Сонгуулийн дараа тангараг өргөөд дараагийн сонгуулийн дараа дараагийн гишүүн, эсвэл өөрөө тангараг өргөснөөр бүрэн эрхийн хугацаа дуусна гэж байгаа.

Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.26-д Улсын Их Хурлын гишүүн сонгогчдод ажлаа тайлагнаж, үйл ажиллагаагаа мэдээлэх эрхтэй, уулзалтуудыг хийх эрхтэй гэдэг үүднээс аливаа Улсын Их Хурлын гишүүний сонгогч иргэдтэйгээ уулзсан уулзалтыг сонгуулийн үйл ажиллагаанд хамааруулахгүй гэдэг анхны философи байсан.

Ажлын хэсгээс аливаа этгээд гээд нээлттэй болгоод оруулж ирж байгаа нь сонгуулийн сурталчилгааны 18 хоногийг үгүйсгэж байгаатай нэгэн адил байна. Сурталчилгаа ил далд хэлбэрээр бүтэн хагас жил он гарангуут л шууд нээлттэй явахуйц юм шиг харагдаж байна.

Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтуудыг томоор нь эргэж нэг харах хэрэгцээ шаардлага үүсэх нь. Ер нь энэ Сонгуулийн тухай хуулийг дахиж нэг эргэж харахгүй бол яг ийм агуулгын зөрчилтэй зохицуулалт орж ирж байгаа харагдаж байна.

Тэгэхээр аливаа этгээд гэж хэнийг хэлэх вэ? Ажлаа тайлагнана гэхээр ажил төрөлтэй хүнийг хэлэх үү? Иргэдтэй уулзсан уулзалт гэхээр хаана ч очсон тухайн иргэдэд хамааралгүй ажлынхаа тайланг тавина гэсэн үг үү. Энэ одоо яг яана гэсэн үг вэ гэдгийг тайлбарлаж өгөөч.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир: А.Ариунзаяа гишүүний асуултад хариулъя.

44.6-д аливаа этгээд хийсэн ажлын тайлангаа танилцуулахаар зохион байгуулсан уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэж хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг заалттай ингэж орж ирж байгаа.

Одоо Улсын Их Хурлын сонгуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар Их Хурлын гишүүн байна уу, Засгийн газрын гишүүн байна уу, жирийн иргэн байна уу 01 сарын 01 сонгуулийн жил эхэлснээс хойш уулзалт, хурал, чуулган хийх эрх нь нээлттэй байгаа. Одоо ч гэсэн. Одоо мөрдөгдөж байгаа хуулиар.

Та бүхэн анзаарч байгаа бол төрийн өмчийн компаниудын нэр дэвших этгээдүүд 31-нээр ажлаа өгөөд ингээд 01 сарын 01-нээс тойроод явчхаж байгаа шүү дээ. Энэ жилийн сонгууль, ноднин жилийн сонгууль томсгосон тойрог гээд Их Хурлын гишүүд 01 сарын 01-нээс хойш орон нутгуудаар баахан залуучууд аваад л тойроод л танилцуулах уулзалт асуудал яриад л явсан.

Энэ чинь аливаа этгээд хэн ч байсан уулзалт, хурал хийх эрх нь нээлттэй байгаа юм.

Тийм учраас өнөөдрийн цэцийн дүгнэлттэй холбогдуулаад оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлтөөр хориотой байсан зүйлийг нээж өгч байгаа асуудал огтоос байхгүй байгаа юм. Огтоос байхгүй. Бид нарын гол зарчим бол цэцийн дүгнэлтийн гол агуулга Улсын Их Хурлын гишүүн хэвлэл материал тараагаад явах нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй гэдэг нь цэцийн дүгнэлтийн агуулгаар Улсын Их Хурлын гишүүнд давуу байдлыг олгосон байна. Хууль, шүүхийн өмнө бүгд эрх тэгш байна гэдэг зарчмыг хөндсөн байна.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд болохоор тайлан тарааж болоод байдаг. Жирийн иргэд болохоор тайлан тарааж болохгүй. Энэ бол давуу байдлыг олгосон.

Тийм учраас тэр Улсын Их Хурлын гишүүн байна уу, Засгийн газрын гишүүн байна уу, жирийн иргэн байна уу хэн бүхнийг энэ хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хэвлэл материал 01 сарын 01-нээс нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэл хугацаанд хийхийг хориглож байгаа юм.

Засгийн газрын гишүүн гэдгээрээ яамныхаа ажлын тайланг хийгээд, тэр нь дандаа цаанаа төсвийн мөнгөөр тайлангаа хийчхээд давуу байдал өөрсдийгөө сурталчлаад явж байгаа юм. Яг үнэндээ амьдрал дээр. Цэцийн дүгнэлтийн агуулга дээр Улсын Их Хурлын гишүүн ч гэсэн төрийн мөнгөөр, төсвийн мөнгөөр тайлан тараагаад явах бололцоо боломж байна. Ингэж л хэлж байгаа юм.

Тийм учраас бүгдээрээ хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байх ёстой юм бол бүгдээрээ адил гараанаас гаръя. Энэ сонгуулийг аль болох төсөв мөнгө бага зарцуулдаг сонгуулийг хийе гэдэг үүднээсээ тэр уулзалт хурал, ажлаа тайлагнах гээд байгаа бол уулзалт хурал хийх нь нээлттэй.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Ц.Сандаг-Очир гишүүн ээ. Би ажлын тайлан хэвлэж тараахыг болиулахыг дэмжиж байна.

Энэ ер нь буруу. Цаашдаа Сонгуулийн тухай хуулиа өөрчлөхдөө ер нь хүн болгон, эсвэл нэр дэвшигч бүр тайлан сэтгүүл, сурталчилгааны материал

тараахаасаа илүүтэй бусад улс орны жишээгээр уг нь нэгдсэн байдлаар Сонгуулийн ерөнхий хорооноос нэгдсэн байдлаар бэлдээд өгдөг бол сонгуулийн зардал маш ихээр буурна. Энэ дээр би санал нэгдэж байна.

Гагцхүү миний санахын л уулзалт уг нь хориглосон. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд өөрсдөө тайлангийн уулзалтаа хийж байна гэдэг нэрийдлээр нэр дэвших магадлалтай залуучуудыг дагуулж яваад л хууль бус ажиллагаа хийгээд байсныг л санаад байх юм.

Тэгэхээр энэ уулзалтуудыг нээлттэй болгох юм бол сонгуулийн сурталчилгааны 18 хоног гэж хязгаарлах ямар хэрэг байна аа? Үүнийгээ ч гэсэн ер нь зохицуулах ёстой юм биш үү гэдэг л ийм санал байна. Санал гэдэг юм уу, асуулт. Энэ дээр тайлбар байвал.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн нэмэлт хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: Аливаа этгээд гэдгийг асуугаад байна.

Аливаа этгээдэд Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, жирийн иргэн бүгд орно. Яг энэ 44.6 хүчин төгөлдөр мөрдөж байгаа заалтаар Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор хийж байгаа уулзалт нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүн тайлангаа ярьж болно. Бусад нь ярьж болохгүй гээд Их Хурлын гишүүн гэдэг хүнд давуу байдлыг олгосон байгаа юм.

Тийм учраас Цэцийн дүгнэлтийн агуулга чинь ерөөсөө энэ. Тийм учраас бид бүхэн яахаараа Их Хурлын гишүүн ганцаараа тайлан тавих нь сурталчилгаанд хамаарахгүй байдаг юм. Энэ чинь өөрөө давуу байдлыг бий болгоод байгаа юм биш үү гэж үзсэн.

Тийм учраас аливаа этгээд. Аливаа этгээдэд Их Хурлын гишүүн орно, Засгийн газрын гишүүн орно, жирийн иргэн хэн ч байсан орно.

Тийм учраас бүгд нээлттэй хурлаа хийе. Таны түрүүний асуусан Их Хурлын гишүүн хүн 4 жилээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Энэ их сонин юм болоод байгаа юм. Би бас гайхаад л байгаа юм. А.Ариунзаяа гишүүн шиг.

Монгол Улсын иргэн болгон Их Хуралд нэр дэвших эрхтэй. Тэр бол одоо бид Үндсэн хуулиараа олгогдсон. Янз бүрийн шахалт шаардлагагүй, янз бүрийн критеригүй шууд Их Хуралд нэр дэвших ёстой би боддог хүн.

Гэхдээ Улсын Их Хурлын гишүүнийг чинь эргэх холбоотой ажиллаарай гээд ард түмэн сонгоод явуулдаг байхгүй юу. Чи эргэх холбоотой ажиллана шүү. Алга болчховоо гээд. Та нар алга болдог шүү гэж хэлдэг. Тийм ээ.

Тийм учраас Их Хурлын гишүүнийг эргэж тайлангаа тавихыг нь хуулиар зөвшөөрсөн байгаа юм.

Одоо энэ хуулийг ингээд харах юм бол ерөөсөө нэг кино найруулагч нөхөр хийсэн киногоо би энэ ард түмэндээ үзүүлэх гэсэн юм гээд явах юм билээ. Чөлөөтэй. Тэгээд л сая А.Ариунзаяа гишүүний яриад байгаа тэр сонгуулийн 18 хоног ямар ч утгагүй болно. 01 сарын 01-нээс бүх хүмүүс зэрэг янз бүрийн хэлбэртэй тайлан, уулзалтууд хийж эхэлнэ. Тэгвэл ерөөсөө тэр сонгуулийнхаа 18 хоногийг байхгүй болгоод чөлөөтэй болгосон нь дээр юм биш үү. 01 сарын 01-нээс. Бүгдийг нь. Тэр 18 хоног чинь угаасаа утгагүй. Бүх хүмүүс тодорсон, бүх хүмүүс тайлангаа хийсэн хойно л нэг ийм дүр эсгэсэн 18 хоног бий болно.

Тэгэхээр энэ чинь ерөөсөө ийм сонин юм болох гээд байна. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч.

Хоёрдугаарт, нь Орон нутгийн сонгуулийн хуулиар орон нутгийн сонгуулийг чинь айхтар базсан байж байгаа. Их Хурлын сонгуулийг ингээд задгай тавих юм бол энэ нөгөө тэгш байх зарчим чинь яах юм бэ?

Нэг нь айхтар хатуу зарчмаар явдаг. Нөгөөдөх нь задгай 01 сарын 01-нээс хойш хүссэн хүн болгон өрсөлддөг энэ жишиг рүү явах юм уу? Үүнийгээ тэгшитгэхгүй юм уу? Ижилсүүлэхгүй юм уу? Ийм хоёр асуултыг эхлээд асууя.

Энэ хуулийг хийхэд маш их тийм хүндрэлтэй асуудал дагаж үүснэ. Энэ дээр хариулт өгөөч ээ. Ажлын хэсгийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир: Ж.Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Би дахин хэлье. Одоо байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Сонгуулийн хуульд чинь таны тэр яриад байгаа кино найруулагч ч гэсэн киноныхоо тухай яриад явах нь нээлттэй байгаа юм. Хязгаарласан, хориглосон байсан зүйлийг нээж өгөөд байгаа асуудал огт биш шүү.

Та бүхэн хуулийнхаа яг энэ хоёр заалтыг маш сайн уншаарай. Маш сайн уншаарай. Хориотой байгаа зүйлийг нь нээж өгөөд байгаа юм биш. Бүгд хурал уулзалт хийх асуудал нээлттэй. Сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш уулзалт чинь намайг дэмжээрэй. Би дэвшинэ гэж ингэж явах юм.

01 сарын 01-нээс нэр дэвшүүлэх ажиллагаа хүртэлх хугацаанд огт хэн нь ч байсан би нэр дэвших гэж байгаа юм, намайг дэмжээрэй гэж ярьж болохгүй. Тухайн асуудлаар ажлын тайлангаа бүх асуудлаа хурал, уулзалт, тодорхой сэдвээр яриад явах асуудал чинь одоо мөрдөгдөж байгаа хууль дээр чинь хүчин төгөлдөр байгаа шүү.

Тийм учраас энэ хуулийн чинь дагуу энэ хуулийн агуулгыг ойлгосон улсууд өнгөрсөн 2024 оны сонгуулийн жил эхэлснээс хойш, 01 сарын 01-нээс хойш орон нутгаар бүхэл бүтэн тойроод явчихсан шүү дээ. Энэ чинь өөрөө одоо мөрдөгдөж байгаа хуульд нээлттэй байгаа байхгүй юу. Хаалттай байсан юмыг одоо энэ нэмэлт, өөрчлөлтөөр нээж өгч байна гэж ингэж ойлговол энэ буруу ойлголт шүү гишүүд ээ. Та бүхэн үүнийг сайн анзаарч өгөөрэй л гэж би хэлэх гэж байгаа юм.

Орон нутгийн сонгуулийн хууль бол энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй ямар ч хамаагүй учраас тэр нь дараа нь ярина биз.

Яах вэ, ер нь түрүүнд А.Ариунзаяа гишүүн ч гэсэн асууж байсан. 2028 оны Улсын Их Хурлын сонгууль болохтой холбогдуулаад Их Хурлын сонгуулийн тухай хуульд тэртээ тэргүй гар хүрэх байх. Би хүрнэ байх гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ бол өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал цэцийн дүгнэлтийг та бид чинь өөрсдөө бүрэн зүйл, заалтаар нь 4 үндэслэлээр нь хүлээгээд авчихсан байхгүй юу. Нээрээ бид чинь давуу байдал олгосон ийм хууль баталчихсан байсан юм байна гээд өөрсдөө 100 хувь хүлээгээд авсан. Хүлээгээд авчихсан учраас Улсын Их Хурал энэ зөрчлийг арилгах хүрээнд холбогдох хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн хугацаатай энэ хуулийнхаа хүрээнд өнөөдөр асуудал маань орж ирж байгаа юм гэдгийг та бүхэн маань зөв ойлгоорой.

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн тодруулж асууя.

Ж.Алдаржавхлан. Бас тэгж ч тайлбарлаж болно. Нөгөө талаар ч тайлбарлаж болно.

Тэгэхээр манай ажлын хэсэг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах гэж санал оруулж ирж байгаа юм байна. Тэгэхээр хэдүүлээ бас үүнийг дахин сайн ярилцахгүй бол. Миний ярьдаг тэр кино найруулагч зүгээр нэг л жишээ л байгаа юм.

Хэрвээ Их Хурлын гишүүнийг ард түмэн сонгохдоо чи эргэж ирж тайлангаа тавь гэж сонгосон. Тийм ээ. Энэ дээр чинь сонгуулийн бус зорилгоор, санал татах зорилгоор уулзалт зохион байгуулахгүй шүү энэ тэр гэдэг тийм нэмэлт өгүүлбэр нэмж болохгүй юм уу. Энэ чинь тийм бүрхэг заалт байгаа байхгүй юу. Тодорхой бүр тэрийг зааж өгч болохгүй юу?

Энэ нэг тийм бүрхэг заалтаар маш олон юмнууд задгай тавигдаж явах юм байна гэж нэгд харлаа.

Хоёрт нь, Монгол Улсын бүх иргэн сонгуульд нэр дэвших ёстой. Гэхдээ бүгдээрээ нэг ижил гараанаас гардаг байх ёстой гэсэн зарчмаа барих ёстой юм болов уу гэж би бодож байна. Дахиад хэлэхэд энэ асуудал батлагдах юм бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн нэмэлт хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: Та 44.6-гийн заалтыг. Ахиад оруулж ирж байгаа хуулийн заалтыг уншаарай. Энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй л гэж байгаа юм.

Тэгэхээр сонгогчдын санал татах зорилгоор уулзалт. Түрүүн А.Ариунзаяа гишүүн асууж байсан. Ажлын тайлангаа бид чинь 4 жилээр сонгогдсон. Үнэн. Гишүүд хийсэн ажлын тайлан юмаа иргэдэд мэдээлэл өгөх үүрэгтэй. Бүгдийг нь хориглож ч болохгүй. Цэцийн дүгнэлттэй холбогдуулаад.

Тийм учраас Улсын Их Хурлын тухай хууль, Засгийн газрын тухай хууль, нэгжийн тухай хуулиудыг зөрчих юм билээ.

Тийм учраас Та ажлын тайлангаа тайлагнах үүрэг чинь байгаа учраас тэр уулзалт хурлыг чинь нээлттэй болгоод өгье. Гагцхүү тэр хэвлэл материал тарааж болохгүй юм л гэж. Хэвлэл материалын цаана давуу байдал бий байна. Төсвийн мөнгөөр олон арван хуудастай, гоё ганган зурагтай ийм тайлангуудыг хийж тарааж байгаа нь өөрөө тэгш биш байна, шударга биш байна.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье.

Тэгээд 41.9 дээр байгаа энэ заалт чинь жоохон шарааны л заалт байгаад байгаа юм л даа. Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд энэ нь сонгуулийн сурталчилгааны материалд тооцогдохгүй гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр тайлан нь өөрөө сонгуулийн сурталчилгааны материал гэж үзээд байна шүү дээ. Эд гэж үзээд байгаа байхгүй юу. Тэгээд эдийг бид нөгөө 48-аар хориглодог юм шүү дээ. Нэг баахан юм болохгүй, болохгүй гэсэн. Тэгэнгүүт энэ чинь эд юм уу, үгүй юу гэдэг дээр л асуудал үүсээд эд байна. Эд эддээ бүр хэрхэн.

Ер нь жоохон шарааны л юм байдаг юм шүү дээ. Хэрхэн сонгогчдыг саналыг нь худалдаж авсан тухай тайлан байдаг юм шүү. Яс юман дээр. Ингэсэн тэгсэн, тэр нь бараг л тэдэн төгрөг өгсөн, тэрнийг сургуульд оруулсан гээд.

Тэгээд тийм юмаа яг сонгууль болохын өмнө дахиж сануулж сэргээгээд тараагаад байна гэдэг асуудал л яригдаад байгаа шүү дээ.

Тэгэхээр үүнийг нь больё гэсэн ийм л асуулт. Тэгэхдээ бусад этгээдүүдэд бас зөвшөөрөх юм уу? Манай сайд нар Их Хурлын гишүүн биш байхдаа тайлан тараагаад л явж байсан шүү дээ. Сайд хүн байж. Тэр бол иргэдийг төлөөлөөгүй байхгүй юу. Уг нь. Тэгэнгүүт чинь нөгөө гишүүд нь хориглогдож байгаа мөртлөө сайд нарт нь нээлттэй үлдчих юм уу гэдэг асуулт үлдэнэ.

Дахиад бусад иргэд ч гэсэн бас энэ зорилгоор ямарваа нэгэн тайлан, төрийн бус байгууллага, тийм үү ингээд яваад байх юм уу гэдэг асуултууд байгаа учир бүгдийг нь хориглож байгаа.

Тэгэхээр энэ дотор аливаа этгээд гэдэг дотор төрийн бус байгууллага энэ тэрийг бас бид ойлгох ёстой. Тийм үү? Яг ингээд санал татах гэж байгаа юм шиг яваад байгааг нь.

Тэгэхээр энэ чинь жоохон хэцүү болно. Яг санал татах гээд байгаа, үгүйг нь тодорхойлоход жоохон зовлонтой. Яг шүүх дээр очихоор би санал татах гээгүй гээд хэлбэл яах вэ гээд. Тэгээд энэ бол их ярвигтай. Маш ярвигтай. Гэхдээ бид нарт өөр гарц байхгүй. Ямар ч байсан энэ бол маш том дэвшил. Ямар дэвшил вэ гэвэл нэгдүгээрт сонгогчдын саналыг татах ажиллагааг тодорхой хэмжээгээр зогсоож байгаагаараа нэгдүгээрт дэвшил.

Хоёрдугаарт, төрийн хүч, нөөцийг ашиглаж байгаа тэр хэлбэрүүдийг бага ч гэсэн багасгаж байгаа бас нэг давуу тал. Яагаад гэвэл мэдээж тэр тайланг дандаа төсвийн мөнгөөр хийлгэж тарааж байгаа байх.

Тэгэхээр энэ төрийн хүч, нөөцийг ашиглаж байгааг нь болиулж байна. Дээрээс нь давуу байдал, эрх эдлэхийг нь болиулж байна. Тэгээд сонгогчдыг худалдан авсан тухайгаа тайлагнахыг нь хорьж байна. Ийм давуу талтай.

Тэгээд ер нь анзаараад байхад өөрсдөө уулзалт хийх боломжоо авч үлдээд, бусад субъектүүдэд хориглох гээд байгаа байхгүй юу. Бараг ингээд өө ёстой бид нарыг муулаад явна цаадуул чинь гэдэг ийм юм бас цухалзаж байгаа шүү. Тэр тийм шударга бус байж болохгүй шүү дээ. Үгүй одоо Улсын Их Хурлын гишүүдийг муулъя гэвэл хэзээ дуртай цагтаа л муулна шүү дээ. Тэгээд тэр өчүүхэн юмнаас болж бид нарыг яг сонгуулийн өмнө муулаад унана. Ёстой болохгүй гэдэг өчүүхэн үзлээс болж бусад иргэдийн тэр муулах эрхийг нь хааж

болохгүй. Уулзалт хийх тэр боломжийг нь хааж болохгүй. Бүгд тэгш гараанаас эхлэх ёстой.

Тэгэхээр аливаа этгээд гэдгээ тэр төрийн бус байгууллага орж байгаа эсэхийг жоохон бас нэг тодруулж хэлж өгөх хэрэгтэй байх гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Их Хурлын дарга, Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Энэ нэлээн адармаатай ийм асуудал. Гэхдээ бас нэг талдаа их тийм тодорхой ч зүйл байгаа юм л даа. Сонгогчдын сонгох, сонгох эрхийн тухай энд яригдана. Аливаа иргэний сонгох, сонгох эрхийн тухай асуудлууд Сонгуулийн тухай хуулиар улам боловсронгуй болоод л зохицуулагдаад л явж байгаа. Тийм ч байх ёстой гэж байгаа юм.

Саяын одоо бидний энэ Үндсэн хуулийн дүгнэлттэй холбоотой хоёр заалтын нэгийг нь ер нь хүлээгээд авчихъя гэдэг дээр яах вэ бүгд санал нийлж байх шиг байгаа юм. Тэр нь ялангуяа саяын хэвлэмэл материал тараахтай холбоотой асуудлыг.

Тэр нь 41.9. Сая Ж.Баярмаа гишүүний тайлбар хийсэн зүйл.

Энэ 44 дүгээр зүйлийн 44.6 өөрөө бол нэлээн бид нарийн ярьж байж үүнийг ямар хуулийн төсөл хэлбэрээр ямар, хуулийн зохицуулалт, ямар хуулийн томъёололтой орж ирэх вэ гэдгийг яримаар байгаа юм.

Би энэ дээр эхлээд Та бүхэнд зориуд сануулах үүднээс Монгол Улсын Үндсэн хуулийн 23.2-ыг уншиж өгье.

23.2-т Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно гэсэн байгаа юм. Энэ яах вэ, ээлжит сонгууль ч бай, ээлжит бус сонгууль ч бай энэ ямар байдлаар тэр хүн эрх нь эхлэх вэ гэдгийг заачихсан байгаа юм.

Улсын Их Хурлын тухай хуулийн 7.3 дээр гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байна гээд заасан. Өөрөөр хэлбэл хугацааг нь их тодорхой заасан. Хэрвээ ээлжит сонгууль болсон байх юм бол дараагийн сонгууль хүртэл 4 жил энэ хүн эрхтэй байна гэж байгаа юм.

Тэгэхдээ тэр эрх аяндаа үүссэн эрх биш. Энэ бол тухайн Улсын Их Хуралд олгосон чиг үүрэгтэй уялдсан байдлаар бий болсон эрх, үүрэг байгаа юм. Бүрэн эрх.

Тэр бүрэн эрх дотор нь Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.26 дээр сонгогчдод үйл ажиллагаагаа мэдээлэх гэсэн ийм чиг үүргийг нь заагаад өгсөн байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид сонгуулийн жил эхэлсэн ч гэсэн Улсын Их Хурлын гишүүн ажлаа хийж байгаа гэдэг утгаараа уулзалт, хурал зохион байгуулах бүрэн эрхтэй гэж үзэж байгаа.

Сонгуулийн тухай хууль яагаад 44.6-г хийсэн бэ гэдгийг 2011 оны 11 сарын 29-ний өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэл гэрчлээд байгаа байхгүй юу.

Тэр хуралдааны тэмдэглэл дээр яасан гэхээр зэрэг энэ заалтыг яагаад ингэж та нар тухайлан оруулж өгсөн бэ гэсэн чинь тэндээс ямар хариулт гарсан бэ, ямар тайлбар гарсан бэ гэхээр энэ бол ерөөсөө Улсын Их Хурлын гишүүн төлөөлөх эрхтэй. Иргэд, сонгогчдыг. Тэр төлөөлөх эрхээ хэрэгжүүлэх эрхийг нь бид энэ хуулиар зохицуулж өгсөн юм л гэж байгаа юм.

Тэгэхээр энэ угаасаа тодорхой зохицуулалт байгаа юм. Тэгэхээр үүнтэй уялдсан байдлаар Үндсэн хуулийн дүгнэлт бол яг энэ зүйл, заалт бусад сонгуульд нэр дэвших иргэдтэй уялдсан байдлаар тэгш бус байдал үүсгээд байна гэдэг ийм дүгнэлт хийсэн байгаа юм. Үүнийг бид хүлээгээд авсан. Нэгэнт хүлээгээд авсан юм бол одоо үүнийг хэлэлцэж байна гэсэн үг шүү дээ.

Тэгээд хүлээгээд авсан ч гэсэн бид яг саяын байдлаар томьёолж оруулж оруулж ирэх үү, эсвэл өөр байдлаар нэмэлт заалт оруулж ирсэн байдлаар үүнийг томьёолох уу гэдэг ийм бас асуулт гарч ирээд байгаа юм.

Энэ дээр манай ажлын хэсэг яаж Та бүхэн шийдэл бодсон бэ? Шийдлийг жишээ нь ярилцсан бэ гэдэг нэг ийм нэгдүгээр асуулт байна.

Хоёр дахь зүйл. Ц.Сандаг-Очир гишүүн сая тайлбар хийж байна. Мэдээж хэрэг ажлын хэсэг нэлээн нарийн ажилласан байх. Тэртээ тэргүй бусад иргэд чинь уулзалт хийх эрх нь нээлттэй байгаа шүү дээ гэж байгаа байхгүй юу. Угаасаа Сонгуулийн тухай хуулиар. Хэрвээ тийм эрх нээлттэй байсан юм бол яагаад Үндсэн хуулийн цэц дээр маргаан гарсан юм? Яагаад Үндсэн хуулийн цэц энэ дээр дүгнэлт гаргасан юм гэдэг асуудал гарч ирээд байна гэж байгаа юм.

Тэгэхээр тэр эрх бол яг бидний ойлгосон шиг нээлттэй байгаагүй. Улс Улсын Их Хурлын гишүүний хувьд өөрийнхөө чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд,

бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд олгосон ийм эрхийн хүрээний зохицуулалт байсан учраас энэ дээр маргаан үүссэн байгаа юм.

Тэгэхээр тэр хоёр дахь зүйлийг Та бидэнд тайлбарлаж өгөөч ээ гэж байгаа юм. Үнэхээрийн тийм нээлттэй зохицуулалт байгаа юм уу гэдэг.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: С.Зулпхар гишүүний асуултад хариулъя.

Үнэхээр 4 жилийн бүрэн эрхийн хугацаанд ажиллах, ажлын тайлангаа иргэд, сонгогчдодоо тайлагнах нь үүрэгтэй.

Тэр эрхийг чинь хангах үүднээс уулзалт, хурал, цуглаан хийх эрхийг нь нээлттэй болгох үүднээс 44.6-г хүчингүй болгоогүй. Тэр заалт чинь өөрөө зөвхөн Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшихээр уулзалт, хурал цуглаан хийнэ. Энэ нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй гэсэн гэж Их Хурлын гишүүнд давуу байдлыг олгосон байна гэдэг ийм агуулгаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан байхгүй юу. Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшихээр бол энэ уулзалт, хурал цуглаанд хамаарахгүй.

Тийм учраас энэ чинь өөрөө нөгөө талаараа Их Хурлын хууль, Засгийн газрын хууль, нэгжийн хуулиараа Та бүхэн ард иргэддээ хийсэн ажлын тайлан, төр засгийн бодлого, шийдвэрээ танилцуулах эрхийг нь байгаа учраас хүчингүй болгож болохгүй. Энэ эрхийг нь эдлүүлэх үүднээс тэр заалтыг өөрчилж, аливаа этгээдэд хурал, уулзалт цуглаан хийх эрхийг нь нээлттэй байлгаж өгье. Боломжийн байлгаж өгье. Тэр ажлаа тайлагнах гээд байгаа бол тэр уулзалтынхаа хүрээнд ажлаа ярь, танилцуул. Харин хэвлэл материал болохгүй юм гэдэг ийм л агуулгаар.

Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт чинь үндсэндээ агуулга нь Улсын Их Хурлын гишүүн яахаараа уулзалт хийгээд, тэр нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй байгаад байгаа юм бэ? Бүр ингээд үг, өгүүлбэрээр заагаад өгсөн. Тэгээд яах юм. Бусад жирийн иргэд хориотой юм уу. Энэ чинь тэгш байгаа юм уу, шударга байгаа юм уу, жигд гараанаас гарч ирж чадаж байгаа юм уу гэдэг ийм л агуулга байхгүй юу.

Тийм учраас тэр заалт 44.6-г чинь аливаа этгээд гэж өөрчлөөд байгаа нь тэр. Аливаа этгээддээ тэр иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, төрийн өмчийн компани, удирдлага, орон нутгийн удирдлага, Их Хурал, Засгийн газрын гишүүд бүгд орно.

Тийм учраас бүгд сонгуулийн сурталчилгаатай хамаарахгүй асуудлаа ярих нь нээлттэй. Намайг дэмжээрэй. Би дэвших гэж байгаа шүү л гэж ярихгүй бол одоо ч гэсэн мөрдөгдөж байгаа хуулиар бүгд нээлттэй байгаа. Үүнийг

хаалттай байсан юмыг нээж өгөөд байгаа асуудал ерөөсөө байхгүй. Энэ нь өөрөө сонгуулийн сурталчилгааны 18 хоногийг 01 сарын 01 болгож татаад байгаа асуудал ерөөсөө байхгүй шүү. Хэн ч гараад очоод аль ч сумд очоод уулзалт хийх нь нээлттэй. Аль ч гишүүн аль ч тойрог дээр очоод уулзалт хийх нь нээлттэй.

Яагаад гэхээр Их Хурлын сонгуулийнхаа хуулиар, Засгийн газрынхаа хуулиар тэр хуулиудынх нь заалт нь, үүрэг нь байгаа учраас тэр заалтыг чинь хангах үүднээс хүчингүй болгоогүй, бүгдэд адил тэгш эрхтэйгээр нээж өгөөд байгаа юм.

Д.Амарбаясгалан: С.Зулпхар гишүүн тодруулж асууя.

С.Зулпхар: Баярлалаа. Хэлэлцэх нь бидний үүрэг учраас яг ингээд л хэлэлцээд л явах ёстой юм шиг байгаа юм.

Яг нэг зүйл дээр их тодорхой ойлголттой баймаар байна. Бид Үндсэн хуулийн тэр заалт, Улсын Их Хурлын тэр зохицуулалтууд чинь Улсын Их Хурлын гишүүн ажлаа хийж байгаа гээд. Ажлаа хийхийн тулд яаж хийх вэ гэдгийг маш тодорхой заагаад өгсөн. Хугацааны хувьд эрхийг нь заагаад өгсөн байхгүй юу. Тэгээд үүнийг Сонгуулийн тухай хуулиар зохицуулсан юм.

Тэгэхээр миний хэлээд байгаа юм бол энэ бол яг Улсын Их Хурлын өөрийнх нь бүрэн эрхтэй уялдсан байдлаар, хийдэг ажилтай нь уялдсан байдлаар сонгуулийн сурталчилгаа биш байдлаар яаж ажиллах вэ гэдгийг зохицуулсан заалт байхгүй юу. Тэгээд энэ бол Үндсэн хуулийн дүгнэлт гаргахдаа энэ чинь Үндсэн хууль зөрчлөө гэсэн юм.

Тэгэхээр хэрвээ үнэхээрийн бүгдэд нээлттэй байсан бол Үндсэн хуулийн цэцээс ийм дүгнэлт гарахгүй, ийм маргаан ч үүсэхгүй байсан.

Нөгөө нэг зүйл бол бид ажлаа хийхийн төлөө энэ зохицуулсан зохицуулалт илүү боловсронгуй байгаа учраас үүгээрээ явах нь зөв байх л гэсэн саналтай байгаа юм. Гэхдээ яах вэ зохицуулалтыг бид Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн хүрээнд шийд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхбат: Энэ 44.1 гэсэн заалтыг хүчингүй болгож байгаа нь ер нь зөв өө.

Ер нь манай Монголын төр хэвлэмэл материал, бичиг хэргийн зардал дээр маш их зардал гаргадаг юм байна шүү дээ. Одоо ингээд л анзаарч байхад.

Маш олон төрлийн сэтгүүл, маш олон төрлийн хэвлэмэл материалууд гарч ирдэг юм байна.

Тэгээд энэ дээр Их Хурлын гишүүд ч бай, Засгийн газрын гишүүд нь ч бай өөр өөрсдөө давуу байдал олгоод, гоё ганган тайлан, сэтгүүл хэвлүүлээд төсвийн зардлыг нэмэгдүүлээд байгаа энэ асуудлыг хориглож байгаа нь зөв гэж бодож байна.

Зүгээр тэгэхдээ ялангуяа тойргоос сонгогдсон гишүүд тойргийнхоо ард иргэдтэй уулзаж, тайлангаа тавьж, Улсын Их Хурлын танхимд хэлэлцсэн хууль тогтоомжид хэрхэн оролцсон талаар ярьж хэлэх нь зөв л дөө. Үүнийг ганцхан уулзалтууд зохион байгуулаад, түүгээрээ тайлагнаад явах л болж байгаа юм шиг байна.

Урьд дунд нь хэвлүүлж болдог юм уу? Жишээ нь. Гэдэг нэг ийм асуулт байна. Зүгээр хэрвээ хэвлүүлэх дээрээ тулбал. Үүнийг зүгээр яах вэ тодруулаад бас асуучихъя гэж бодсон юм

Хоёрдугаарт, аливаа этгээд гэдэг дээр яг чухам юу юу оров гэдгийг. Сая хэллээ. Тэгэхдээ би дахиад асуучихъя. Аливаа этгээд гэдэг дээр ямар ямар субъектүүд багтаж байгаа вэ? Энэ талаар дэлгэрүүлж хэлж өгөөч ээ гэдэг ийм хоёр зүйлийг асуух байна.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир: Ц.Мөнхбат гишүүнд баярлалаа. Хуулийн төслийг дэмжиж байгаад.

Ер нь 01 сарын 01-нээс, сонгуулийн жилийн 01 сарын 01-нээс өмнө, сонгуулийн жил эхлээгүй 12 сарын 31-нээр тэр эд зүйл тараана уу, тэр мөнгө төгрөг гэдэг юм уу, бусад тайлан бараа материал тараах чинь нээлттэй байгаа шүү дээ. Одоогийн хуулиар.

Сонгуулийн жил эхлээд л 01 сарын 01-нээс хойш Сонгуулийн хууль үйлчлээд эхэлж байгаа.

Тийм учраас эд зүйл тараахыг бүгдэд хориотой байгаа. Харин тэр эд зүйл дотор чинь бас сонин, сэтгүүл ороод байгаа байхгүй юу. Уг нь. Манайхан л хуулийг буруу ашиглаж, гуйвуулж, сайд нар ажлын тайлан гэж тараагаад байгаа болохоос биш уг нь эд зүйл дотор чинь сонгуулийн хорооны. Одоо сонгуулийн хорооны Тамгын дарга энд сууж байна. Бас дээр нь нэмж тайлбар өгөхөд илүүдэхгүй.

Эд зүйл дотор сонин, сэтгүүл орох уу гэвэл орно. Уг нь. 48.1.1-ээрээ эд зүйл дотор.

Тийм учраас сонгуулийн жилийн 01 сарын 01-нээс өмнө тэр тайлан юмаа тарааж болно шүү. Энэ хуулиар хориглоогүй асуудал. 01 сарын 01-нээс хуулийн үйлчлэл үйлчлээд эхэлж байгаа учраас хориотой гэдгийг Ц.Мөнхбат гишүүнд хэлье.

Аливаа этгээд гэдэгт одоо тэгээд бүх төрлийн, бүх салбарын, төрийн, албан тушаалтнууд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн өмчийн компанийн удирдлагууд, ажилтан, хэн байдаг юм бүх иргэн орно. Аливаа этгээдэд. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Амгаланбаатарын Ганбаатар гишүүн асуулт асууя.

А.Ганбаатар: Бараг үг хэлье дээ.

Энэ ардчилсан улсын ардчилсан байлгах гол зүйл бол шударга сонгууль л даа. Тэгээд шударга сонгуулийн чинь гол хэмжүүр бол ерөөсөө л тэгш боломж. Сонгох сонгогдох эрхэд хандаж байгаа, нэр дэвшиж байгаа улсуудын гэдэг юм уу, горилж байгаа хүмүүст тэгш боломжийг олгох л асуудал.

Тэгээд сонгуулийг бүгд мэдэж байгаа. Гараа бариа хоёр л байгаа шүү дээ.

Тэгэхээр гараан дээр нь нэгэнд нь пүүз өмсүүлээд, нөгөөд нь бакал өмсүүлээд уралдуулна гэдэг буруу байхгүй юу.

Тэгэхээр би юу гэж хэлэх гэж байна гэхээр 44.6 “Их Хурлын гишүүн” гэдгээ “аливаа этгээд” гээд сольчихсон байгаа байхгүй юу. Үгээр л. Энэ бол зүгээр л нүглийн нүдийг гурилаар хуурч байгаа байхгүй юу. Аливаа этгээд дотор чинь гишүүн орж байгаа. Гишүүнд заавал давуу байдал үүснэ. Уулзалт хийхэд засаг захиргааныхаа шугамаар бүтцээр хийнэ. Хажууд нь бие даагч яаж явах вэ. Хамуутай даага унасан юм шиг л явна шүү дээ.

Хэрвээ яг тэгш боломж олгох гэж байгаа бол 44.6 байх хэрэггүй. 01 сарын 01-нээс ерөөсөө сурталчилгаа, уулзалтыг хаах ёстой байхгүй юу. Сонгууль хүртэл. Тэгээд л 18 хоногтоо л үз л дээ.

Хэрвээ Их Хурлын гишүүд өөрсдийгөө сурталчлаад байгаа 3.5 жил чинь хангалттай шүү дээ. Тайлан тавиад болоо шүү дээ. 12 сарынхаа 31-нээ дуусгаад хэвлэмэл материал эд нараа овоолоод өгчих.

Тэгэхээр энэ бол ерөөсөө асуудлыг шийдэж байгаа биш харин асуудал ургуулж байгаа асуудал болоод байгаа юм. Тэгээд миний хэлэх гээд байгаа санаа тэглэх зарчмаар үүнийг шийдээч ээ. Тэглэж байж тэгш боломж олгогдоно шүү. Нэгд нь.

Хоёрт нь, сошиалаар өөрсдийгөө сурталчлах боломж байж байна шүү дээ. Зүгээр заавал тэр цаасан материал, эсвэл хөдөө гадаа явж зардал, чирэгдэл болж, уулзалт хийж, олон хүн үймүүлэх ямар хэрэгтэй юм. Одоо энэ шинэ нэр дэвшигч нар байж байна. Жагсаалтынхан байж байна. Дахиад шинээр дэвших хүмүүс байж байна. Энэ хоёр, гурав сонгогдсон хүнтэй уралдах боломж байхгүй шүү дээ. Юу үнэн. Энэ үнэн шүү дээ. Амьдрал дээр бүгд мэдэж байгаа.

Тэгэхээр үнэхээр үүнийг зохицуулах гээд тэгш боломжийг олгох гээд байгаа юм бол 01 сарын 01-нээс уулзалт, хэвлэмэл материал, сурталчилгаа, сошиалаас бусад бүх юмыг хаах хэрэгтэй. Хаана гэдэг нь үг нь зохиж байна уу, үгүй юу? Энэ заалтыг нь аваад хаях хэрэгтэй. Тийм боломж олгохгүй байх хэрэгтэй. Тэгж байж наадах чинь тэгш боломжийг олгосон болно. Сонгогдох, сонгогдох эрхийг хангасан болно. Хувь хүний Үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангасан болно. Үндсэн хуулийн цэцийн гаргасан дүгнэлтийн чинь үндэслэлийг хангахгүй заалт байна гэж хэлж байгаа юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: А.Ганбаатар гишүүний асуултад хариулъя.

Яагаад 44.6-г хүчингүй болгоогүй, 41.9-тэйгөө адилхан хүчингүй болгоогүй юм бэ гэж. Яг түрүүний өмнө гишүүдийн асуусан асуулт дээр бид бол 4 жилийн хугацаанд төр, түмнийг төлөөлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд 4 жилийнхээ хугацаанд ажлаа иргэддээ тайлагнах үүрэгтэй улсууд. Энэ нь Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын тухай хууль, Үндсэн хууль, Засгийн газрын тухай хууль, нэгжийн удирдлагуудтай хамааралтай заалтууд дээрээ бүгд ажлаа тайлагнах үүрэг нь байгаа байхгүй юу.

Тэгэхээр 44.6-г хүчингүй болговол энэ олон хуулийн зөрчлүүд үүсэхээр байгаа юм. Зарим гишүүн бараг бид чинь тэгвэл 3.6 жилийн бүрэн эрхтэй юм уу гэдэг ийм асуудал үүсэх гэж байгаа юм.

Ийм хуулийн зөрчил үүсэх гээд байсан учраас 41.9-ийг хүчингүй болгож 44.6-г аливаа этгээдүүдэд хурал, уулзалт цуглаан, тэр хуулиар олгогдсон ажлаа тайлагнах, мэдээлэх энэ эрхийг нь хангаж өөрчлөн найруулж оруулж ирж байгаа юм. Таны хэлсэнтэй холбогдуулж цахимаар ажлын тайлангаа хийх, танилцуулах асуудал бүх цаг үед нээлттэй байгаа.

Тийм учраас хурал уулзалтыг нь нээлттэй өгч байгаа. Цахимаар ажлын тайлангаа тавих бололцоо боломжийг нь олгож байгаа. Үнэхээр Та иргэд сонгогчдодоо ажлаа тайлагнах гээд байгаа бол цахимаар танилцуул, тайлагна. Уулзалт хурал хийгээд ажлаа тайлагна. Гагцхүү хэвлэмэл материалаар танилцуулж тайлагнаж болохгүй л гэдэг цэцийн дүгнэлтийн гол агуулга энэ байсан. Энэ дүгнэлтийн агуулгад нийцүүлж ажлын хэсэг хуулийн төслөө боловсруулж оруулж ирсэн.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Золжаргал: Ер нь аливаа хязгаарлалт, зохицуулалт, тэгээд замбараагүй байдлыг хянахын тулд л хийгддэг байх л даа. Гэхдээ угаасаа хязгаарлах бараг боломжгүй тиймэрхүү зүйлс байгаа.

Тэгээд хүн хийж байгаа ажлаа, үзэл бодлоо илэрхийлээд мод тарьдаг би ийм гоё мод тарьсан энэ тэр гээд явах нь сонгуулийн жил эхэлсэн учраас энэ хүн нэр дэвшиж магадгүй юм шиг байна гээд хориглох боломж байхгүй. Тэгтэл нөгөө талдаа яг ингээд Их Хурлын гишүүн бол танилцуулж болно гэдэг заалт тавьчхаар ялгасан үндэслэл болж байгаа гэдэг утгаар цэцийн дүгнэлт гарсан юм болов уу гэж.

Тэгэхээр нэгэнт л хатуу ялгаад зохицуулж чадахгүй юм бол тэгш байдлаар оруулж ирж байгаа гээд энэ өөрчлөлтийг агуулгын хувьд дэмжиж байгаа юм.

Нэг асуулт байна. Магадгүй Сонгуулийн ерөнхий хороо руу илүү зохих асуулт юм болов уу. Сонгуулийн тухай хуулийн 48.5 дээр сурталчилгааны явцад дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно гээд. Тэгээд тэр дотроо 45.2 дээр нь зөвшөөрснөөс бусад хугацаанд сурталчилгаа хийхийг хориглоно гэж байгаа юм. Доор нь 5.5 дээр нь болохоор 22.00 цагаас өглөөний 8 хүртэл яригч ашиглахыг хориглоно гээд.

Тэгэхээр энэ 45.8 нь өөрөө угаасаа сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдлийг хориглоно гэсэн.

Тэгэхээр энэ зөвшөөрөгдсөнөөс бусад хугацаа гэдэг нь сурталчилгаанаас тусдаа сар өдрийг ярьж байгаа юм уу, эсвэл цагийг ярьж байгаа юм уу? Цаг бол энэ дотроо бас цаг нь байгаад. Нэг ийм сонирхолтой зөрүүг бид анзаарсан юм.

Хоёрдугаарт нь, хэлэх үг байна. Нэгэнт одоо энэ тэгш оролцооны талаар ярьж байгаа үед Сонгуулийн тухай хууль дээр жишээлбэл нөгөө юу байдаг л даа, “ухуулагч” нар гээд үнэмлэхтэй ухуулагч нар явуулдаг. Бүртгэж аваад. Гол нь тойрог томроод ухуулагч болгон нь цалинтай. Тэгээд тэр чинь нэг их айхтар ухуулаад л хүнд сурталчлаад байгаа юм байхгүй. Өрхийн нэг хүн нь хэдэн төгрөг аваад тэгээд 5, 10 хүний санал баталгаажуулдаг нэг ийм сонин албажсан авлигын шинжтэй болсон шүү дээ. Тэгсэн мөртлөө улс төрийг бид нээлттэй байлгая, сайн дурынхныг оролцуулъя гээд залуучууд ирээд орой ажлаа тарангуутаа 6-аас 8 цаг хүртэл ингээд найзыгаа дэмжээд явъя гэхээр зэрэг болохгүй. Бариад авах юм бол баларна гээд байдаг.

Хандив в цуглуулахад бас 50 мянган төгрөг явуулангуутаа “амжилт хүсье өвгөн” энэ тэр гээд бичихээр асуудалд орчихдог. Цаг нь тулаад маш олон хүн

тэгээд бичихээр бүгдээрэнг нь буцаах барих гээд. Иймэрхүү жижиг юм шиг мөртлөө зохицуулалтууд, сайхан юм бодож хийсэн зохицуулалтууд буцаад нээлттэй байх, улс төр сайн дурын иргэдийн оролцоонд байх гэдэг юмыг хязгаарлаад байгаа юм.

Тэгээд үүнийг бас яг ийм тэгш оролцоог хязгаарласан нөхцөл байна гэж үзэж байгаа. Үүнийг илэрхийлж хэлмээр байна.

Тэгээд асуулт нь түрүүний 48.5-тай холбоотой. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн 10 дугаар микрофон Д.Бат-Эрдэнэ дарга хариулт өгье.

Д.Бат-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ.

Тэгэхээр Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар хязгаарлалт маань хоёр түвшинд байдаг.

Нэгдүгээрт, ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш хийж болохгүй үйлдэл, үйл ажиллагаа юу вэ гэдгийг 48.1 дээр тодорхойлсон. Үүн дотор уулзалт хийх тухай хориглосон зохицуулалт байдаггүй.

Хоёрдугаарт нь, сонгуулийн сурталчилгаа эхэлснээс хойш хязгаарлах хязгаарлалтууд эхэлдэг. Энэ бол сая гишүүний асуултад гарч байна. Өөрөөр хэлэх юм бол нэр дэвшигчийн үнэмлэх олгосноос эхлээд сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлдэг. Энэ үед ямар үйлдэл хийж болохгүй вэ гэдгийг 48.5 дахь хэсгээр хязгаарлаж байгаа. Өөрөөр хэлэх юм бол үүнээс өмнө ямар нэгэн байдлаар сонгуулийн сурталчилгааг хийж болохгүй шүү гэдэг ийм хязгаарлалт байгаа.

48.5.5 дээр байгаа тэр цагийн тухайд зөвхөн шөнийн цагаар чанга яригчийг ашиглаж болохгүй шүү л гэдэг хязгаарлалт. Энэ хугацаанд чанга яригчийн арга хэлбэрийг л ашиглаж болохгүй гэдэг ийм зохицуулалттай байгаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо намын бүлгүүдийг төлөөлж бүлэгт харьяалагддаг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн үг хэлье. 2 дугаар индэр.

О.Номинчимэг: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Тэгээд цэцийн дүгнэлтийг хүлээн авсантай холбоотой ажлын хэсэгт орж ажилласан. Цэцийн маргаан дээр итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд ажиллаад, хоёр долоо хоногийн өмнө бид энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авахдаа ямар үндэслэлээр нь бид хүлээж авах вэ гэдэг дээр тодорхой саналаа хэлсэн.

Гэхдээ Улсын Их Хурал энэ цэцийн дүгнэлтийг 4 үндэслэлээр бүгдээрэнгээр нь хүлээж авсан учраас энэ томьёолол гарч байгаа. Энэ дээр олон гишүүд санал бодлоо хэлж, гарч болзошгүй сөрөг үр дагавар, ялангуяа сонгуулийн сурталчилгааны хугацаа ихсэх, түүнтэй холбогдуулж зардал ихсэх талаар санаа зовниж байгаагаа илэрхийлж байх шиг байна.

Тэгэхээр бид ер нь ардчилсан парламентат ёсоо бэхжүүлэхийн тулд шударга, ил тод, нээлттэй сонгуулийг явуулах нь хамгийн чухал тулгуур.

Тэгээд үүнийг явуулахын тулд мэдээж тэгш боломж бололцоог нээж өгөх ёстой. Үүний төлөө ч гэсэн парламент ажиллана гэдэгт итгэлтэй байгаа. Зүгээр энэ дээр бид сонгуулийн хууль тогтоомжийг зөвхөн энэ цэцийн гарч байгаа дүгнэлтээр хязгаарлахгүй шинэчлэх шаардлага байгаа гэж харж байгаа.

Юун түрүүнд энд яалт ч үгүй улс төрийн сонгуулийн Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуулийн зардлын асуудал, санхүүжилтийн асуудлыг бууруулах тал дээр бид дорвитой өөрчлөлт, тогтолцооны өөрчлөлт хийхгүй бол бид өөрсдийн зорьж байгаа шударга, тэгш боломжийг нээсэн сонгуулийг бүрэн утгаар нь явуулж чадахгүй.

Бид олон тоо баримтыг дурдаж болно. Жил болгон гэхэд улс төрийн намын гаргаж байгаа, эсвэл хувь нэр дэвшигчийн гаргаж байгаа улс төрийн санхүүжилт, намын санхүүжилт, сонгуулийн компанит ажлын санхүүжилт ихсэж байгаа.

Үүнийг бууруулахын тулд дорвитой арга хэмжээ хийхийн тулд бид хоёр юман дээр бас анхаарах ёстой болов уу гэж харж байгаа. Нэгдүгээрт, бид сонгуулиар хөлсөөр ажилладаг сонгуулийн ухуулагч нар ажилладаг. Ухуулагч яг үзэл бодлоороо намын бодлого, хувь улс төрчийн бодлогыг дэмжиж ажиллана гэхээсээ илүү боловсон санал худалдан авах ийм хэрэгсэл болж байгаа.

Үүнтэй холбоотойгоор бас ухуулах байр гээд зөндөө их байгуулдаг. Байрны зардал гээд гардаг. Яг үнэндээ одоо ухуулах байр дээр иргэд ирээд тэнцвэртэй мэдээлэл авна гэхээсээ илүү нам намын л үйл ажиллагаа явдаг ийм тогтолцоо үүсчхээд байгаа.

Тэгээд энэ мэт мэдээжийн харагдаж байгаа зүйлсээсээ бид эхлээд сонгуулийн санхүүжилтийг багасгах асуудал дээр дараа дараагийн хэлэлцүүлэг, Улсын Их Хурал, Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлтүүд хийх явцдаа сая Улсын Их Хурлын гишүүдийн санаа зовниод

байгаа сурталчилгааны хугацаа ихсэх вий дээ, зардал дахиад нэмэгдэх вий дээ гэдэг асуудлыг хамтран хэлэлцэж тогтолцооных нь хүрээнд нь шийдэх ёстой болов уу гэж харж байна.

Ийм сонгуулийн санхүүжилтийг санал худалдан авалтыг багасгахгүйгээр бид тэгш сонгуулийн тухай ярих боломжгүй.

Ерөөсөө мөнгөтэй, бянтай ийм хүмүүс л сонгуульд боломж олгож байгаа боломж нь нээлттэй байгаа. Жирийн иргэд, залуучуудын хувьд оролцох боломжийг нь хязгаарласан заалтууд байгаа. Энэ маань өөрөө дахиад мөнгөтэй, бизнес, ашиг сонирхолтой хүмүүс төрд ороод ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гардаг. Иргэдийнхээ төлөө гэсэн шийдвэр гаргаж чадахгүй байна гэдэг шүүмжлэл дагуулдаг учраас энэ дээрээ Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд анхаарч сонгуулийн хууль тогтоомждоо энэ чиглэлийн шинэчлэлүүдийг хийнэ.

Энэ явцдаа саяын яригдсан асуудлуудыг ч гэсэн дахин авч үзэх ёстой юм гэдэг тал дээр байр сууриа илэрхийлж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэрт урьж байна.

Д.Жаргалсайхан: Үндсэн хуулийн шийдвэрийг хүлээж авах нь зөв. Бидний хувьд нэгэндээ давуу үүсгэж, тараах материал, бусад материалыг илүү ард иргэдэд тарааж, ямар нэгэн байдлаар өөрсдийгөө сурталчлах нь хүний эрх, тэр тусмаа шударга сонгуульд харшилсан зүйл гэдэг дээр бүгдээрээ санал нэгтэй байгаа байх.

Тэгээд ер нь цаашдаа Сонгуулийнхаа тухай хуульд бид бас өөрчлөлт оруулах ёстой.

Ер нь сонгуулийн жил эхэлснээс бусад хугацаанд мөнгө, эд материал тараах асуудал хэвийн гүйцэтгэл болсон. Тэр тусмаа манай албан тушаал хашиж байгаа хүмүүс, тэр тусмаа сайд дарга нар төрийн мөнгөөр, төсвийн мөнгөөр хийж байгаа ажлаа өөрөө өгч байгаа юм шиг мэтээр очиж өгдөг, тууз хайчилдаг. Ер нь л би тойрогтоо ийм юм хийлээ ч гэдэг юм уу.

Тэгээд дээрээс нь эд материал, одоо бүр бараг цагаан сарын бэлэг гээд л янз янзын зүйлүүдийг тарааж байгаа нь энд шударгаар ороод ирсэн, энэ төрийн төлөө иргүй сэтгэлээр зүтгэж байгаа хүмүүст үнэхээр дарамт болж байна. Тойрогтоо ажиллахад эд материал хардаг, гуйдаг, түүдэг ийм асуудлууд үргэлжилсээр байна.

Тийм учраас сонгуулийн тухай хуульд ганцхан сонгуулийн жил эхэлснээс бусад гэж байгаа. Тийм ээ. Бусад жилүүдэд ч гэсэн эд материал тараахыг хориглох саналыг Сонгуулийн тухай хуульд оруулах саналтай байгаа.

Мөн сонгуулийн хугацаанд гэж байгаа. Хугацаанд бидний хувьд Сонгуулийн хорооноос бүр нэг тойрогт хэд 1.4 тэрбум төгрөгийн санхүүг зарцуулж болно гэсэн бүр босгыг тавьж өгч байгаа юм. Тэгээд энэ нь юуг илэрхийлж байна вэ гэхээр мөн О.Номинчимэг гишүүнтэй адилхан бас шударгаар, энэ төрд хоёргүй сэтгэлээр зүтгэж байгаа хүмүүст ийм хэмжээний мөнгө байхгүй.

Тэгэхээр төрд орж ирээд шударгаар ажиллах биш давуу байдал үүсгэсэн, мөн эд материал тараагаад гараад ирсэн хүмүүс төрийг хоёрдуулах, давуу байдал үүсгэх ийм нөхцөл бололцоог бас манай энэ сонгуулийн хуулиар бас дэмжээд байгаа юм шиг ийм утга санаа харагдаж байгаа юм.

Тийм учраас сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж байгаа дээр нэгмөсөн бид бүхэн сонгуулийнхаа хуульд мөнгөний босгыг авах ёстой.

Тийм учраас ингэж байж бид төрийн өрсөлдөөнийг хангахад улс төрийн эр зориг гаргаж, шударга сонгуулийг явуулж байж, бидний төрийн бодлого, шийдвэр цааш цаашдаа хоёргүй сэтгэлээр төрийн өндөр албан хашиж байгаа хүмүүс маань зүтгэдэг болох ийм бололцоо нөхцөл бүрдэх юм гэсэн ийм саналыг илэрхийлж байна. Та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Өлзийхүүгийн Шижир гишүүн үг хэлнэ. 2 дугаар индэрт урьж байна.

Ө.Шижир: Бүгдэд нь өдрийн мэнд.

Хэдийгээр өнөөдөр бид зөвхөн Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийн асуудлыг ярьж байгаа ч гэсэн бид Сонгуулийн тухай хуулийг заавал ярих ёстой.

Яагаад гэвэл Сонгуулийн тухай хуулийн 48.1.1-д өнөөдрийг хүртэл буюу сонгуулийн тухайн жил буюу 2028 оны 01 сарын 01 хүртэл мөнгө эд зүйл тараах, хөнгөлөлттэй үнээр бараа, материал тараах нийтийг хамарсан биеийн тамир, уралдаан тэмцээн зохион байгуулах, түүнийг ивээн тэтгэх гэсэн энэ заалт одоо хүчинтэй байгаа.

Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн дагуу заалтыг тэгш эрхийн зарчмын дагуу хуулийг хүчингүй болгох ёстой.

Яагаад би энэ заалтыг яриад байна вэ гэхээр сүүлийн хоёр сонгуулийн яг бэлэн мөнгөний гаралт дээр тодорхой судалгаа хийж үзсэн. 2019 оны эхний 6

сард гэх юм уу, нийтдээ 156 тэрбум төгрөг бэлэн мөнгө яг арилжааны банкнуудаас бэлэн мөнгө хэлбэрээр гарч байсан бол сонгуулийн жил буюу 2020 онд 268 тэрбум төгрөг болж нэмэгдсэн.

Энэ 268 тэрбум төгрөгийн 88.9 хувь нь зөвхөн сонгуулийн эхний 6 сард гарсан. Үлдсэн 11 хувь нь үлдсэн 6 сард гарсан. Хэрвээ тэгш байсан бол энэ дунджаар 20, 30 тэрбум гарах байсан байх.

Мөн 2024 оны сонгуулийн жилтэй холбоотой, ер нь сонгуулийн ээлжит жилүүдтэй холбоотой улсын төсвийн тэлэл дандаа 20-оос 25 хувь байнга тэлж байдаг. Энэ өөрөө яг зүй тогтол болсон.

Гэтэл 2024 оны эхний 6 сард 2024 онд нийтдээ 302 тэрбум төгрөг бэлэн мөнгө хэлбэрээр арилжааны банкнуудаас гарсан бол эхний 6 сард 284 тэрбум төгрөг буюу нийт бэлэн мөнгөний гаралтын 94.3 хувь зөвхөн сонгуулийн саруудад буюу 7 сарын 01-н хүртэл гарсан байна.

Тэгэхээр энэ бол аливаа сонгууль өөрөө хэт их мөнгөнөөс хамааралтай ийм сонгууль болчихсон байгааг илтгэж байгаа нь тоо баримтууд.

Тэгээд би түрүүн 2017 он маань улс төрийн намуудын санхүүжилтийн тухай ярихад энэ тоонуудыг тухайн үед Монголбанкнаас арилжааны банкуудаас хэдий хэмжээний төгрөг тухайн сонгуулийн жилд бэлэн гарч байна вэ гэдэг. Энд гадаад валютын тухай огт дурдагдаагүй. Энэ зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгт, мөнгөн дэвсгэртээр.

Гэтэл 2020 онд сонгуулийн жил буюу эхний 6 сард гарсан нийт мөнгөн тэмдэгт өөрөө тухайн жилийнхээ бэлэн гарсан мөнгөний 88.9 хувийг эзэлж байна гэдэг бол энэ бол сонгуульд зориулсан мөнгө шүү. 2024 онд 302 тэрбум төгрөг гарсны 288 тэрбум төгрөг зөвхөн сонгуулийн саруудад гарсан нь энэ бас сонгуульд зориулсан мөнгө.

Тийм учраас бид сонгуулийн тухай хуулийн 48.1.1 буюу одоо хүртэл хүчин төгөлдөр байгаа бэлэн мөнгө тараах, эд зүйл тараах, хөнгөлөлттэй үнээр арга хэмжээ зохион байгуулах, гадаад дотоодод аялуулах, урлагийн наадам, түүнийг ивээн тэтгэх гэсэн энэ заалтуудыг бас давхар ярих ёстой.

Би дахиад хэлье. Сонгуулийн жилд нийт гардаг бэлэн мөнгөний эхний 6 сард нийтдээ 88.9-өөс 94 хувь гардаг гэсэн үг. Үлдсэн 6-хан хувь нь үлдсэн 6 сардаа хуваагдаж гардаг бол энэ бүгдээрээ сонгуульд зориулсан мөнгө учраас бид улс төрийн намын санхүүжилтийг ил тод болгох ёстой. Сонгуулийн хандивуудыг бас мөн ил тод болгох ёстой.

Улс төрийн намууд санхүүжилт авах хэрэгтэй ч компаниас хандив авч байгаа бас нэг талаасаа логикийн хувьд ч зарчимгүй. Хувь хүн тухайн нэр

дэвшигчид, тухайн намд хандив өгч болно. Энэ бол тухайн хүний хувь хүний үзэл бодол. Компани ашиг олж бизнесийн орлого олох ёстой болохоос биш хувь хүний үзэл бодлыг илэрхийлэхгүй.

Тийм учраас бид цаашдаа улс төрийн намын сонгуулийн тухай хууль, улс төрийн намын санхүүжилтээр бэлэн мөнгөний хандив гаргалт дээр бас тодорхой хэмжээний заалтуудыг заавал оруулж өгөх ёстой. Ингэж байж бид шударга сонгууль ярина, ингэж байж бид тэгш эрх ярина, ингэж байж бид сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөх ийм хууль руу орно.

Тэгэхгүй бүгдээрээ ярьдаг. Маш их мөнгө гарч байна, маш их сонгуульд гарч байна. Тэгэлгүй яах юм бэ. Энэ чинь нийт 302 тэрбум төгрөгийн чинь 288 тэрбум төгрөг нь зөвхөн сонгуулийн саруудад бэлэн мөнгөөр гараад явчхаар бид үүнийг ямар шударга сонгууль болсон гэж үзэх юм бэ.

Тэгэхээр Та бүхэн энэ дээр анхаараарай. Энэ дээр би дахиад хэлье. Энэ бол зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгт буюу төгрөгөөр гарсан тооцоо шүү. Валютын тооцоо энэ дээр байхгүй байгаа. Валютын тооцоог удахгүй Та бүхэнд гаргаж танилцуулна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг Баасан гарагийн үдээс өмнөх чуулганы хуралдаан дээр явуулна.

Дараагийн асуудалд оръё.

**Гурав.Монгол Улсын шүүхийн тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**
/Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй
холбогдуулан боловсруулсан,
анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Улсын Их Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн тул холбогдох хуулийн төсөл боловсруулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 06 дугаар тогтоолоор хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очиноор ахлуулан, гишүүнээр Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Заяабал, М.Нарантуяа-Нара, Л.Соронзонболд нар ажиллалаа.

Байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу явууллаа.

Ажлын хэсэг уг хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг болон 47.7 дахь хэсгийг хөндөж, шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг төрийн албаны тухай хуульд заасан насны хязгаартай нийцүүлэх хүрээнд 60 гэснийг 65 болгох, тэтгэвэр тогтоохтой холбоотой бусад харилцааг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохицуулахаар тусгасныг Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг, Х.Тэмүүжин нар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэснийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тул цэцийн дүгнэлтийн хүрээ, хязгаарт багтаан хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй талаар асуулт асууж, хариулт авч, байр сууриа илэрхийлсэн болно.

Хууль зүйн байнгын хороо уг хуулийн төслийг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн хүрээ, хязгаарт багтаан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэснийг хасаж, хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэн Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэлээ.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 84.6 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооны боловсруулсан Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа.

Одоо Улсын Их Хурлын гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Пүрэвжавын Сайнзориг гишүүн алга байна. Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

Х.Тэмүүжин: Асуулт гэхээсээ илүүтэйгээр протоколд тэмдэглүүлж үг хэлж байгаа юм.

2025 оны 02 сарын 14-ний 02 Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт байгаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн нэгтгэн дүгнэхэд гээд шийдвэр гаргасан хэсэг байгаа.

Энэ шийдвэр гаргасан хэсэг дээр юу гэж би бичсэн байгаа вэ гэхээр Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гээд хатуу заасан нь шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл буюу 60 нас хүрэх хүртэл нь томилох, энэ томилох зарчмыг алдагдуулсан байна гэж Үндсэн хуулийн цэц үзсэн байгаа юм.

Тэгээд цэцийн энэ дүгнэлтээр шүүгчид 60 насаар тэтгэврийн дээд хязгаар тогтоосныг Үндсэн хууль зөрчсөн гэж ерөөсөө дүгнээгүй.

Харин тэр хүртэл нь ажиллах боломжийг энэ 55 насанд хүрснээр тэтгэвэрт гаргана гээд 30 жил гэдгээр тогтоосныг Үндсэн хуулийн зөрчил гэж үзсэн учраас энэ хүрээнд нь Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар Байнгын хороон дээр ярилцаж, энэ дагуу Шүүхийн тухай хуульд өөрчлөлт орж байгаа юм гэдгийг сануулж хэлж байгаа юм.

Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

Л.Соронзонболд: Гишүүдийн өдрийн мэндийг эрье.

Манай ажлын хэсэг энэ дээр тэр 65 нас гээд тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн бол гэдэг ийм заалтуудыг оруулах санал гаргасан. Байнгын хороон дээр яригдаад Үндсэн хуулийн цэцийн үндсэн асуудал ороогүй учраас гээд бид больсон юм.

Гэхдээ энд нэг анхаарах асуудал байгаа. Яагаад гэхээр бид тухайн салбарын хуулиар хүний тэтгэвэрт гарах насыг, цалингийн асуудлуудыг шийдээд байгаа нь ер нь бидний хувьд анхаарч засах ёстой асуудал юм байна гэж бодож байгаа.

Тийм учраас энэ асуудлыг зориуд энэ асуудлыг хэлэлцэж байгаа үед тэмдэглэн хэлэх гэж асуулт авах цаг авсан юм.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны яг энэ шүүгчдийн тэтгэвэрт гарах настай холбоотой шийдвэрийг би дэмжиж, Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн манаачийн хувьд хууль, хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй ба үүрэгтэй гэдгийг хэлж байна гэж хүлээж авсан.

Гэтэл яг оруулж ирж байгаа энэ ажлын хэсгийн маань дүгнэлт нь яг тэр хуулийн өмнө бүгд тэгш байна гэдгийг дахиад л зөрчсөн мэт харагдаж байна.

Шүүгчээр 30 жил, 30 түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэдгийг хассан.

Үлдээсэн заалт нь өөрөө юу юм бэ гэхээр шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно гэдэг ийм заалт орсон нь ердийн бүх Монгол Улсын иргэнд үйлчилж байгаа Нийгмийн даатгалын тухай хуулиар, Тэтгэврийн тухай хуулиар эрэгтэй 60, эмэгтэй 55 гэсэн заалтыг зөрчиж байгаа буюу шүүгчид хүсвэл өөрсдөө давуу байдал эдэлж 5 жилийн өмнө тэтгэвэртээ гарах боломжийг нь олгож байна. Яагаад?

Шүүгчийн тухай хууль дээр 40.1 дээр шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн таслал, эсхүл шүүгчээр 25 жил ажилласан

бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдөж болно гэсэн заалт хүчин төгөлдөр байгаа.

47.6 дээр яг үүнийгээ дахиад үгүйсгэсэн, хоорондоо зөрчилтэй буюу 55 насанд хүрсэн бол гарч болно гээд бас дахиад энэ хууль чинь өөрөө дотроо дахиад зөрчилтэй болчхож байна.

Жирийн хүмүүс тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн бол 65 насанд гарах эрх нь байна. Төрийн албаны тухай хуулиар ч 65 нас гэж байгаа.

Тэтгэврийн тухай хуулийн 5.1.2 дээр тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25-аас доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэврээ тогтоолгох эрхтэй.

Шүүгчид бүгдээрээ эмэгтэй юм уу? 55-тайдаа гардаг. Нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажилласан тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 50 насанд хүрсэн эрэгтэй, нийтдээ 20-оос доошгүй жил, үүнээс 7 жил хүнд нөхцөлд ажилласан 45 настай эмэгтэй, хүнд, хортой нөхцөлд ажилласан 55 насанд хүрсэн эрэгтэй бас тэтгэврээ тогтоолгох боломжтой.

Яг газрын доор, хүнд нөхцөлд ажилладаггүй шүү дээ. Тэгээд яагаад ингэж давуу байдлыг нь хэвээр нь үлдээв ээ? Энэ уг нь Үндсэн хуулийн цэц маань бүгдээрээ л ижил тэгш байх ёстой. Олон жил шүүгчээр ажилласан туршлага, дадлагыг үгүйсгэсэн, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг 5 жилээр богиносгосон гэж. Уг нь 60-тай гарах эрх нь байгаад байдаг. Гэтэл 55-тай гаргана гэсэн энэ заалт чинь буруу юм гээд дүгнээд ороод ирж байхад яах вэ, яах вэ та өөрөө л хүсэх юм бол 55 гарчих л даа гэдэг ийм давуу байдлыг нь хэвээр нь үлдээв?

Цэргийн тэтгэвэр бол яах вэ энэ чинь тусдаа асуудал. 10 байгууллага байгаа гэж би түрүүн бас хэлж байсан.

Энэ бол төсвийн татаасаар явдаг. Энэ асуудалгүй. Яг энэ шүүгч, прокурор, бусад энэ асуудлууд чинь нийтийн сангаасаа явж байгаа. Бид бүгдийн төлж байгаа шимтгэл энэ сангаас явж байгаа.

Яагаад эдгээр хүмүүс давуу эрхийг эдлэх ёстой юм бэ гэдэг ийм асуулт байна. Тэгээд яах вэ шүүгчид өөрсдөө хүсээд байгаа юм биш, прокурор өөрсдөө хүсээд байгаа юм биш. Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурал дээр ийм шийдвэрийг гаргаад байгаа байхгүй юу. Яагаад? Нөгөө ах намайг бодоорой гэж хэн хэлсэн гэлээ. Иймэрхүү.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: Ерөнхийдөө энэ асуудлаар манай Байнгын хороон дээр яригдсан.

Нэг зарчмын асуудал хөндөгдөж байгаа нь төрийн тусгай албан хаагчдын тэтгэвэрт гарах насны асуудлыг салбар салбарын хуулиар зохицуулж явж байгаа нь өнөөдөр бас зөрчлийг үүсгэж байна. Хууль хоорондын зөрчлийг. Прокурорын хуульд бас ийм. Шүүхийн тухай хуульд, Өмгөөллийн тухай хуульд. Ингээд тэтгэвэрт гарах настай холбоотой харилцааг салбар бүрийн хуулиар зохицуулсан байгаа.

Гэтэл цаана нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтоох тухай ерөнхий хууль чинь байж байна. Хөдөлмөрийн хууль чинь байж байна. Бас төрийн албаны хуулиар байж байна. Төрийн албаны хуулиараа тэтгэвэрт гарах төрийн албаны насны дээд хязгаар 65 гээд заачихсан.

Ингээд ерөнхий хуультайгаа салбарын хуулиуд нь зөрчилтэй байгаа асуудлууд байгаа юм билээ. Эндээс юу харагдаж байна вэ гэхээр цаашдаа энэ тэтгэвэр тогтоолгохтой харилцааг салбарын хуулиудаар зохицуулж явах юм уу, аль эсвэл ерөнхий хуулиа барьж явах юм уу гэдэг нэг том зарчмын асуудлыг бид цаашдаа нэг тийш нь болгох ёстой юм байна лээ гэж үзэж байгаа юм.

Хоёрт, А.Ариунзаяа гишүүний асууж байгаа асуулт маш зөв. Энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт тэр 47.6 дахь заалт чинь хоёр өгүүлбэрээс бүрдэж байгаа.

Хоёр дахь өгүүлбэрийг нь хүчингүй болгож байгаа. Үндсэн хуулийн цэц хоёр дахь өгүүлбэр нь шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулсан байна гэж үзэж тэтгэвэр тогтоолгох насны асуудлыг зөрчсөн байна гэж үзэж дүгнэлт гаргасан.

Манай ажлын хэсэг дээр бас таны ярьж байгаагаар яг одоо энэ Хууль зүйн байнгын хороон дээр яригдаад, ер нь 47.6-г нэг мөр хөндөгдөж байгаа учраас төрийн албаныхаа тухай хуультай нийцүүлээд шүүгчийнх нь тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг нь 65 болгочихъё гэж бид оруулж ирсэн.

Харамсалтай нь Хууль зүйн байнгын хороон дээр энэ ажлын хэсгийн санал маань дэмжигдээгүй юм. Олон жил туршлагатай манай хуульч гишүүд хөндөгдөөгүй заалтыг оруулж ирж байна. Зөвхөн цэцийн дүгнэлтийн хүрээнд хөндөгдсөн асуудал дээрээ нэмэлт, өөрчлөлтөө хий гэдэг ийм асуудлыг Хууль зүйн байнгын хороон дээр яригдсан.

Тийм учраас яг энэ хөндөгдсөн заалтыг нь хүчингүй болгохоор орж ирж байна.

Тийм учраас хоёр дахь өгүүлбэрийг нь хүчингүй болгохоор таны хэлж байгаатай адилхан энэ тэтгэвэрт гарах харилцааны үндсэндээ бараг

харилцаанд 50 хувь нь асуудал нь шийдэгдээд ахиад цаана нь шүүгчтэй холбоотой тэтгэвэрт гарах асуудал бас зөрчил маргаантай үлдэж байгаа нь үнэн.

Тийм учраас үүнийг цаашид ахиж тэр насны дээд хязгаарт нийцүүлэх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулж асууя.

А.Ариунзаяа: Энэ шүүхийн тухай хууль дээрээ хоёр заалт нь хоорондоо зөрчилтэй байна гэж би түрүүн хэллээ шүү дээ. Тийм ээ. Шүүгчид яг үүнийг унших юм бол, хуульчид маань.

40.1 шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эсхүл 25 жил ажилласан бол гэж байгаа байхгүй юу. Энэ бол болж байна. Тэтгэвэрт тогтоолгох насанд хүрсэн гэдэг маань ердийн хуулиараа ч явна, төрийн албаны тухай хуулиараа ч явж болно. Аль алинаар нь ойлгож болно.

Гагцхүү энэ 47.6 чинь бусдаас илүү давуу байдал олгосон байгаад байгаа байхгүй юу. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт чинь тийм байсан шүү дээ. Шүүх энэ шүүхийн хуулиар ердийн хуулиасаа өөрөөр зохицуулсан байна.

Тэгэхээр ажлын хэсгийн унасан саналаар яагаад бид энд санал хурааж болохгүй байгаа юм бэ? Би таны саналыг чинь ажлын хэсгийн анхны тэр унасан саналыг чинь дэмжиж байна. Түүнийг дэмжихийн тулд бид яах ёстой вэ? Энэ орж ирж байгаа заалтыг чинь дэмжихгүй байна.

Тэгэхээр яах ёстой вэ? Гарц гаргалгаа байна уу?

Д.Амарбаясгалан: Ц.Сандаг-Очир гишүүн хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: Хууль зүйн байнгын хороон дээр энэ асуудлыг яриад зарчмын зөрүүтэй саналын томьёолол гараагүй учраас Байнгын хорооны даргын зүгээс анхны хэлэлцүүлгийг эцсийн хэлэлцүүлэгтэй нь хамтатган явуулъя гэдэг ийм горимын санал гараад дэмжигдсэн.

Одоо хэрвээ энэ санал чуулганы хуралдаан дээр дэмжигдэхгүй гэж үзэж байгаа бол одоо цаашдаа хэрхэн яах, дэгээр яаж зохицуулсныг манай Тамгын газар, хуулийн газрынхан тайлбарлана биз.

Ер нь зөрчилтэй асуудал 50 хувь нь шийдэгдээд, 50 хувь нь шийдэгдэхгүй үлдэж байгаа нь үнэн. А.Ариунзаяа сайд аа. Ахиад маргаантай асуудал, шүүгчтэй холбоотой, тэтгэвэрт гарах харилцаа нэг дэх өгүүлбэр дээрээ.

Таны нөгөө давуу байдал олгоод байгаа гэхээсээ илүү харин шүүгчийн 65 нас хүртэл ажиллах бололцоог нь 60 болгоод харин эрхийг нь зөрчөөд байна гэдэг асуудал байгаа шүү.

Тэгэхээр энэ маань өөрөө төрийн албаныхаа хуультай зөрчилтэй асуудал нь нэг талаараа үлдэж байгаа нь үнэн. Үүнийг хэдийгээр нэгмөсөн зохицуулъя гэсэн боловч Хууль зүйн байнгын хороон дээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуулт асууя.

Ш.Бямбасүрэн: Надад нэг ийм асуулт байна.

Тэгээд энэ хоёр туйлын л юм болчихоод байгаа юм л даа. Одоо нэг талдаа бид шүүхийн хараат бус байдлаа хангана гээд шүүгч нарынхаа, өөрөө л өргөдлөө өгөхгүй бол огцордоггүй. Тэгээд ер нь нэлээн их юмыг нь өгсөн. Тэгээд нөгөө талд нь болохоор зүгээр ингээд бусдаас арай илүү наана нь тэтгэвэрт гарах нөхцөлийг нь хуулиараа олгосон байж байгаа. 55, 60 гээд.

Тэгэхээр хоёр дахь хувилбар нь болохоор мэдээж шүүхийн шинэчлэлийн асуудал байгаа. Одоо энэ инновацлаг нөхцөл байдал, орчин үеийн нөхцөл байдал шүүгчдийг өөрчлөх, солих энэ асуудал нь үүгээрээ бүрдэнэ гэсэн хоёр ийм туйлын дунд яваад байх шиг байгаа юм.

Тэгэхээр ажлын хэсэг яг энэ хоёрынхоо ер нь яг аль тал руугаа нь илүү байгаа юм бэ? Ер нь шүүгчдийнхээ хараат бус байдлыг хангана гээд өөрөө тэтгэвэртээ гаръя гэтэл нь суулгаад байх юм уу, эсвэл тодорхой нас зааж өгч шүүхийн шинэчлэлийн асуудал нь илүү чухал гэж үзэж байгаа юм уу гэдэг дээр ямар байр суурьтай байгааг нь асууя.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултад хариулъя.

Ц.Сандаг-Очир: Ш.Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя.

Яах вэ энэ бас бодлогын асуудал байх. Түүнээс ажлын хэсгийн гишүүн, нэг, хоёр гишүүний хувь хүний асуудал байж болохгүй.

Ер нь хууль бүгд тэгш үйлчлэх л ёстой. Шүүх ч байна уу, прокурор байна уу, төрийн албан хаагч байна уу ялгавартай байж болохгүй.

Тийм учраас бид төрийн албандаа төрийн албаны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар нь 65 гэж байгаа бол түүндээ л нийцүүлж холбогдох салбар хуулиуд, тэгээд Хөдөлмөрийн хууль, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоох тухай хууль. Бүгд хуулийнхаа өмнө хуульдаа л бүгдээрээ захирагдаж явах, бүгд л хуулийн өмнө тэгш байх л зарчмыг л барьж байгаа.

Тийм учраас бид ажлын хэсэг дээр ч гэсэн энэ асуудлыг яриад төрийн албаны хуульд нь нийцүүлэе л гэдэг асуудлыг ярьсан боловч Хууль зүйн байнгын хорооны гишүүд маань зөвхөн цэцийн дүгнэлтэд хөндөгдсөн үг, өгүүлбэр дээрээ л асуудлаа ярь. Хөндөгдөөгүй өгүүлбэр дээр та нар асуудал ярьж оруулж ирж буруу жишиг тогтоох гэж байна. Хэрвээ шүүгчийн насны дээд хязгаарыг та нар 65. 60 байгааг чинь цэц буруу байна гэж дүгнээгүй шүү.

Тийм учраас 65 болгох гэж байгаа бол энэ бол тусгай хуулиар, тэр дэгийнхээ тухай хуулиар, хууль тогтоомжийнхоо хуулиар тусгай асуудал болж орж ирэх ёстой юм л гэж Хууль зүйн байнгын хороон дээр хэлэлцсэн учраас бид яг цэцийн дүгнэлтийн хүрээнд хөндөгдөж байгаа хоёр дахь өгүүлбэрийг нь хүчингүй болгохоор өнөөдөр оруулж ирж байгаа юм гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүд нэр ирүүлээгүй байгаа. Санал хураалтыг Баасан гарагийн үдээс өмнөх чуулганы хуралдаан дээр явуулна.

Өнөөдрийн асуудлуудын. Дараагийн асуудалд оръё.

Байнгын хорооны санал, дүгнэлт нь эцэслэн боловсруулагдаагүй байгаа юм байна. Цэцэд хүсэлт гаргах асуудал байгаа.

Тэгэхээр энэ асуудлыг маргааш үдээс өмнөх чуулганаар хэлэлцье.

Ингээд өнөөдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 4 цаг 51 минут үргэлжилж, 16 цаг 18 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД